



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар A/18

Улаанбаатар хот

Г Журам, заавар батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.5 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Гепатитын вирусийн халдвартын тусламж, үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Гепатитын вирусийн халдвартын тандалтын журам"-ыг хоёрдугаар, "Гепатитын вирусийн халдвартын шалтгаант элэгний цирроз, элэгний хавдрын тандалтын журам"-ыг гуравдугаар, "Гепатитын вирусийн халдвартын тусламж, үйлчилгээнд хяналт, үнэлгээ хийх журам"-ыг дөрөвдүгээр, "Гепатитын В вирусийн халдвартын эмнэл зүйн заавар"-ыг тавдугаар, "Гепатитын С вирусийн халдвартын эмнэл зүйн заавар"-ыг зургаадугаар, "Гепатитын D вирусийн халдвартын эмнэл зүйн зааврыг долоодугаар, "Гепатитын B, C, D вирусийн халдвартын илрүүлэг, лабораторийн оношилгоо хийх заавар"-ыг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалаар батлагдсан журам, зааврыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, тушаалын хэрэгжилтийг улсын хэмжээнд мэргэжил аргазүйгээр хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа)-д даалгасугай.

Гурав. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд), Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (А.Өнөржаргал)-т тус тус даалгасугай.

Дөрөв. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/586 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



23

REFERENCES

Эрүүл мэндийн сайдын 2024
оны 01 дугаар сарын 11, өдрийн 18
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ
НЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, тусlamж үйлчилгээг зохион байгуулах, тусlamж үйлчилгээний төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангахад оршино.

1.2. Гепатитын вирусийн халдвартын тусlamж үйлчилгээний удирдлага зохион байгуулалт нь эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны Монгол Улсын стандартууд, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан "Эмнэлгийн мэргэшсэн тусlamж, үйлчилгээ үзүүлэх жагсаалт, журам", "Сум, тосгоны эрүүл мэндийн төвд тусlamж, үйлчилгээ үзүүлэх журам, жагсаалт", "Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусlamж, үйлчилгээний жагсаалт" болон бусад тусlamж үйлчилгээний зохицуулалтын чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тушаал шийдвэрийг тус тус мөрдлөг болгон үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангана.

1.3. Гепатитын вирусийн халдвартыг 2030 онд таслан зогсоох Дэлхийн эрүүл мэндийн стратеги, Монгол Улсын гепатитын вирусийн халдвартын тусlamж үйлчилгээний стратегийн хүрээнд дараах үр дүнд хүрэхэд бүх шатны эрүүл мэндийн байгууллага тусlamж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй зохион байгуулж, халдвараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1.3.1. Гепатитын вирусийн халдвартыг илрүүлэх, тархалтыг хязгаарлахад хүн амыг эрт илрүүлэгт хамруулж, халдвартын тархалтыг тогтоож, халдвартай иргэдийн 90 хувийг илрүүлсэн байх;

1.3.2. Гепатитын В, С вирусийн халдвартын шинэ тохиолдлыг 90 хувиар бууруулах;

1.3.3. Эхээс хүүхдэд гепатитын вирусийн халдвартай дамжихыг таслан зогсоох;

1.3.4. Гепатитын вирусийн халдвартай иргэдийн 80-аас доошгүй хувийг оношилгоо шинжилгээнд хамруулж, оношийг баталгаажуулсан байх;

1.3.5. Гепатитын вирусийн халдвартай хүнд өвчний үе шатанд тохирох эмчилгээг нэн даруй эхлүүлж, эмчилгээ шаардлагатай халдвартай иргэдийн 80 хувьд эмчилгээг эхлүүлсэн байх;

1.3.6. Эмчилгээний үр дүнг тооцох: Гепатитын С вирусийн халдвартын голомтыг таслан зогсоох, гепатитын В вирусийн халдвартыг хяналтад авч, халдвартай иргэдийн 80 хувийг эмчилгээнд хамруулж, хяналтад авсан байх;

1.3.7. Элэгний цирроз, элэгний хорт хавдрыг хянах, сэргийлэх: Гепатитын вирусийн халдвартай хүнд элэгний цирроз, элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, хяналтад авч, түүний шалтгаант нас баралтыг 65 хувь бууруулах.

ХОЁР ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ЗАРЧИМ, ТӨРӨЛ, ХЭЛБЭР

2.1. Гепатитын вирусийн халдварын тусlamж үйлчилгээ нь дараах зарчимд тулгуурлана. Үүнд:

- Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээ, тэдний сонголтод тулгуурласан;
- Үйлчлүүлэгчийг сонсох, итгэлцлийг бий болгох харилцаа хандлагатай;
- Ялгаварлан гадуурхалтаас ангид байж хүний эрхийг дээдэлсэн;
- Санхүүгийн дарамт учруулахгүй, ил тод, ойлгомжтой зохицуулалттай;
- Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог хангасан;
- Салбар дундын үр дүнтэй хамтын ажиллагаанд тусгурласан байх.

2.2. Гепатитын вирусийн халдварын тусlamж үйлчилгээ нь дараах үнэт зүйлсийг эрхэмлэнэ:

- Эрүүл мэндээ хамгаалуулах тэгш эрх;
- Олон нийтийн аюулгүй байдал;
- Эв нэгдэл, харилцан ойлголцол, хүндлэл;
- Хувь хүний нууцыг хадгалах.

2.3. Гепатитын вирусийн халдварын тусlamж үйлчилгээнд дэмжлэг үзүүлж оролцож буй төрийн болон төрийн бус байгууллагын эрүүл мэнд, сайн дурын ажилтан, судлаач нар нь дээрх зарчмыг адил мөрдөж үйлчлүүлэгчийн хүний эрхийг дээдлэн ажиллана.

2.4. Гепатитын вирусын халдварын тусlamж үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд нь нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлнэ:

2.4.1. Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ:

- Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа
- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг
- Дархлаажуулалт
- Тандалт, хавьталь судлал, судалгаа
- Эрсдэлт бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа

2.4.2. Эмнэлгийн тусlamж үйлчилгээ:

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусlamж, үйлчилгээ	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв
Амбулаторийн оношилгоо, хяналт Хавьталь судлал Жирэмсний хяналт Өдрийн эмчилгээ Мобайл эрүүл мэндийн үйлчилгээ Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг	Амбулаторийн тусlamж, үйлчилгээ Хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээ Хөнгөвчлөх эмчилгээ Өдрийн эмчилгээ Явуулын амбулаторийн үйлчилгээ Алсын дуудлага, яаралтай тусlamж Телемедицинний зөвлөгөө	Амбулаторийн тусlamж, үйлчилгээ Хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээ Өдрийн эмчилгээ Алсын дуудлага, яаралтай тусlamж Телемедицинний зөвлөгөө

Ойрын болон алсын түргэн тусlamжийн үйлчилгээ Гэрийн эргэлт, хөнгөвчлөх эмчилгээ		
-------------------------------------------------------------------------------------	--	--

2.5. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний зураглал гаргаж, тасралтгүй байдлыг хангаж ажиллана. Эрүүл мэндийн байгууллага нь гепатитын вирусийн халдвартыг илрүүлэх, элэгний эмгэгийг оношлох, эмчлэх, хянах эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг цогц байдлаар хүргэнэ. Хүн ам эрүүл мэндийн цогц тусlamж үйлчилгээнд тасралтгүй тууштай хамрагдсанаар гепатитын вирусийн халдварт, элэгний эмгэгийг эрт оношилж, эмчлэн хянаж, элэгний цирроз, элэгний хорт хавдраар хүндрэх, нас барах эрсдэлээс сэргийлнэ.

ГУРАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ

3.1. Халдварт өвчин судлалын үндэсний төв

3.1.1. Гепатитын вирусийн халдвартын тусlamж үйлчилгээний чиглэлээр стратеги, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хянах, үр дүнг тооцон сайжруулах ажлыг зохион байгуулж, улсын хэмжээнд мэргэжил арга зүй, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

3.1.2. Нийгмийн эрүүл мэндийн болон төрөлжсөн мэргэшлийн, лавлагаа шатлалын эмнэлгийн тусlamж үйлчилгээг үндэсний хэмжээнд үзүүлж, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр тасралтгүй хангана.

3.1.3. Гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд бодлогын түвшинд шийдвэрлэх асуудлыг тодорхойлж шийдвэр гаргагч наарт танилцуулан, ухуулга нөлөөллийн арга хэмжээ авч ажиллана.

3.1.4. Гепатитын вирусийн халдвартын тандалт, тусlamж, үйлчилгээнд мөрдөх журам, заавар, түгээмэл үйлдлийн стандарт, эмнэл зүйн зааврыг эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг холбоодтой хамтран боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавина.

3.1.5. Гепатитын вирусийн халдвартын тандалтыг улсын хэмжээнд хариуцан ажиллах тандалтын бүтэцтэй байна. Тандалтын нэгж нь гадны улс орон, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж хамтарсан судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хийж, хүний нөөцийг сургаж бэлтгэнэ.

3.1.6. Гепатитын вирусийн халдвартын тохиолдол, эрсдэлт хүчин зүйл, сэргийлэх арга хэмжээний үр дүн, гепатитын вирусийн халдвартын шалтгаант өвчлөл, нас барагт, эмчилгээний үр дүнд тандалт, судалгаа хийж нотолгоонд сууринсан арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.

3.1.7. Гепатитын вирусийн халдвартыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, хяналтад авах тусlamж үйлчилгээний зураглал (каскад)-ыг гаргаж, тусlamж үйлчилгээг цогц байдлаар үзүүлэхэд тулгарч буй асуудлыг илрүүлж, арга хэмжээ авч ажиллана.

3.1.8. Гепатитын вирусийн халдварт дэгдэлт байдлаар бүртгэгдсэн тохиолдолд тархвар судалгаа хийж, шалтгааныг тогтоон, хариу арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлнэ.

3.1.9. Аймаг, нийслэл, эрүүл мэндийн байгууллагын тандалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэдээ, тайлангийн үнэн бодит, бүрэн гүйцэд, цаг хугацаандаа ирүүлсэн байдалд үнэлгээ өгч ажиллана.

3.1.10. Тандалтын мэдээллийг цахимжуулж бүртгэл мэдээллийг сайжруулах арга хэмжээ авна.

3.1.11. Гепатитын вирусийн халдварыг оношлох лабораторийн үйл ажиллагаанд гадаад чанарын хяналтыг улсын хэмжээнд тогтмол хийнэ.

3.1.12. Лабораторийн шинжилгээний гүйцэтгэлийн мэдээллийг дүгнэж, нотолгоонд суурилсан арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.

3.1.13. Гепатитын вирусийн халдварын эмнэлгийн тусlamж, үйлчилгээг дуудлагаар болон телемедицинээр зөвлөгөө өгөх, цахим зөвлөгөөнийг зохион байгуулан мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

3.1.14. Тусlamж үйлчилгээний хяналт шинжилгээ, үнэлгээг эрүүл мэндийн байгууллагуудад хийж, тайлан мэдээнд нь үнэлгээ дүгнэлт өгч ажиллана.

3.1.15. Үндэсний хэмжээнд зөвлөлдөх уулзалт, зөвлөгөөн, сургалт, семинар, эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулах тасралтгүй сургалт болон төгсөлтийн дараах мэргэшлийн сургалтыг зохион байгуулна.

3.1.16. Гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, тусlamж үйлчилгээг сайжруулахад олон нийтийн оролцоог хангана.

3.1.17. Бодлого, шийдвэр гаргагчдын дэмжих бүлэг, хэвлэл мэдээллийн төлөөлөл, териин бус байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, өвчтөний дэмжих бүлэгтэй зөвшилцлийг бий болгох замаар олон талт харилцааг бэхжүүлнэ.

3.1.18. “Гепатиттай тэмцэх дэлхийн өдөр”-ийг тэмдэглэн, гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, түүний үр дагавар, эрсдэлийн чиглэлээр иргэд, олон нийтэд зөв мэдээлэл өгөх, мэдээллийг хүргэх үр дүнтэй арга хэрэгслийг сонгон зөвлөгөө санамж, сургалт, сурталчилгаа тогтмол хийнэ.

3.1.19. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхэд “Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү, гепатитын В вирусийн халдвар дамжихыг таслан зогсоох” зааврын хэрэгжилтийг хангуулж ажиллана.

3.2. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Хүн амыг гепатитын вирусийн халдвараас сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх, мэдлэг олгох, эрсдэлийг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа хийх, хэрэгцээг тодорхойлох бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

3.2.1. Хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг үр дүнтэй явуулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллага, сайн дурын идэвхитэнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

3.2.2. Гепатитын вирусийн халдвартай чиглэлээр иргэдийн мэдлэг, зан үйл, мэдээлэл хүлээн авч буй байдал, мэдээллийн хэрэгцээг тодорхойлох, эрсдэлийн судалгаа тодорхой давтамжтай хийж, нотолгоонд суурилсан дүгнэлт, санал, зөвлөмж гаргана.

3.2.3. Гепатитын вирусийн халдвартай чиглэлээр иргэдээс сэргийлэх мэдлэг, хандлага, дадал зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдах ач холбогдлын талаар иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг тасралтгүй зохион байгуулна.

3.2.4. Гепатитын вирусийн халдвартай эрсдэлт бүлгийн иргэдэд эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд хамрагдах талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулна.

3.2.5. Гепатитын вирусийн халдвартай тусламж, үйлчилгээний журам, зааврыг хэрэгжүүлэхэд харьяа байгууллагуудыг мэргэжил арга зүй, удирдлагаар ханган ажиллана.

3.2.6. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхэд “Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү, гепатитын В вирусийн халвар дамжихыг таслан зогсоох” зааврыг таниулан сурталчилна.

3.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

3.3.1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа стратеги, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.3.2. Гепатитын вирусийн халдвартай чиглэлээр иргэдээс, оношилгоо, эмчилгээ, сорьц тээвэрлэлт, халдвартай хяналтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалт, сурталчилгаанд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжилтэд хяналт тавина.

3.3.3. Хүн амын дунд гепатитын вирусийн халдвартай тархалтыг бууруулах, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй чанартай үзүүлэхэд орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

3.3.4. Гепатитын вирусийн халдвартай чиглэлээр иргэдээс, оношилгоо, эмчилгээ, сорьц тээвэрлэлт, халдвартай хяналтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалт, сурталчилгаанд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжилтэд хяналт тавина.

3.3.5. Гепатитын вирусийн халдвартай чиглэлээр иргэдээс, оношилгоо, эмчилгээ, сорьц тээвэрлэлт, халдвартай хяналтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалт, сурталчилгаанд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжилтэд хамтран ажиллана.

хугацаанд нь бүрэн гүйцэт өгч, харьяа байгууллагуудын тандалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

3.3.6. Тандалтын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын шийдвэр гаргагч нар, эрүүл мэндийн анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг эргэн мэдээлнэ.

3.3.7. Эмч, эмнэлгийн мэргэжилтэнг гепатитын вирусийн халдвартын чиглэлээр мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад хамруулах, хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах тогтвортой суурьшилтай ажиллуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

3.3.8. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн ажилтанг сургах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

3.3.9. Сум, өрхийн эрүүл мэндийн төв, харьяа эрүүл мэндийн байгууллагуудын гепатитын вирусийн халдвартын үед үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд хяналт тавьж ажиллана.

3.3.10. Сум, өрхийн эрүүл мэндийн төв, эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран гепатитын вирусийн халдвартын илрүүлэг, үзлэг, хяналтыг зохион байгуулна

3.3.11. Хүн амд гепатитын вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, орон нутгийн хэвлэл мэдээлэл, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.

3.1.20. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхэд “Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү, гепатитын В вирусийн халдварт дамжихыг таслан зогсоох” зааврыг мөрдөн, тусламж үйлчилгээ үзүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.

3.1.21. Үйлчлүүлэгчдэд иргэний эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой заалтыг танилцуулсан байна.

3.4. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төв

3.4.1. Гепатитын асуудлыг хариуцсан эмч, мэргэжилтэн (мэргэшлийн эмч, сувилагч, статистик / дүн бүртгэгч)-ий орон тооны бус нэгж байгуулна.

3.4.2. Гепатитын вирусийн халдвартын оношилгоо, эмчилгээнд шаардагдах тоног төхөөрөмж, эм, урвалж оношуулж, бусад хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлнэ. Ханган нийлүүлэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

3.4.3. Гепатитын вирусийн халдвартай, өвчний улмаас эмнэлэгт хандаж байгаа иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй чанартай, хүртээмжтэй үзүүлж, үйлчлүүлэгчийн үүрэг хариуцлагын талаар мэдээлллийг хүргэнэ.

3.4.4. Харьяа хүн амын дунд гепатитын вирусийн халдвартыг эрт илрүүлэх, хяналтад авах, эрсдэлт бүлэгт чиглэсэн үзлэг, шинжилгээг тодорхой давтамжтай зохион байгуулна.

3.4.5. Вирусийн эсрэг эмчилгээг эмнэл зүйн зааврын дагуу хийж, эмчилгээний явцыг хянаж, шаардлагатай үед хөдөлмөр зохицуулалтын асуудлыг

шийдвэрлэнэ. Гепатитын вирусийн халдварын тусlamж үйлчилгээ, тандалтад ажиллаж байгаа эмч, эмнэлгийн

3.4.6. Мэргэжилтэнг мэргэжил олгох, дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамруулах, хүний нөөцийг тогтвортой суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.

3.4.7. Гепатитын вирусийн халдварын тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Тандалтын мэдээ, тайланг цаас болон цахим хэлбэрээр аймаг, нийслэлийн ЭМГ, ХӨСҮТ-д мэдээлнэ.

3.4.8. Гепатитын вирусийн цочмог халдварын тохиолдолд тархвар судалгаа хийж, хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.4.9. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхэд “Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү, гепатитын В вирусийн халдвар дамжихыг таслан зогсоох” зааврыг мөрдөн, тусlamж үйлчилгээ үзүүлнэ.

3.4.10. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэхдээ халдварын сэргийлэлт хяналт, аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөн, дотоод хяналт тавьж ажиллана.

3.4.11. Үйлчлүүлэгчдэд иргэний эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой заалтыг танилцуулсан байна.

3.5. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв

3.5.1. “Гепатитын вирусийн халдвартай сум, өрх, хороо” болох уриан дор олон нийтийг татан оролцуулж, хамтран ажиллана.

3.5.2. Гепатитын вирусийн халдварын тохиолдлыг илрүүлэн, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, эрүүл мэндийн төвд онош баталгаажуулахаар илгээнэ.

3.5.3. Гепатитын вирусийн халдварт өртөх эрсдэлт бүлгийн хүн амын судалгаа гаргаж, идэвхтэй илрүүлгийг зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.5.4. Гепатитын вирусийн халдварын тохиолдолд тандалт судалгаа хийж, анхан шатны бүртгэл маягтыг хөтөлж, цаас болон цахим хэлбэрээр харьяа удирдах байгууллагад холбогдох журмын дагуу хугацаанд нь мэдээлнэ.

3.5.5. Хүн амын дунд гепатитын вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна.

3.5.6. Цахим бүртгэл, тандалтын бүртгэл мэдээллийг байгууллагын хэмжээнд мөрдөж ажиллана.

3.5.7. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь гепатитын вирусийн халдварын тохиолдлын мэдээллийг нэгтгэн, аймагт эрүүл мэндийн газар, дүүрэгт эрүүл мэндийн төвд мэдээлнэ.

3.5.8. Гепатитын вирусийн халдварын тандалтын бүртгэл мэдээллийн үнэн бодит, бүрэн гүйцэт, цаг хугацаандаа мэдээлэх байдлыг ханган ажиллана.

3.5.9. Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн тандалтын тайлан, эргэн мэдээлэл, зөвлөмжийг тухай бүр хэлэлцэн, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

3.5.10. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхэд “Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү, гепатитын В вирусийн халдвар дамжихыг таслан зогсоох” зааврыг мөрдөн, тусlamж үйлчилгээ үзүүлнэ.

3.5.11. Үйлчлүүлэгчдэд иргэний эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой заалтыг танилцуулсан байна.

3.6. Амаржих газар, эх барихын тусlamж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага

3.6.1. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхэд “Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү, гепатитын В вирусийн халдвар дамжихыг таслан зогсоох” зааврыг мөрдөн, тусlamж үйлчилгээ үзүүлнэ.

3.6.2. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхийг анхан болон лавлагаа шатлалын тусlamж үйлчилгээний эмч наrtай хамтран хянана. Халдвартай эхээс төрсөн хүүхдийг халдвараас сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ.

3.6.3. Жирэмсэн эхийн солилцох хуудас, эрүүл мэндийн дэвтэрт гепатитын В, С, D вирусийн илрүүлэг шинжилгээнд хамрагдсан эсэх, хамрагдсан бол шинжилгээний хариуг тэмдэглэсэн эсэхийг шалгаж авна. Жирэмсний хяналтын хугацаанд илрүүлэг шинжилгээнд хамрагдаагүй эсхүл тэмдэглэгээ байхгүй бол жирэмсний хяналтын эмчид мэдээлж, HBsAg, anti-HCV илрүүлэх түргэвчилсэн тестээр илрүүлэг шинжилгээ хийнэ.

3.6.4. Төрөлт удирдах эмч, мэргэжилтэн гепатитын В, С, D вирусийн архаг халдвартай эх жирэмсний хугацаанд вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан эсэх мэдээллийг хяналтын эмчээс авна.

3.6.5. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхээс төрсөн нярайд төрсний дараа 12 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг вакциныг, В вирусийн эсрэг иммуноглобулины хамт дархлаажуулалтын сувилагч нярайн эмчийн дүгнэлтийг үндэслэн хийнэ.

3.6.6. Вакцин, иммуноглобулин хийсэн тухай эрүүл мэндийн дэвтэрт заавал тэмдэглэх ба хийгээгүй тохиолдолд шалтгааныг нь тодорхой бичнэ.

3.6.7. Гепатитын В вирусийн архаг халдвартай эх төрөх үед нярайн арьс салст гэмтэх, шалбарах зэрэг халдвар авах эрсдэлт хүчин зүйл үүссэн бол төрөлтийн болон нярайн түүхэнд тэмдэглэнэ. Халдвараас сэргийлж вакцин, иммуноглобулиныг зааврын дагуу, цаг хугацаанд нь тарихыг дархлаажуулалтын сувилагчид төрөлт удирдсан мэргэжилтэн мэдээлж, хэрэгжилтийг хянана.

3.6.8. Амаржих газрын тархвар судлаач нь вакцин, иммуноглобулины төлөвлөлт, захиалга, хадгалалт, зарцуулалт, аюулгүй тарилга, дархлаажуулалтын заавар журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.6.9. Үйлчлүүлэгчдэд иргэний эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой заалтыг танилцуулсан байна.

3.7. Төр, хувийн хэвшлийн бусад эрүүл мэндийн байгууллага

3.7.1. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд идэвхи санаачлагатай оролцож үйлчлүүлэгчдийн дунд гепатитын вирусийн халдварт илрүүлэх үзлэг, шинжилгээ хийж, шинээр оношлогдож байгаа тохиолдлыг бүртгэн, ХӨСҮТ-д мэдээлж, лавлагаа лабораториид сорьц илгээн оношийг баталгаажуулна.

3.7.2. Гепатитын вирусийн халдвартын тусламж, үйлчилгээ үзүүлдэг төв эмнэлгүүд, тусгай зөвшөөрөл бүхий хувийн эмнэлэг нь бодлогын журам, заавар боловсруулах, хүний нөөцийг сургаж бэлтгэх, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийхэд ХӨСҮТ-тэй хамтран ажиллана.

3.7.3. Өвчтөнд гепатитын вирусийн халдвартын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа улс, хувийн хэвшлийн бүх эмнэлгүүд вирусийн эсрэг эмчилгээний шууд хяналт, тасралтгүй байдлыг ханган ажиллана.

3.7.4. Гепатитын вирусийн халдвартын тандалтын мэдээллийг харьяа эрүүл мэндийн байгууллагад цаг тухайд нь гаргаж илгээнэ. Цочмог халдвартын тохиолдолд тархвар судалгаа хийж, мэдээлж, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцож ажиллана.

3.7.5. Гепатитын вирусийн халдвартын тусламж, үйлчилгээ үзүүлдэг тусгай зөвшөөрөл бүхий хувийн эмнэлгийн мэргэшсэн эмч мэргэжилтнүүд нь бусад эмнэлгүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллана.

3.7.6. Эмнэлгийн үйл ажиллагаа, ажлын байранд халдвартын сэргийлэлт хяналт, аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөн, дотоод хяналт тавьж ажиллана.

3.7.7. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхэд “Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү, гепатитын В вирусийн халдвартай дамжихыг таслан зогсоох” зааврыг мөрдөн, тусламж үйлчилгээ үзүүлнэ.

3.7.8. Үйлчлүүлэгчдэд иргэний эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой заалтыг танилцуулсан байна.

ДӨРӨВ. ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРТАЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХЭД ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гепатитын вирусийн халдвартыг эрт илрүүлэх, оношлох, үр дүнтэй эмчлэх, хянахад өвчтөн, түүний гэр бүл, хамт олон, сайн дурын ажилтан, эрүүл мэндийн ажилтан, нийгмийн ажилтан нар дараах чиглэлээр хамтран ажиллана.

4.1. Үйлчлүүлэгчийг нотолгоонд суурилсан мэдээллээр хангана.

4.1.1. Үйлчлүүлэгчдэд иргэний эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой заалтыг танилцуулсан байна. Үүнд:

- Гепатитын вирусийн халдвартай тохиолдолд оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийлгэх;
- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар зохиож байгаа ажилд оролцох;
- Халдварт өвчин тархааас сэргийлэх дэглэмийг сахиж мөрдөх;
- Халдварт өвчний үзлэг, шинжилгээнд өөрийн санаачилгаар болон эмч, эмнэлгийн байгууллагын шаардлагаар орох;

4.1.2. Гепатитын вирусийн халдварын тусламж үйлчилгээг үзүүлэхдээ дараах халдварын талаарх мэдээллийг үйлчлүүлэгчид танилцуулсан байна. Үүнд:

- Гепатитын вирусийн халдвар, халдвар дамжих зам (цус, бэлгийн зам, эхээс хүүхдэд), хүндрэлийн тухай;
- Бусдаас халдвар авахаас сэргийлж, хувийн ариун цэврийн хэрэгсэл (шүдний сойз, хумсны хутга, сахлын хутга гэх мэт)-ийг бусадтай хуваалцахгүй,
- Халдвартай бол цусны донор болохгүй байх;
- Вирусийн эсрэг эмчилгээ, үргэлжлэх хугацаа, эмчилгээний ач холбогдол, эмчийн заасан хугацаанд эмчилгээг үр дүнд хүргэхийн тулд эмээ үргэлжүүлэн уух ёстой;
- Эмийн тэсвэржилт, гаж нөлөө, шинж тэмдэг, зовиур илэрвэл эмчид яаралтай мэдэгдэхийг тайлбарлаж өгөх;

4.1.3. Үйлчлүүлэгчийг хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмжинд хамруулах асуудлыг зохицуулах;

4.2. Үйлчлүүлэгч гепатитын вирусийн халдварын тусламж үйлчилгээ авахдаа дараах үүрэг хариуцлага хүлээнэ. Үүнд:

4.2.1. Гепатитын вирусийн халдвараас сэргийлж, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамрагдах;

4.2.2. Эрүүл мэндийн даатгалын багц үзлэг шинжилгээ, аж ахуйн нэгж байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд өөрийн санаачилгаар тогтоосон журмын дагуу оролцох;

4.2.3. Гепатитын вирусийн халдвартай байж болзошгүй, халдвар авах эрсдэлд өртсөн талаар, өөрөө болон гэр бүл, найз нөхөд, бэлгийн хамтрагчаас нь урьд өмнө гепатитын вирусийн халдвар илэрч байсан, нас барсан, эмчилгээ хийлгэсэн эсэх талаарх үнэн зөв мэдээллийг өгөх;

4.2.4. Гепатитын вирусийн халдвартай өвчтөн сүүлийн 6 сарын хугацаанд халдвар дамжих эрсдэлт хүчин зүйлд өртсөн талаарх мэдээлэл;

4.2.5. Гепатитын вирусийн халдвартай өвчтөн эмчийн өгсөн зөвлөмжийн дагуу эмчилгээний зааврыг чандлан мөрдөж, эмчилгээг бүрэн дуусгах, эмчилгээний явцад эмийн гаж нөлөө, хүндрэл илэрсэн, ямар нэг шалтгааны улмаас вирусийн эсрэг эмийг бүрэн хэрэглээгүй, тасалсан бол эмчлэгч эмчид мэдэгдэх;

4.2.6. Өвчтөн эмчилгээний явц, хяналтын шинжилгээг тогтоосон хугацаанд тогтмол өгөх;

4.2.7. Вирусийн эсрэг эмчилгээний талаар буруу ташаа мэдээлэл тараахгүй байх;

4.2.8. Бусад үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах, эмчилгээгээ бүрэн дуусгахад нь бусаддаа үлгэр дууриал болох;

4.3. Олон нийт, хамт олны оролцоо, дэмжлэг - Гепатитын вирусийн халдвараас сэргийлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллага, хамт олон, ажил олгогч нар дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

4.3.1. Гепатитын вирусийн халдвартай тэмцэх, сэргийлэх, тусlamж үйлчилгээг сайжруулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагын зохион байгуулж буй ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

4.3.2. Гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, дархлаажуулалт, илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамрагдахын ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах, сурталчлах, мэргэжлийн байгууллагаас дэмжлэг туслалцаа авч ажиллах;

4.3.3. Гепатитын архаг халдвартай иргэдэд дэмжлэг үзүүлэх, хяналтын үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулах, эмчилгээг эмчийн хяналтан дор тасралтгүй хийлгэхийн ач холбогдлыг ойлгуулах;

4.3.4. Гепатитын архаг халдвартай иргэдэд ажлын байрны ээлтэй орчинг бүрдүүлэх;

4.3.5. Ажиллагсдыг гепатитын вирусийн халдвар илрүүлэх, үзлэг шинжилгээ болон халдвараас сэргийлж дархлаажуулалтад хамруулах;

4.3.6. Үйлчлүүлэгч, ажилтан, тэдний гэр бүлийн нууцыг хамгаалах.

4.4. Мэргэжлийн нийгэмлэг холбоо

4.4.1. Эмч, мэргэжилтнүүдийн чадавхижуулах төгсөлтийн дараах богино хугацааны тасралтгүй болон мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, хамтран ажиллах;

4.4.2. Гепатитын вирусийн халдварын тандалт, тусlamж, үйлчилгээнд мөрдөх оношилгоо, эмчилгээний эмнэл зүйн зааврыг боловсруулахад оролцох;

4.4.3. Стандарт ажиллагааны заавар, удирдамж, гарын авлага, шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд сууринсан шинэ мэдээ мэдээллийг бэлтгэн эмч, мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах;

4.4.4. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, шинэ техник технологи, инновацийг нэвтрүүлэх.

$$\frac{\partial \psi}{\partial t} = -\frac{\partial^2 \psi}{\partial x^2} + \frac{1}{2} \left(\frac{\partial \psi}{\partial x} \right)^2 - \psi^2 + \epsilon \psi$$

$$H^{\ast}_c(\mathcal{M})$$

$$v^{\alpha}$$

ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ТАНДАЛТЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гепатитын вирусийн халдвартын тархвар судлал, тандалтын үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна. Гепатитын вирусын халдвартын тандалт гэдэг нь тохиолдлыг илрүүлэх, бүртгэх, мэдээллийг системтэйгээр цуглуулах, цуглуулсан мэдээнд дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх цогц үйл ажиллагаа юм.
- 1.2 Бүх шатны эрүүл мэндийн байгууллага нь гепатитын вирусийн халдвартын тандалтын тогтолцоог бүрдүүлж, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.
- 1.3 Гепатитын вирусийн халдвартын тандалтын тогтолцоогоор цочмог болон архаг халдварт, шинээр оношлогдож байгаа тохиолдол, халдварт авахад нелөөлсөн эрсдэлт хүчин зүйл, эхээс хүүхдэд дамжих халдварт, гепатитын вирусийн шалгаант элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөлийг тандан судлана.
- 1.4 Гепатитын вирусийн халдвартын тохиолдолд тархвар судалгаа хийж хүн ам зүй, эрсдэлт хүчин зүйл, зан үйл, эмчилгээ, вакцинжуулалтын мэдээллийг цуглуулан, мэдээнд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.
- 1.5 Тандалтын тогтолцоогоор цуглуулсан мэдээллээс халдвартын тархалт, түвшин, хөдлөл зүй, халдварт өртөх эрсдэлтэй хүн ам, халдварт дамжихад хамгийн их нелөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг тогтооно. Халдвараас сэргийлэх өвөрмөц болон өвөрмөц бус сэргийлэх арга хэмжээ, оношлогоо, эмчилгээ, хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний үр дүнг тооцон халдвартын тархалтыг бууруулах, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах тэргүүлэх чиглэлээ тодорхойлно.
- 1.6 Тандалтын тогтолцоогоор тогтоох боломжгүй мэдээлэл, үзүүлэлтийг зорилтот судалгаа, идэвхитэй тандалт хийж тогтооно.

ХОЁР. ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ТАРХАЛТ

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мэдээлснээр 2019 онд 296 сая хүн гепатитын В вирус (ГВВ)-ийн халдвартай, 58 сая хүн гепатитын С вирус (ГСВ)-ийн халдвартай амьдарч, жил бүр 1.5 сая хүн шинээр халдварт авч байна. Дэлхий дахинд гепатитын вирусийн халдвартын шалтгаант элэгний цирроз, элэгний хорт хавдрын улмаас жил бүр 1 сая гаруй хүн нас барж байна (ГВВ-ийн халдварт 820 мянга, ГСВ-ийн халдварт 290 мянган хүн). Гепатитын В вирусийн халдвартай хүмүүсийн дунд 4.5% нь гепатитын D вирусийн халдвартай гэж тооцоолжээ.

Монгол Улсад “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн 2021 оны байдлаар гепатитын С вирусийн халдвартын тархалт 9.3%, гепатитын В вирусийн тархалт 8.1% байна. Судалгаагаар HBsAg зөрэг хүмүүсийн 60-65% гепатитын D вирусийн халдвартай байна. Манай улсад гепатитын В ба D вирусийн цочмог халдвартай 15-44

насанд зонхилон бүртгэгдэж, эрэгтэйчүүд 66.2%-ийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд нийт нас баралтын 15%-ийг элэгний цирроз, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт эзэлж байна.

Нярай болон бага насандаа авсан гепатитын В вирусийн халдварт ихэвчлэн архагшиж, элэгний цирроз, хавдар болон нас баралтад хүргэх эрсдэлтэй. Нярай үедээ халдварт авсан бол 90%, 1-5 настайдаа халдварт авахад 20-50%, насанд хүрсэн үедээ бол 5-аас бага хувь нь архаг хэлбэрт шилждэг. Тиймээс эхээс хүүхдэд халдварт дамжихаас сэргийлж чадвал гепатитын В вирусийн шалтгаант архаг халдвартын өвчлөл, нас баралт буурна.

ГУРАВ. ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ТАРХВАР СУДЛАЛ

3.1. Гепатитын вирусийн халдвартын эх уурхай

- ГВВ-ийн цочмог ба архаг халдвартай хүн
- ГСВ-ийн цочмог ба архаг халдвартай хүн
- ГДВ-ийн цочмог ба архаг халдвартай хүн

3.2. Халдварт дамжих зам

- Арьс салстын бүрэн, бүтэн байдлыг алдагдуулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ (мэс засал, шүд, төрөлт, тарилга, зүү эмчилгээ гэх мэт) болон гоо сайхны үйлчилгээ (шивээс, чих цоолох, маникюр, педикюр гэх мэт), гэмтэл, ахуйн орчинд сахлын хутга, хумсны хутга, сойз зэрэг хэрэгслийг дундаа хэрэглэх явцад арьс салстaa гэмтээх байдлаар халдварт дамжих;
- ГВВ-ийн халдвартай жирэмсэн эхээс хүүхдэд халдварт дамжих;
- Халдвартай хүний цус цусан бүтээгдэхүүн сэлбэх;
- Мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд зүү тариураар;
- Бэлгийн замаар.

3.3. Халдварт өртөх эрсдэлт хүн ам

3.3.1. Эрхэлсэн ажил мэргэжлээс хамаарах эрсдэлтэй бүлэг:

- Цус, биологийн шингэнтэй шууд харьцаж ажилладаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн (мэс засал, гэмтэл, төрөх, эмэгтэйчүүд, шүд, эмгэг судлал, лаборатори, эмнэлгийн анхан шатны яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлдэг), яаралтай тусламж үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтэн, цагдаа, үйлчилгээний ажилтан, эрдэм шинжилгээ, судалгааны ажилтан
- Хүний цустай харьцдаг эм, биобэлдмэлийн үйлдвэр, цусны төв ба гемодиализийн ажилтан
- Эмнэлгийн багаж хэрэгсэл угааж цэвэрлэдэг ариутгалын ажилтан, эмнэлгийн хог хаягдлыг цуглуулж, устгах ажилтан

3.3.2. Биеийн эрүүл мэндээс хамаарах эрсдэлтэй бүлэг:

- Цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэн, эс болон эхийн сүүний донорууд
- Байнгын бөөр орлуулах гемодиализ эмчилгээ, шаардлагатай ба цусны эмгэгтэй өвчтнүүд, бусад мэс ажилбар, үр хөндөлт хийлгэсэн хүмүүс
- Гепатитын вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхэд, БЗДХ, ХДХВ-ийн халдвартай амьдарч байгаа хүмүүс

3.3.3. Амьдралын хэв маяг, бэлгийн зан үйлээс хамаарах эрсдэлт бүлэг:

- Биеэ үнэлэгчид, тэдний бэлгийн хавьтагчид
- Бэлгийн олон хавьтагчтай хүмүүс
- Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд

- Мансууруулах бодис тарьж хэрэглэгчид
 - Хөдөлгөөнт хүн ам, шилжин суурьшигчид,
 - Хорих газар ял эдлэгсэд, хаалттай орчинд байрлагсад /цэргийн хуаран/
 - ГВВ-ийн халдвартай хүний бэлгийн хамтрагч, гэр бүлийн гишүүд
- 3.4. Гепатитын вирусийн цочмог халдвартай нууц үеийн хугацаа
- ГВВ-ийн халдвартай 45-180 хоног (дунджаар 90 хоног)
 - ГСВ-ийн халдвартай 14-180 хоног (ихэвчлэн 14-84 хоног)
 - ГДВ-ийн халдвартай 2-8 долоо хоног
- 3.5. Гепатитын вирусийн халдвартай илрүүлэг
- 3.5.1. Эрсдэлт суурилсан илрүүлэг – Гепатитын вирусийн халдварт өртөх эрсдэлт хүн амыг илрүүлэг шинжилгээнд хамруулна.
- 3.5.2. Хүн амд суурилсан илрүүлэг (universal) – 18-аас дээш насын хүмүүст гепатитын вирусийн илрүүлэг шинжилгээг хийнэ.
- ДӨРӨВ. ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**
- 4.1. Гепатитын В вирусийн халдвартай дархлаажуулалт
- 4.1.1. Хүүхдийн дархлаажуулалт
- Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу хүүхдийг гепатитын В вирусийн эсрэг вакцины 4 тунгаар дархлаажуулна. Эхний тунг нярайг төрснөөс хойш 24 цагийн дотор хийнэ.
 - Гепатитын В вирусийн архаг халдвартай эхээс төрсөн хүүхдэд гепатитын В вирусийн эсрэг товтолт вакцины эхний тун ба гепатитын В вирусийн эсрэг иммуноглобулин (HBIG)-ыг төрснөөс хойш 12 цагийн дотор зааврын дагуу хийнэ.
 - Гепатитын В вирусийн эсрэг вакциныг 0.5 мл-ээр хүүхдийн баруун гуяны булчинд, гепатитын В вирусийн эсрэг иммуноглобулиныг үйлдвэрлэгчийн зааварт заасан тун хэмжээгээр хүүхдийн зүүн гуяны булчинд тус тус тарина.
 - Вакцин, иммуноглобулиныг тарьсан огноо, талбай, цувралын дугаарыг эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээнд заавал тэмдэглэнэ.
 - Дутуу ба бага жинтэй нярайд эрхтэн системийн хүнд хэлбэрийн өөрчлөлтгүй тохиолдолд иммуноглобулиныг гепатитын В вирусийн эсрэг вакцины хамт нярайн эмчийн заалтаар хийнэ.
 - Гепатитын В вирусийн эсрэг вакцин, иммуноглобулиныг “Вакцин, биобэлдмэлийг хадгалах, тээвэрлэх журам”-ын дагуу эмнэлгийн мэргэжилтний хяналтан дор +2-+8°C-д хадгалж, тээвэрлэнэ.
 - Халдвартай эхээс төрсөн нярайд гепатитын В вирусийн эсрэг иммуноглобулины нэг тун, гепатитын В вирусийн эсрэг вакцины 4 удаагийн тунг бүрэн хийснээс хойш 2 сарын дараа HBsAg, anti-HBs илрүүлэх шинжилгээ хийж, халдвартай авсан эсвэл дархлал тогтсон эсэхийг үнэлнэ (Хүснэгт 1).
- 4.1.2. Сайн дурын дархлаажуулалт
- Эрсдэлт бүлгийн хүн амыг гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтад хамруулна.

- Товтолын вакцин, гепатитын В вирусийн эсрэг вакцинд хамрагдаад 15-аас дээш жил болсон бол зааврын дагуу вакцинд хамруулах ажлыг харьяа эрүүл мэндийн байгууллага зохион байгуулна.
- HBsAg, anti-HBc ба anti-HBs тодорхойлох шинжилгээг хийж HBsAg сөрөг, anti-HBc сөрөг, anti-HBs сөрөг тодорхойлогдвол уг хүнийг халдварт аваагүй, вакцин хийлгээгүй гэж үзэн гепатитын В вирусийн З тунгаар дархлаажуулж, вакцин хийлгэсэн тухай тэмдэглэл хийлгүүлнэ (Хүснэгт 1).
- Шинжилгээгээр HBsAg сөрөг тохиолдолд сайн дурын дархлаажуулалтад харьяа эрүүл мэндийн байгууллагад хамрагдана.
- Дархлаажуулалтын сүүлийн тунгаас 1-2 сарын дараа anti-HBs тодорхойлно.

Хүснэгт 1. Гепатитын В вирусийн эсрэг вакцины дархлаа (Anti-HBs) тогтоцын түвшин

№	Anti-HBs түвшин (mIU/ml)	Тайлбар	Авах арга хэмжээ
1.	<10	Дархлаа тогтоогүй	Дахин 3 тун вакцин хийх
2.	10-100	Сул хариу урвал	Нэг тун вакцин нэмэлтээр хийх
3.	>100	Дархлаатай	Шаардлагагүй

4.2. Эмнэлгийн тусlamж үйлчилгээний явцад эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчийг халдварт өrtөхөөс сэргийлэх

4.2.1. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлж буй эрсдэлт бүлэгт хамаарах эрүүл мэндийн ажилтанг гепатитын вирусийн халдварт авах эрсдэлт хүчин зүйлд өrtөх, өrtсөний дараа халдвараас сэргийлэх арга хэмжээ нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам, зааврын дагуу зохицуулагдана.

4.2.2. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийг гепатитын вирусийн халдварт өrtөхөөс сэргийлж багаж, хэрэгслийн ариун байдал, орчны цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хэрэгжүүлж, тарилтын аюулгүй байдлыг ханган, аль болох нэг удаагийн хэрэгслийг тусlamж үйлчилгээнд ашиглана.

4.2.3. Үйлчлүүлэгч эмнэлгийн тусlamж, үйлчилгээ авах үедээ гепатитын вирусийн халдварт авах эрсдэлт хүчин зүйлд өrtсөн бол өrtөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээ нь эрүүл мэндийн ажилтны өrtөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээний заавартай ижил, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зааврыг баримтлана.

4.2.4. Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах асуудал холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдана.

4.3. Гоо сайхны үйлчилгээний ажилтан болон үйлчлүүлэгчийг халдварт өrtөхөөс сэргийлэх

4.3.1. Арьс, салстад хүрэлцэх, цоолох ажилбарт нэг удаагийн хэрэгслийг ашиглах;

4.3.2. Гоо сайханч, маникюр, шивээсчин бэлтгэх мэргэжлийн сургалтуудад халдвараас сэргийлэх мэдлэг олгох;

4.3.3. Шивээс, маникюр, педикюр зэрэг гоо сайхны үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудад мэргэжлийн нийгэмлэг холбоод, хяналтын болон мэргэжлийн байгууллагууд хяналт, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангах;

4.3.4. Дээрх үйлчилгээний ажилтанг гепатитын В вирусийн эсрэг вакцинд хамруулах.

4.4. Бэлгийн замаар халдварт дамжихаас сэргийлэх

4.4.1. Бэлгэвч зөв хэрэглэхийг олон нийтэд сурталчлах;

4.4.2. Хөдөлгөөнт хүн ам, эмэгтэй биеэ үнэлэгч, эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьтад ордог эрэгтэйчүүд зэрэг эрсдэлт бүлгийн хүн амыг илрүүлэг шинжилгээнд тогтмол хамруулах, тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

4.4.3. Нийт хүн амд бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх мэдлэг, хандлага, дадал, зан үйлийг төлөвшүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх;

4.4.4. Гэр бүлийн хүн, бэлгийн хамтрагчийн аль нэг нь гепатитын вирусийн архаг халдвартай бол хамтрагчийг В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулах.

4.5. Эхээс хүүхдэд халдварт дамжихаас сэргийлэх

4.5.1. Эхийн цусанд гепатитын В вирусийн ачаалал өндөр, HBeAg зерэг бол төрөхөөс өмнө вирусийн эсрэг эмчилгээнд хамруулах.

4.5.2. Нэхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг эрт илрүүлэгт хамруулж, гепатитын вирусийн халдварт илэрвэл гэр бүл төлөвлөлтөөс өмнө эмчлэх, хянах.

4.5.3. Гепатитын В вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхдэд вакцин, иммуноглобулиныг зааврын дагуу хийх.

4.6. Мансууруулах бодис судсаар тарьж хэрэглэгчдэд халдварт дамжихаас сэргийлэх

4.6.1. Гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтад хамруулах;

4.6.2. Нэг удаагийн зүү, тариур, мансууруулах бодис орлуулагч хэрэглэхийг зөвлөх;

4.6.3. Зорилтот бүлгийг урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах.

ТАВ. ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ТАНДАЛТ

5.1. Гепатитын вирусийн цочмог халдварт

5.1.1 Гепатитын В вирусийн цочмог халдвартын тохиолдлын тодорхойлолт:

5.1.1.1 Эмнэлзүйн шалгуур - Өвөрмөц шинж тэмдэг болох шарлах болон бусад эмнэлзүйн шинж тэмдэг цочмог эхэлсэн, ийлдэс дэх аминотрансферазын түвшин нэмэгдсэн.

5.1.1.2 Лабораторийн шалгуур - Гадаргуугын эсрэг төрөгч (HBsAg) болон үндсэн эсрэгтөрөгчийн эсрэг иммуноглобулин M (anti-HBcIgM) зерэг илэрсэн.

5.1.1.3 Тархвар судлалын шалгуур - Үйлчлүүлэгчид өмнө нь тухайн вирус тодорхойлогдож байгаагүй, шинж тэмдэг эхлэхээс 15-50 өдрийн өмнө гепатитын В вирусийн халдвартай хүнтэй бэлгийн хавьтад орсон, арьс салстын бүрэн бүтэн байдлыг алдагдуулсан ямар нэгэн эрсдэлт хүчин зүйлд ертсөн.

5.1.2 Гепатитын С вирусийн цочмог халдварын тохиолдлын тодорхойлолт:

5.1.2.1 Эмнэлзүйн шалгуур – Халдвар авсан тохиолдлын 70-80 хувьд эмнэлзүйн шинж тэмдэг илрэхгүй. Төрөх үед халдвар авсан мэдээлэл байхгүй бол 36 сараас дээш настай хүнд шарлах шинж тэмдэг, эсвэл цусан дахь нийт билирубиний дээд түвшин \geq 3.0 мг/дл, эсвэл ийлдэсд аланин аминотрансферазын (ALT) дээд түвшин > 200 IU/L байх.

5.1.2.2 Лабораторийн шалгуур – HCV RNA зэрэг эсвэл С вирусийн эсрэгтөрөгч байгааг илтгэх сорил зэрэг.

5.1.2.3 Тархвар судлалын шалгуур – Өмнө нь HCV RNA, С вирусийн эсрэгтөрөгч тодорхойлогдож байгаагүй. Эмнэлзүйн шинж тэмдэг эсвэл лабораториор оношлогдохоос 14-180 өдрийн өмнө арьс салстын бүрэн бүтэн байдлыг алдагдуулсан ямар нэгэн эрдэлт хүчин зүйлд өртсөн.

5.1.3 Гепатитын D вирусийн цочмог халдварын тохиолдлын тодорхойлолт

5.1.3.1 Эмнэлзүйн шалгуур - Гепатитын D вирусийн цочмог халдвар нь хам халдвар болон давхар (супер) халдвар гэсэн 2 хэлбэртэй.

5.1.3.2 Гепатитын В ба D вирусийн хам халдвар: Өмнө нь халдвар авч байгаагүй хүнд гепатитын В вирус, гепатитын D вирус зэрэг халдварлаж элгийг гэмтээх хүнд явцтай цочмог халдварт өвчин. Эмнэл зүйд ихэвчлэн фулминант хэлбэрээр илрэх ба нас барагт өндөр.

5.1.3.3 Гепатитын В ба D вирусийн давхар халдвар: Архаг В гепатиттай өвчтөнд гепатитын D вирус нэмж халдварлах байдал. Давхар халдварын үед эмнэл зүйн шинж тэмдэг нь ихэвчлэн хүнд хэлбэрээр явагдаж ерөнхий хордлого, шарлалт, цусархаг хам шинж тод ажиглагдана.

5.1.4 Гепатитын вирусийн цочмог халдварын батлагдсан тохиолдлыг “Маягт 1. Гепатитын вирусийн цочмог халдварын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хуудас”-ын дагуу бүртгэнэ.

5.1.5 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын тархвар судлаач нь гепатитын цочмог халдварын тохиолдолд тархвар судалгаа хийж, халдвар авахад нөлөөлсөн байж болзошгүй эрдэлт хүчин зүйлийг тогтоож, хариу арга хэмжээ авч ажиллана.

5.1.6 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг Өвчний олон улсын 10 дугаар ангиллын дагуу өвчлөл, нас барагтын тандалтын сарын тоон мэдээг “Маягт 1. Гепатитын вирусийн цочмог халдварын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хуудас”-ын дагуу нэгтгэн, ХӨСҮТ-д medee@ncccd.gov.mn цахим хаягаар сар бүрийн 5-ны дотор мэдээллийн урсгалын дагуу мэдээлнэ.

5.2. Гепатитын вирусийн архаг халдвар

5.2.1. Гепатитын В вирусийн архаг халдварын тохиолдлын тодорхойлолт:

5.2.1.1. Эмнэлзүйн шалгуур: Шинж тэмдэг илрэхгүй байж болно.

5.2.1.2. Лабораторийн шалгуур: Үйлчлүүлэгчид өмнө 6 сараас өмнө HBsAg тодорхойлогдож байсан, anti-HBcIgM сөрөг, дараах

үзүүлэлтийн аль нэг нь зерэг гарсан (HBsAg, HBeAg, гепатит В вирус ДНХ), б сараас дээш хугацаанд тодорхойлогдсон.

- 5.2.1.3. Тархвар судлалын шалгуур-Эмнэл зүй, лабораторийн шалгуураар архаг халдвэр бол тархвар судлалын шалгуур шаардлагагүй.

5.2.2. Гепатитын С вирусийн архаг халдвартын тохиолдлын тодорхойлолт:

- 5.2.2.1. Эмнэлзүйн шалгуур: Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхгүй эсвэл архаг халдвартай хүнд гепатитын үеийн шинж тэмдэг хөнгөнөөс хүнд явцтай илэрнэ.
- 5.2.2.2. Лабораторийн шалгуур: Anti-HCV зерэг, мөн HCV RNA тодорхойлогдоно.
- 5.2.2.3. Тархвар судлалын шалгуур: Эмнэл зүй, лабораторийн шалгуураар архаг халдвэр бол тархвар судлалын шалгуур шаардлагагүй.

5.2.3. Гепатитын D вирусийн архаг халдвартын тохиолдлын тодорхойлолт

- 5.2.3.1. Эмнэлзүйн шалгуур - Эмнэл зүйн шинж тэмдэггүй, эсвэл хөнгөнөөс нэн хүнд хэлбэрээр явагдана. Хүнд хэлбэрийн үед ерөнхий хордлого, шарлалт, цусархаг хам шинж тод ажиглагдана. Өвчний давшигүй хэлбэрийн үед элэгний цирроз, элэгний ээнэгшил адлагдал, элэгний хорт хавдрын шалтгаан болдог.
- 5.2.3.2. Лабораторийн шалгуур: Гепатитын В вирусийн гадаргуугийн эсрэгтөрөгч (HBsAg) б сараас дээш хугацаанд зерэг өвчтөнд ГДВ-ийн эсрэгбие (anti-HDV) зерэг, HDV-RNA тодорхойлогдсон.
- 5.2.3.3. Тархвар судлалын шалгуур: - Эмнэл зүй, лабораторийн шалгуураар архаг халдвэр бол тархвар судлалын шалгуур шаардлагагүй.
- 5.2.4. Гепатитын вирусийн архаг халдвартын батлагдсан тохиолдлыг "Маягт 2. Гепатитын вирусийн архаг халдвартын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хуудас"-ын дагуу бүртгэнэ.

5.3. Үр дагаврын тандалт

5.3.1. Гепатитын В, С, D вирусийн шалтгаант элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөлийг бүртгэнэ.

5.3.2. Эрүүл мэндийн байгууллага нь тухайн сард шинээр бүртгэгдсэн гепатитын В, С, D вирусийн архаг халдвартын шалтгаант элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөл, нас барагтын тохиолдлыг "Маягт 3. Гепатитын вирусийн архаг халдвартын үр дагаврын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хуудас"-ын дагуу нэгтгэж, сарын эцсээр тасалбар болгон аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт мэдээлнэ.

5.3.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг Өвчний олон улсын 10 дугаар ангиллын дагуу кодлож, өвчлөл, нас барагтын тандалтын сарын тоон мэдээг "Маягт 3. Гепатитын вирусийн архаг халдвартын үр дагаврын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх


"хуудас"-ын дагуу нэгтгэн, ХӨСҮТ-д medee@nccd.gov.mn цахим хаягаар сар бүрийн 5-ны дотор мэдээллийн урсгалын дагуу мэдээлнэ.

5.4. Жирэмсний хяналтад байгаа эмэгтэйчүүдийг гепатитын В, С вирусийн халдварт илрүүлэх шинжилгээнд хамруулж, халдвартай илэрсэн тохиолдол бүрийг хяналтад авч, "Маягт 4. Эхээс хүүхдэд дамжих гепатитын вирусийн халдварын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хуудас"-ын дагуу сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь ХӨСҮТ-ийн medee@nccd.gov.mn цахим хаягаар сар бүрийн 5-ны дотор мэдээлнэ.

5.5. Аймаг, нийслэл, эрүүл мэндийн байгууллага гепатитын вирусийн халдварт (цочмог, архаг, үр дагавар)-ын тандалтын мэдээ, тайланг бүрэн гүйцэд, цаг хугацаанд нь мэдээллийн урсгалын дагуу ирүүлнэ (Зураг 1).

5.6. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь гепатитын вирусийн архаг халдварын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зураглалын дагуу мэдээллийн сан үүсгэн, мэдээ, мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, дун шинжилгээ хийж үндсэн шалгуур үзүүлэлтийг тооцно.

5.7. Гепатитын вирусийн архаг халдварын тохиолдлыг бүртгэн хяналтад авч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулан эмчилгээний үр дүнг тооцно.



Зураг 1. Тандалтын мэдээллийн урсгал

Маягт 1.

ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ЦОЧМОГ ХАЛДВАРЫН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ХУУДАС											
Эрүүл мэндийн байгууллагын нэр _____					Мэдээлсэн огноо _____						
Вируст гепатитын сэжигтэй тохиолдлын нэр:											
1. Эцэг/эхийн нэр		2.Өөрийн нэр		3. Нас			4. Хүйс <input type="checkbox"/> Эрэгтэй <input type="checkbox"/> Эмэгтэй		5. Утасны дугаар		
6. Регистрийн дугаар		7. Оршин суугаа хаяг Аймаг / Хот _____ Сум / Дүүрэг _____		8. Ам бүл			9. Ажлын хаяг				
Баг / Хороо _____		Хэсэг / Хороолол _____									
10. Албан тушаал, нийгмийн байдал			11.Хэрвээ хүүхэд бол			12.Боловсрол					
<input type="checkbox"/> Ажилчин <input type="checkbox"/> Оюутан			<input type="checkbox"/> Сургууль <input type="checkbox"/> Хүүхэд асрах төв			<input type="checkbox"/> Боловсролтой					
<input type="checkbox"/> Албан хаагч <input type="checkbox"/> Хүүхэд (0-15)			<input type="checkbox"/> Цэцэрлэг <input type="checkbox"/> Бусад _____			<input type="checkbox"/> Бүрэн дунд					
<input type="checkbox"/> Малчин <input type="checkbox"/> Ажилгүй			<input type="checkbox"/> Гартээ			<input type="checkbox"/> Тусгай дунд					
<input type="checkbox"/> Тэтгэвэрт <input type="checkbox"/> Бусад			<input type="checkbox"/> Дотуур байр			<input type="checkbox"/> Бакалавр					
						<input type="checkbox"/> Магистр ба түүнээс дээш					
13. Эмнэлэгт узүүлсэн огноо: _____		14. Эмнэлэгт хэвлсэн эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Тийм бол огноо: _____		15. Цочмог эхэлсэн эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй		16. Арьс салс т шарл асан эсэх: <input type="checkbox"/> Тийм	17. Эмнэл зүйн шинж тэмдэг эхэлсэн огноо: _____	18. Шинжилгээ авсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Тийм бол огноо: _____	19.Өвчтөн нас барсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Тийм бол огноо: _____	20. Вируст гепатитын эсрэг дархлаажуулалт: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй ГАВ вакцин <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй ГВВ вакцин <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	
21. Эмнэ нь архаг гепатитын халдвартай эсэх:					22. Лабораторийн шинжилгээ хийсэн эсэх: Тийм-1 Үгүй-2 Аланинаминотрансфераз (АЛАТ) ОУН _____ Аспаргинаминотрансфераз (АСАТ) ОУН _____						
Гепатитын С вирусийн архаг халдвартай эсэх: <input type="checkbox"/> 1					anti-HAV IgM <input type="checkbox"/> Эрөг anti-HDV <input type="checkbox"/> Эрөг						
Гепатитын В вирусийн архаг халдвартай эсэх: <input type="checkbox"/> 2					anti-HAV IgG <input type="checkbox"/> Эрөг anti-HDV IgM <input type="checkbox"/> Эрөг						
Гепатитын В, D вирусийн архаг халдвартай эсэх: <input type="checkbox"/> 3					HBsAg <input type="checkbox"/> Эрөг HDV-RNA _____ IU/ml						
23. Халдвартай эх уурхай					anti-HBcIgM <input type="checkbox"/> Эрөг anti-HCV <input type="checkbox"/> Эрөг						
					HBeAg <input type="checkbox"/> Эрөг HCV-RNA _____ IU/ml						
Өвчтөн <input type="checkbox"/> 1					anti-HBc <input type="checkbox"/> Эрөг HCV genotype <input type="checkbox"/> Эрөг						
Вирус тээгч <input type="checkbox"/> 2					HBV-DNA _____ IU/ml anti-HEV IgM <input type="checkbox"/> Эрөг						
Тодорхойгүй <input type="checkbox"/> 3					anti-HBs <input type="checkbox"/> Эрөг						
24. Эрсдэлт хүчин зүйлс											
Эмнэлгийн туслаамж үйлчилгээ					Баталгаагүй эх уусвэрээс ундны ус уусан <input type="checkbox"/> 11						
					Баталгаагүй хүнсний бүтээгдэхүүн хэрэглэсэн <input type="checkbox"/> 12						
					Өвчлөл гарсан хүүхдийн байгууллагын хүүхэд эсвэл <input type="checkbox"/> 13						
					Гепатитын вирусийн халдвартай эндертэй газар <input type="checkbox"/> 14						
					Гэр бүлийн гишүүн гепатитын вирусийн халдвартай <input type="checkbox"/> 15						
Эмнэлгийн туслаамж Ажил эрхэмлэлт					Шүдний сойз, сахлын ба хүмсны хупта г.м хувийн эрүүл ахуйн хэрэгслийг дамжуулан хэрэглэдэг <input type="checkbox"/> 16						
					Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд <input type="checkbox"/> 17						
					Бэлгийн олон хавьтагчтай <input type="checkbox"/> 18						
					Мансууруулах бодис хэрэглэдэг, бэлгийн харьцаанд орсон <input type="checkbox"/> 19						
					Бэртэл гэмтэл <input type="checkbox"/> 20						
Гэрээр тариа хийлгэсэн <input type="checkbox"/> 21											
Бусад <input type="checkbox"/> 22											
25. Батлагдсан онош (ОУФА-10) / / / / <input type="checkbox"/> Эмнэлзүйгээр <input type="checkbox"/> Тархвар судлалын асуумж <input type="checkbox"/> Лабораториор											
26. Онош батлагдсан огноо / / /											

Маягт 2.

ГЕПАТИТЫН ВИРУСИЙН АРХАГ ХАЛДВАРЫН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ХУУДАС				
Эрүүл мэндийн байгууллагын нэр _____		Мэдээлсэн огноо _____ / _____ / _____		
Вируст гепатитын сэжигтэй тохиолдлын нэр:				
1. Эцэг/Эхийн нэр _____		2. Фамилийн нэр _____		3. Нас _____
4. Хүйс <input type="checkbox"/> Эрэгтэй <input type="checkbox"/> Эмэгтэй		5. Утасны дугаар _____		
6. Регистрийн дугаар _____		7. Оршин суугаа хаяг Аймаг / Хот _____ Сум / Дүүрэг _____ Баг / Хороо _____ Хэсэг / Хороопол _____		8. Ам бул _____
10. Албан тушаал, нийгмийн байдал <input type="checkbox"/> Ажилчин <input type="checkbox"/> Юустан <input type="checkbox"/> Албан хаагч <input type="checkbox"/> Хүүхэд (0-15) <input type="checkbox"/> Маличин <input type="checkbox"/> Ажилгүй <input type="checkbox"/> Тэтгэвэрт <input type="checkbox"/> Бусад 11. Хэрэв хүүхэд бол <input type="checkbox"/> Сургууль <input type="checkbox"/> Хүүхэд асрах төв <input type="checkbox"/> Цэцэрлэг <input type="checkbox"/> Бусад _____ <input type="checkbox"/> Гэртээ <input type="checkbox"/> Дотуур байр _____		12. Боловсрол <input type="checkbox"/> Боловсролгүй <input type="checkbox"/> Бүрэн дунд <input type="checkbox"/> Тусгай дунд <input type="checkbox"/> Бакалавр <input type="checkbox"/> Магистр ба туунээс дээш		13.Үзлэгийн төрөл <input type="checkbox"/> Үрьдчилан сэргийлэх үзлэг <input type="checkbox"/> Эрт ирүүлэг <input type="checkbox"/> Өвчиний учир амбулаторийн зөвхөгүүй/ <input type="checkbox"/> Идэвхийтэй илрүүлэлтээр <input type="checkbox"/> Хяналт <input type="checkbox"/> Тандалт/хөвөвтлаар/
15.Огноо Өвчин эхэлсэн: _____ / _____ / _____ Эмчид үзүүлсэн: _____ / _____ / _____ Оношлогдсон: _____ / _____ / _____ Бүртгэл авсан: _____ / _____ / _____ Эмчилгээ эхэлсэн: _____ / _____ / _____		16.Эмнэлэгт хөвтээн эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Тийм бол огноо: _____ / _____ / _____	17.Өвчтөн нас барсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Тийм бол огноо: _____ / _____ / _____	14.Тохиолдлын тодорхойлолт: <input type="checkbox"/> Шинээр бүртгэдэн оношлогдсон <input type="checkbox"/> Өмнө нь оношлогдож байсан, давтан <input type="checkbox"/> Хяналт алдаадсаны дараах <input type="checkbox"/> Эмчилгээний үр дүн тодорхойгүй
20. Өмнө нь гепатит HBsAg, Anti-HCV илрүүлэг шинжилгээ өгч байсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй		Хэрэв тийм бол: HBsAg: <input type="checkbox"/> Серег <input type="checkbox"/> Эзэрэг HBV анхеношлогдсон огноо: _____ / _____ / _____ Anti-HCV: <input type="checkbox"/> Серег <input type="checkbox"/> Эзэрэг HCV анхеношлогдсон огноо: _____ / _____ / _____		18. Вируст гепатитын эсрэг дархлаажуулалт <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй ГАВ вакцин <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй ГВВ вакцин <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Хэрэв тийм бол: <input type="checkbox"/> I тун <input type="checkbox"/> II тун <input type="checkbox"/> III тун
22. Эмчийн хяналтанд орсон эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Хэрэв тийм бол: <input type="checkbox"/> Ахнуудаа <input type="checkbox"/> Давтсан Огноо: _____ / _____ / _____		23.Хяналтын хугацаанд элэгний цирроз, элэгний хорт хавдар оношлогдсон эсэх <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Хэрэв тийм бол: <input type="checkbox"/> Элэгний цирроз <input type="checkbox"/> Элэгний эстемэн Огноо: _____ / _____ / _____		19. Дархлаа тогтоц тодорхойлсон эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Хэрэв тийм бол anti-HBs (mIU/ml): <input type="checkbox"/> <10 mIU/ml <input type="checkbox"/> 10-100 mIU/ml <input type="checkbox"/> >100 mIU/ml
24. Вирусийн эсрэг эмчилгээ хамрагдсан эсэх <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Хэрэв тийм бол 24-26 асуултавас хамааралтайт бөлгөх <input type="checkbox"/> Ахнуудаа орж байгаа <input type="checkbox"/> Давтсан огноо: _____ / _____ / _____		25. ГСВ-ийн эмчилгээний түүх: Харэглэсэн эм: <input type="checkbox"/> ПегИНФ/Рибавирин ВЭШҮ эм Эмийн нэр _____ Эмчилгээ хийсэн огноо: _____ / _____ / _____ Эмчилгээний үр дүн: Эмчилгээ дуусаад 12 долоо хоногоос хойш HCV-RNA шинжилгээ хийлгэсэн эсэх <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй Тийм бол HCV RNA тоо: _____ IU/ml <input type="checkbox"/> ГСВ эмчлэгдсэн SVR илэрсэн <input type="checkbox"/> ГСВ эмчлэдээгүй Non response <input type="checkbox"/> ГСВ сэдэрсэн Relapse		26. ГВВ-ийн эмчилгээний түүх: Харэглэсэн эм: <input type="checkbox"/> ПегИНФ <input type="checkbox"/> Нуклеоз(т)ид эм Эмийн нэр _____ Эмчилгээ хийсэн огноо: _____ / _____ / _____ Эмчилгээний үр дүн HBV-DNA тоо: _____ IU/ml <input type="checkbox"/> ГВВ эмчлэгдсэн SVR <input type="checkbox"/> сероконверси илэрсэн <input type="checkbox"/> биохими хария урвал илэрсэн <input type="checkbox"/> хариу урвалгүй Non response
28. Эрсдэлт хүчин зүйлс		27. ГДВ-ийн эмчилгээний түүх: Харэглэсэн эм: <input type="checkbox"/> ПегИНФ <input type="checkbox"/> Булевиртид <input type="checkbox"/> Нуклеоз(т)ид эм Эмийн нэр _____ Эмчилгээ хийсэн огноо: _____ / _____ / _____ Эмчилгээний үр дүн: HDV-RNA тоо: _____ IU/ml <input type="checkbox"/> ГДВ эмчлэгдсэн SVR <input type="checkbox"/> ГДВ ачаалал буурсан <input type="checkbox"/> биохими хария урвал илэрсэн <input type="checkbox"/> хариу урвалгүй Non response		
Эмчилгээний туслах чадвар		Баталгаагүй эх уүсвэрээс үндны ус уусан <input type="checkbox"/> 11 Баталгаагүй хүнсний бүтээгдэхүүн хэрэглэс <input type="checkbox"/> 12 Өвчтөл гарсан хүүхийн байгууллагын <input type="checkbox"/> 13 Гепатитын вирусийн халдварт өндөртэй <input type="checkbox"/> 14 Гэр бүлийн гишүүн гепатитын вирусийн халдвартай <input type="checkbox"/> 15 Цүдний соёз, сахалын ба хүмсны хутга г.м хувийн зруул ахуйн хэрэгслийг дамжуулан хэрэглэдэг <input type="checkbox"/> 16 Эрчүүдтэй бэлгийн хавьтад ордог эрчүүд <input type="checkbox"/> 17 Бэлгийн олон хавьтагчтай <input type="checkbox"/> 18 Мансууруулах бодис хэрэглэдэг, бэлгийн харьцаанд орсон <input type="checkbox"/> 19 Бэртэл гэмтэл <input type="checkbox"/> 20 Гэрээр тария хийлгэсэн <input type="checkbox"/> 21 Бусад <input type="checkbox"/> 22		
		Джинсийн эхийн туслах чадвар		29. Батлагдсан онош (ОУӨА-10) _____ / _____ / _____ <input type="checkbox"/> Эмнэлзүйгээр <input type="checkbox"/> Тархваар судпалын асуумж <input type="checkbox"/> Лабораториор
30. Онош батлагдсан огноо: _____ / _____ / _____				

Маягт 3.

ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ҮР ДАГАВРЫН ТОХИОЛДЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ХУУДАС

Ерөнхий мэдээлэл – Иргэний бүртгэл				
Тандалтын нэжийн нэр:				
Мэдээлсэн эмчийн нэр:				
Мадзэлсэн оноо:	_____ / _____ / _____			
Өвчний регистрийн дугаар:				
Төрсөн он сар өдөр:	_____ / _____ / _____	Хүйс: Эр Эм		
Оношилсон оноо	_____ / _____ / _____			
Үр дагавар/ хүндэрэл				
ЭЛЭГНИЙ ЦИРРОЗЫН ОНОШИЛГОО				
Тохиолдлын төрөл	Шинэ оношлогдсон	Өвчний төгсгөлийн шат	Элэг шилжүүлэн суулгасан	Нас барсан
Элэгний цирроз эзэнгшилтэй		Тийм	Үгүй	
Эмнэлзүйгээр оношилсон элэгний цирроз		Тийм	Үгүй	
Дүрс оношилгоо хийсэн		Тийм	Үгүй	
Эмгэг судлалын оношилгоо (биопси) хийсэн		Тийм	Үгүй	Хийгдээгүй
Фиброз шинжилгээ (FIB-4, APR)	FIB-4 оноо-----, APR оноо-----			
Фиброскан (kPA оноо)		Хийгдээгүй		
Элэгний циррозын үе шат (Чайлд Пью үнэлгээ)	A (5-6 оноо)	B (7-9 оноо)	C (10-15 оноо)	
Энцефалопати (үе шат)	Үгүй(1 оноо)	I-II зэрэг (2 оноо)	III-IV зэрэг (3 оноо)	
Хавлийн асцит	Байхгүй(1 оноо)	Хяналттай (2оноо)	Тэсвэртэй (3 оноо)	
Улаан хоолойн варикоз		Тийм	Үгүй	
Ходоодны варикоз		Тийм	Үгүй	
Билирубин	μmol/L (<34; 34-50;>50)	mg/dL (<2.2-3; >3)		
Альбумин	g/dL (>3.5; 2.8-3.5; <2.8)			
Протромбин хугацаа	Секунд (<4; 4-6; >6)	(INR):(<1.7; 1.7-2.3; >2.3)		
MELD-ийн оноо	<10; 11-18; 19-24; >25)			
ЭЛЭГНИЙ ЭСТ ХОРТ ХАВДРЫН ОНОШИЛГОО				
Тохиолдлын төрөл	Шинэ оношлогдсон	Өвчний төгсгөлийн шат	Элэг шилжүүлэн суулгасан	Нас барсан
Хавдрын маркер AFP / PiMca II		Тийм	Үгүй	Тийм бол; хариу
Дүрс оношилгоо хийсэн		Тийм	Үгүй	
Эмгэг судлалын оношилгоо (биопси) хийсэн		Тийм	Үгүй	Хийгдээгүй
Халдвэр ба бусад шалтгаан				
Гепатитын вирусийн халдвэр				
ГВВ	HBsAg	Эерэг	Сөрөг	
	HBVDNA сүүлийн хариу (IU/ml)			
	Вирусийн эсрэг эмчилгээ хийгдэж буй	Тийм	Үгүй	
	Тийм бол эмчилгээний горим			
ГДВ	Anti-HDV	Эерэг	Сөрөг	
	HDVRNA сүүлийн хариу (IU/ml)			
ГСВ	Anti-HCV	Эерэг	Сөрөг	
	HCV RNA сүүлийн хариу (IU/ml)			
	HCV генотип (genotype)			Хийгдээгүй
	ВЭШҮ эмийн эмчилгээ хийгдсэн эсэх	Тийм	Үгүй	
	Тийм бол эмийн эмчилгээний горим			
	ВЭШҮ эмийн эмчилгээ хийсэн оноо	Эхэлсэн оноо _____ / _____ / _____		Дууссан оноо _____ / _____ / _____
	ВЭШҮ эмийн эмчилгээ үр дүн (SVR 12week)	Тийм	Үгүй	
Бусад шалтгаан				
Архины хэрэглээ AUDIT С сорил (асуумж)	Оноо (1- 12): _____			
Чихрийн шижин	Тийм	Үгүй		
Элэгний вејжил /таргалалт (БЖИ)	Тийм	Үгүй	БЖИ:	
Аутоиммун гепатит	Тийм	Үгүй		
Цэсний эмгэгийн шалтгаант цирроз	Тийм	Үгүй		
Гемохроматоз	Тийм	Үгүй		
Эмийн шалтгаант	Тийм	Үгүй		

Маягт 4.

ЭХЭЭС ХҮҮХДЭД ДАМЖИХ ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ТОХИОЛДЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ХУУДАС

Эрүүл мэндийн байгууллагын нэр _____

Мэдээлсэн огноо ____/____/____

Ерөнхий мэдээлэл – Жирэмсэн эхийн бүртгэл

Жирэмсний хяналтад орсон огноо: _____	4. Хүйс <input type="checkbox"/> Эр <input type="checkbox"/> Эм
1. Эцэг эхийн нэр:	5. Утасны дугаар:
2. Өөрийн нэр:	6. Регистрийн дугаар _____
3. Нас ____/____/____	7. Оршин суугаа хаяг Аймаг / Хот _____ Сум / Дүүрэг _____ Баг / Хороо _____ Хэсэг / Хороолол _____ Газар / Гудамж / Байр _____ Тоот _____

Гепатитын вирусийн халдвартай жирэмсэн эхийн тандалт

8. Жирэмсний хэд дэх долоо хоногтойд илрүүлэг шинжилгээнд орсон эсэх:

Жирэмсний эхний 12 долоо хоногт Жирэмсний 12 долоо хоногоос дээш

9. Гепатитын В вирусийн халдвартай илрүүлэгт орсон эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	10. HBsAg илэрсэн эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
11. Гепатитын В вирусийн үржил, ачаалал тоолох шинжилгээнд хамрагдсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	12. Вирусийн шинжилгээ HBsAg зерэг, HBV-DNA >200 000 IU/ml <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
13. Гепатитын В вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	14. В вирусийн эмчилгээний тогтвортой хариу урвал илэрсэн/эдгэрсэн: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
15. Гепатитын C вирусийн халдвартай илрүүлэгт орсон эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	16. Anti-HCV илэрсэн эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
17. Гепатитын C вирусийн ачаалал тоолох шинжилгээнд хамрагдсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	18. Гепатитын C вирусийн ачаалал тодорхойлогдсон эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
19. Гепатитын C вирусийн эмчилгээг төрсөний дараа хийлгэсэн эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	20. Гепатитын C вирусийн эмчилгээний тогтвортой хариу урвал эдгэрсэн: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

Гепатитын вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхдийн тандалт

21. Гепатитын В вирусийн халдвартай эхээс төрсөн: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	23. В вирусийн халдвартай эхээс төрсөн нярайд В вирусын эсрэг иммуноглобулин тарьсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
22. В вирусийн халдвартай эхээс төрсөн нярайд 12 цагийн дотор HBV-ийн эсрэг вакцин тарьсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	24. Хүүхдийг тавт вакцины 4 тунгаар дархлаажуулнаас хойш 2 сарын дараа (7-12 сартайд) anti-HBs дархлал тогтоцын шинжилгээнд хамрагдсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
25. Дархлал тогтоцын хэмжээ: <input type="checkbox"/> > 10 IU/ml <input type="checkbox"/> > 10 - <100 IU/ml <input type="checkbox"/> > 100 IU/ml	26. Хүүхдийг 18 сартайд нь гепатитын В вирусийн илрүүлэгт хамруулсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
27. Гепатитын В вирусийн халдвартай илэрсэн эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	28. Дархлал сэргээх дархлаажуулалтыг хийлгэсэн эсэх <input type="checkbox"/> Сэргээх тун шаардлагагүй <input type="checkbox"/> 1 тун <input type="checkbox"/> 2 тун <input type="checkbox"/> 3 тун

Гепатитын вирусийн халдвартай эхийн төрсний дараах тандалт

29. Гепатитын В вирусийн эсрэг эмчилгээнд төрсөний дараа хамрагдсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	30. В вирусийн эмчилгээний тогтвортой хариу урвал/эдгэрсэн: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
31. Гепатитын C вирусийн эсрэг эмчилгээнд төрсөний дараа хамрагдсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	32. С вирусийн эмчилгээний тогтвортой хариу урвал/эдгэрсэн: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй



ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ШАЛТГААНТ ЭЛЭГНИЙ ЦИРРОЗ, ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДРЫН ТАНДАЛТЫН ЖУРАМ

НЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмаар гепатитын вирусийн халдвартын шалтаант элэгний цирроз, элэгний хорт хавдрын тохиолдлыг тандах, амбулатори болон эмнэлэгт сууринсан тандалтын тогтолцоог нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулна.

1.2 Тус журам нь гепатитын вирусийн шалтгаант элэгний цирроз, элэгний хорт хавдрын тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудад хамаарна.

1.3 Гепатитын вирусийн халдвартын үр дагаварын тандалтын тогтолцоог нэвтрүүлснээр элэгний цирроз, элэгний хорт хавдрын тохиолдлын шалтгааныг тогтоон өвчний дарамтыг үнэлэх, хүндрэл, нас баралтаас сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх үндэслэл болно.

ХОЁР. ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ҮР ДАГАВРЫН ТАНДАЛТ, ХЯНАЛТ

2.1. Элэгний циррозын тандалт, хяналт

2.1.1 Элэгний цирроз олон янзын шалтгааны улмаас элэгний цуллаг болон судасны тогтолцоо түгмэлээр гэмтэн үйл ажиллагаа бүхий эсийн тоо эрс цөөрч, элэгний хэвийн бүтэц, агууламж эвдрэн, холбогч эдийн цирроз, зангилаат бүрдэл үүсч, элэгний дутмагшил, үүдэн хараагуурын даралтын ихсэлтэнд хүргэдэг архаг даамжрах явцтай эмгэг (Өвчний олон улсын ангилал-ICD-10: кодоор элэгний фиброз ба цирроз -K74.0)-ыг тандалтад хамруулна.

2.1.2 Элэгний цирроз оношлогдсон үеэс эмчийн хяналт шаардлагатай бөгөөд элэгний циррозын хүндрэл үүсэхээс сэргийлэхийн тулд 3 сар тутамд ЦЕШ, БХШ, цус бүлэгнэлт, хавдрын маркер, хэвлэлийн хөндийн хэт авиан шинжилгээг хийнэ. 1-3 жил тутам ходоодны дуран хийж, венийн судасны өргөслийг хянана. Шаардлагатай тохиолдолд хэвлэлийн тодосгогчтой КТ шинжилгээ хийнэ.

2.2. Элэгний хорт хавдрын тандалт, хяналт

2.2.1. Европын элэг судлалын холбооны удирдамжийн дагуу дүрс оношилгооны шалгуур (нэг см-ээс бага бол хоёр аргаар, нэг см-ээс их бол нэг аргаар) эсвэл эмгэг судлалын нотлох баримтыг ашиглан тодорхойлсон тохиолдол. (Өвчний олон улсын 10-р ангилал: кодоор элэгний өмөн - C22.0, C22.9)-ыг тандалтад хамруулна.

2.2.2. Тухайн жилд багтсан анх оношлогдсон тохиолдлыг (а) шинээр оношлогдсон, (б) урд нь оношлогдож байсан (в) нас барсан болон элэг шилжүүлэн суулгасан гэж ангилна.

2.2.3. Гепатитын вирусийн халдвартай бүх өвчтөнд элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх хяналтыг хийнэ. Элэгний хорт хавдар үүсэх эрсдэлээс хамаарч идэвхитэй хяналтын товтолыг тогтооно.

2.2.3.1. Хорт хавдар үүсэх дундаж эрсдэлтэй бүлэг: Вирусийн бус шалтгаант элэгний циррозын үед 6 сар тутам хэвллийн хэт авиан шинжилгээ, элэгний үйл ажиллагаа (АЛАТ, АСАТ), хавдрын маркер АФП (боломжтой бол PIVKA II) үзэх

2.2.3.2. Хавдар үүсэх өндөр эрсдэлтэй бүлэг: Гепатитын вирусийн шалтгаант элэгний циррозын үед 3 сар тутам хэвллийн хэт авиан шинжилгээ, элэгний үйл ажиллагаа (АЛАТ, АСАТ), хавдрын маркер АФП (боломжтой бол PIVKA II) үзэх, жилд 1 удаа хэвллийн тодосгогчтой КТ хийх, шаардлагатай тохиолдолд элэгний биопси хийх, сар тутам хэвллийн хэт авиан шинжилгээ хийх

2.3. Бүртгэх

2.3.1. Гепатитын вирусийн халдвартын шалтгаант элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралтыг тохиолдлын тодорхойлолтын дагуу бүртгэж, мэдээлнэ.

2.3.2 Тэндэлжилсэн нэгжийн амбуулаторийн хоол болон сууринуудын эрхтэн судлал, халдварт, хавдрын кабинет, хэвтэн эмчлүүлэх, яаралтай тусламж, сэхээн амьдралуудын тасгийн эмч үзлэгийн явцад элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралтыг “Маягт 3. Гепатитын вирусийн халдвартын үр дагаврын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хуудас”-д аар тухай бүр бүртгэнэ.

2.3.3. Тохиолдлыг давхар мэдээлэхгүйн тулд регистрийн дугаараар Маягт 1, 2, 3-аар өмнө нь мэдээлсэн эсэхийг нягтална.

2.3.4. Элэгний цирроз, элэгний хорт хавдар, элэг шилжүүлэн суулгасан анх оношлогдсон тохиолдол бүрийг нэг удаа бүртгэнэ. Хэрэв элэгний циррозтой өвчтөн элэгний хорт хавдарт шилжвэл хорт хавдрын шинэ тохиолдлыг, элэгний цирроз эсвэл элэгний хорт хавдартай өвчтөн нас барвал нас баралтыг, элэгний цирроз, элэгний хорт хавдартай өвчтөн элэг шилжүүлэн суулгасан тохиолдлыг Маягт 3 аар даотаа бүртгэнэ.

2.4. Мэдээлэх

2.4.1. Бүртгэлийн хуудсаар бүртгэгдсэн элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралтыг “Маягт 3. Гепатитын вирусийн халдвартын үр дагаврын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хуудас”-аар цахим эсвэл цаасан хэлбэрээр тархвар судлаач эмчид долоо хоног бүрийн Даваа гаригт мэдээлнэ.

2.4.2. Статистикч/ Тархвар судлаач эмч нь цаасан хэлбэрээр ирсэн “Маягт 3. Гепатитын вирусийн халдвартын үр дагаврын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хуудас”-ыг бүрэн, зөв бүртгэсэн эсэхийг няглан цахим программд шивж ХӨСҮТ-д долоо хоног бүр мэдээлнэ.

2.4.3. Статистикч/тархвар судлаач эмч нь “Маягт 3. Гепатитын вирусийн халдвартын үр дагаврын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хуудас”-аар мэдээлэгдсэн элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралтын тохиолдлыг эмнэлгийн сарын статистик тоо мэдээлтэй тулган мэдээлэгдээгүй тохиолдлыг илрүүлж мэдээлнэ.

2.5. Үр дагаврын тандалтын тайлан, эргэн мэдээлэл

2.5.1. Тандалтын мэдээг нас, хүйс, өвчний үе шат, хүндрэлийн зэргээр нь ангилан гепатитын В, С, D вирусийн халдварын шалтгаант элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөл, нас бааралтын эзлэх хувь, халдварын бус шалтгаант архины хэрэглээ, бодисын солилцооны хам шинж, чихрийн шижин, бусад эрсдэлт хүчин зүйлсийг “бусад шалтгаан”-д хамааруулж нэгдсэн дүн шинжилгээг ХӨСҮТ улирал, жилээр тайлан гаргаж эргэн мэдээлнэ.

2.5.2. Нэгдсэн дүн шинжилгээ хийсэн тайланг улирал, жилээр Эрүүл мэндийн яаманд тайлагнана.

2.5.3. Тандалтын мэдээний чанар, шалгуур үзүүлэлтийг ХӨСҮТ улирал, жилээр Хүснэгт 3-ын дагуу дараах үзүүлэлтээр дүгнэж Эрүүл мэндийн яам, эрүүл мэндийн байгууллагуудад эргэн мэдээлнэ.

ГУРАВ. ҮР ДАГАВРЫН ТАНДАЛТЫН ТОГТОЛЦООНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

3.1 Хапдварт яячин судпалын үндэсний төв:

3.1.1. Тандалтын тогтолцоогоор ирүүлсэн тохиолдлын бүртгэл, мэдээний чанарт үнэлгээ өгч, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.1.2. Элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөл, нас бааралтын тохиолдлыг эрүүл мэндийн байгууллагаас авч нэгтгэх, давхардал байгаа эсэхийг нягтална.

3.1.3. Мэдээлэлд дараах байдлаар дүн шинжилгээ хийж улирал, жилээр тайлан гаргана. Үүнд:

3.1.3.1. Нас, хүйс, өвчний үе шат, хүндрэлийн зэргээр ангилан элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөл, нас бааралтад В, С, D вирусийн халдварын шалтгааны эзлэх хувь,

3.1.3.2. Архины хэрэглээ, бодисын солилцооны хамшинж, чихрийн шижин зэрэг халдварын бус шалтгааны эзлэх хувь,

3.1.3.3. Бусад эрсдэлт хүчин зүйлсийг “бусад шалтгаан”-д хамааруулан нэгдсэн дүн шинжилгээ хийх,

3.1.3.4. Вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан байдал

3.1.3.5. Элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэсэн өвчтөний тоон мэдээ

3.1.4. Үр дагаврын тандалтын мэдээг хугацаандаа, бүрэн, зөв мэдээлсэн эсэхийг Хүснэгт 3-ын шалгуур үзүүлэлтээр дүгнэж эргэн мэдээлнэ.

3.1.5. Гепатитын вирусийн халдварын үр дагаврын тандалтын эмч, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулна.

3.1.6. “Маягт 3”-ын дагуу цуглуулсан мэдээ, мэдээлэл нь тухайн эрүүл мэндийн байгууллага болон ХӨСҮТ-д хадгалагдах бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, тушаал, зааврын дагуу хувь хүний нууцлалыг хадгална.

3.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв:

3.2.1. H-Info программд эрүүл мэндийн байгууллагаар мэдээлэгдсэн элэгний цирроз, элэгний хорт хавдрын тохиолдлын шалтгааны оношийг бүрэн, зөв эсэхийг хянана.

3.2.2. Гепатитын вирусийн халдвартын шалтгаант элэгний цирроз, элэгний хорт хавдрын нас барагтыг баталсан тушаалын АМ7 маягтын дагуу “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ”-ээр H-Info программд мэдээлэхдээ шалтгааныг тусгасан эсэхийг хянаж, мэдээллийг бүрэн байдлыг хангулна.

3.2.3. Гепатитын вирусийн халдварт, түүний үр дагаварын тандалтын цахим програм боловсруулах, хөгжүүлэлтийг хийнэ.

3.3. Хавдар судлалын үндэсний төв:

3.3.1. Эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтнүүдийг гепатитын вирусийн халдвартын үр дагаварын тандалтын тогтолцоог хэрэгжүүлэх арга зүйгээр хангана.

3.3.2. Хавдрын үндэсний бүртгэлийн CanRegMon системд элэгний хорт хавдрын гепатитийн В, С, D вирусийн халдвартын болон бусад шалтгааныг бүртгэж мэдээлнэ.

3.3.3. H-Info программд элэгний хорт хавдрын нас барагтыг мэдээлэхдээ шалтгааны оношийг бүрэн, зөв хөтлөх талаар бүх шатлалын эмч нарт сургалт зохион байгуулна.

3.3.4. Гепатитын В, С, D вирусийн халдвартын шалтгаант элэгний хорт хавдрын бүртгэл мэдээлэл, эрт илрүүлгийн талаар ХӨСҮТ, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог хангах, тулгамдсан асуудлыг тодорхойлж шийдвэрлэн ажиллана.

3.4. Эрүүл мэндийн бусад байгууллага:

3.4.1. Эрүүл мэндийн байгууллага нь тухайн байгууллагын захирал/даргын шийдвэрээр үр дагаварын тандалтын тогтолцоог хэрэгжүүлнэ.

3.4.2. Үр дагаварын тандалтын тогтолцоог хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын дарга, амбулаторийн эрхлэгч, статистикч/тархвар судлаач эмч, дотор/элэг/, хавдар, халдварт, яаралтай тусламж, сэхээн амьдруулах тасгийн эмч, мэдээллийн мэргэжилтнээс бүрдсэн баг ажиллана.

3.4.3. Үр дагаварын тандалтаар элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөл, нас барагтын тохиолдол бүрийн давхардлыг хянаж бүртгэж мэдээлнэ.

3.4.4. Тухайн сард тандалтаар мэдээлэгдсэн элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөл, нас барагтын тохиолдлыг эмнэлгийн статистик тоо мэдээтэй тулган нягталж, мэдээлэгдээгүй тохиолдлыг илрүүлж мэдээлнэ.

3.4.5. Тандалтад хамрагдаж байгаа тохиолдлыг “Маягт 3”-ын дагуу тохиолдлын тодорхойлолтод тохирсон, мэдээлэх маягтын зөв, бүрэн хөтөлсөн эсэхэд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангана.

3.4.6. Гепатитын вирусийн халдвартын үр дагаварын тандалтын эргэн мэдээлэл, зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн байгууллагын гепатитын вирусийн халдвартын тусламж үйлчилгээнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор холбогдох журам, зааврын хэрэгжилтэд тогтмол хяналт, үнэлгээ хийх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Хяналт, үнэлгээ нь гепатитын вирусийн халдвартай тэмцэх ажилд тулгарч буй асуудлуудыг илрүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилготой. Үнэлгээ нь гепатитын вирусийн халдвартын тусламж үйлчилгээний журам, зааварт тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнд гарсан нөлөөллийг тооцох арга хэмжээ байна.

1.3. Хяналт үнэлгээг гепатитын вирусийн халдвартын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын ажлын байр ба тайлан мэдээнд нь дүгнэлт хийж үнэлнэ.

ХОЁР ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. ХӨСҮТ нь улсын хэмжээнд, аймаг, дүүрэг нь сум, өрхийн эрүүл мэндийн төвд гепатитын вирусийн халдвартын тусламж үйлчилгээний гадаад хяналт, үнэлгээг төлөвлөн, тогтмол хийж гүйцэтгэнэ.

2.2. Тухайн эрүүл мэндийн байгууллага нь гепатитын вирусийн халдвартын тусламж үйлчилгээний дотоод хяналт, үнэлгээг төлөвлөн, тогтмол хийж гүйцэтгэнэ.

2.3. Хяналт, үнэлгээг гепатитын вирусийн халдвартын тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, зохион байгуулалт, ажлын байрны сургалт, үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл, тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлно.

2.4. Хяналт, үнэлгээг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэх ба тусгай боловсруулсан хяналтын хуудсыг ашиглана.

2.5. Гепатитын вирусийн халдвартай тэмцэх үйл ажиллагааны зохион байгуулалт, хүний нөөц, багаар ажиллах чадвар, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж буй байдал зэрэгт хяналт тавина.

2.6. Гепатитын вирусийн халдвартай тэмцэх үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл, ололт амжилт, дутагдалтай талуудыг илрүүлэн дүгнэлт, зөвлөмж гаргах, эмчилгээ, хяналтын үр дүн, шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ (Хүснэгт 3).

2.7. Хяналт, үнэлгээгээний тайлан, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж нотолгоонд суурилсан мэдээллийг бодлого боловсруулах, шийдвэр гаргахад ашиглана.

2.8. Хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн биелэлт, үр дүн, зөвлөмжийг тухайн байгууллагын удирдлага, холбогдох эмч, мэргэжилтэнүүдэд танилцуулан зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавина.

ГУРАВ. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

3.1. Хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт нь гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, эмчилгээ, тусламж үйлчилгээний үр дүн, хэрэгжилтийн байдлыг тодорхойлон үйл ажиллагааг үнэлнэ.

Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2022 он	Хүрэх түвшин		
			2024 он	2025 он	2026 он
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт					
1	Тав хүртэлх насны хүүхдийн дундах гепатитын В вирусийн [HBsAg+] тархалт	0.53% (2011)	0.4%	<0.3 %	0.2%
2	100,000 хүн ам дахь гепатитын В вирусийн өвчлөлийн шинэ тохиолдол	3.3	0.6	0.4	0.3
3	100,000 хүн ам дахь гепатитын С вирусийн өвчлөлийн шинэ тохиолдол	2.4	2.9	2.7	2.5
4	Гепатитын В болон С вирусийн халдвараас үүдэлтэй элэгний хорт хавдрын шалтгаант нас барагтын түвшин (100,000 хүн амд)	5.5 (2015)	4.9	4.5	4.1
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт					
5	Нярайг төрсний дараах 24 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулсан хувь	98.5%	98.8%	99 %	99.5%
6	Тавт вакцины бүрэн тунгийн хамралтын хувь [товлолын дагуу, турван тунд хамрагдсан байх]	99.5%	96.7%	96.8%	97%
7	Гепатитын В вирусийн архаг халдвартай эхээс төрсөн нярайг 12 цагийн дотор В вирусийн эсрэг вакцин, иммуноглобулин (HBIG)-ыг хавсарч хэрэглэсэн хувь	-	70%	90%	90%
8	Гепатитын В, С, D вирусийн шалтгаант элэгний хорт хавдар, элэгний хатуурлын хувь	Тодорхой гүй	тодорхойлно	тодорхойлно	тодорхойлно

9	Тухайн жилд гепатитын В вирусийн архаг халдвартай гэж оношлогдсон иргэдээс вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь	47%	55%	60%	65%
10	Тухайн жилд гепатитын С вирусийн архаг халдвартай гэж оношлогдсон иргэдээс вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь	85%	80%	90%	90%
11	Тухайн жилд гепатитын D вирусийн халдвартай гэж оношлогдсон иргэдээс вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь	10%	40%	50%	55%
12	Гепатитын В вирусийн архаг халдвартай амьдарч байгаа иргэдээс оношлогдсон хүний эзлэх хувь	60.4%	75%	80%	85%
13	Гепатитын C вирусийн архаг халдвартай амьдарч байгаа иргэдээс оношлогдсон хүний эзлэх хувь	36%	70%	80%	85%
14	Төрийн болон олон улсын байгууллагын санхүүжилтээр хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны тоо	1	8	10	11

НОМ ЗҮЙ

- WHO, Global health sector strategies on, respectively, HIV, viral hepatitis and sexually transmitted infections for the period 2022-2030
- WHO Global progress report on HIV, viral hepatitis and sexually transmitted infections, 2021
- WHO. Guidance for country validation of viral hepatitis elimination and path to elimination, 2023
- Элэгний цирроз, түүний хүндрэлийн оношилгоо, эмчилгээний эмнэл зүйн заавар. Эрүүл мэндийн сайдын 2021 оны A694 тоот тушаал
- Сүрьеэгийн тусламж үйлчилгээний заавар. Эрүүл мэндийн сайдын 2021 оны A30 тоот тушаал
- БЗДХ, ХДХВ ДОХ тусламж үйлчилгээний заавар. Эрүүл мэндийн сайдын 2023 оны A133 тоот тушаал

7. Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл 2018 он.
8. World Health Organization. International Classification of Diseases of Oncology, ICD-O, Third edition, First Revision 2013. Өвчний олон улсын ангилал: Хавдар судлал. ӨОУА-ХС, Гутгаар дэвтэр. Орчуулга

01

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
дугаар сарын 11 өдрийн 16 дугаар
тушаалын тавдугаар хавсралт

ГЕПАТИТЫН ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ЭМНЭЛ ЗҮЙН ЗААВАР

A. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

A.1 Онош, Өвчний олон улсын 10 дугаар ангилал (ICD-10)

B16	Цочмог В гепатит Acute hepatitis B
B16.0	Цочмог гепатит В ба Дельта хавсарсан, элэгний комоор хүндэрсэн Acute hepatitis B with delta - agent, with hepatic coma
B16.1	Цочмог гепатит В ба Дельта хавсарсан, элэгний комгүй Acute hepatitis B with delta - agent, without hepatic coma
B16.2	Дельта үүсгэгчгүй, цочмог гепатит В, элэгний комоор хүндэрсэн Acute hepatitis B without delta - agent, with hepatic coma
B16.9	Дельта үүсгэгчгүй, цочмог гепатит В, элэгний комгүй Acute hepatitis B without delta - agent, without hepatic coma
B17.0	Гепатитын В вирус тээгч цочмог Дельта халдварт авсан Acute delta - (super) infection of hepatitis B carrier
B18.0	Дельта вирус хавсарсан В вируст архаг гепатит Chronic viral hepatitis B with delta-agent
B18.1	Дельта вирус хавсраагүй В вируст архаг гепатит Chronic viral hepatitis B without delta-agent

Тайлбар: Гепатитын В вирусийн халдвартын шалтгаант элэгний цирроз, элэгний хорт хавдар үүссэн бол Өвчний олон улсын 10 дугаар ангиллын дагуу үндсэн оношийг тавьж, бусад хавсарсан шалтгааны оношийг тусгана. Жишээ нь:

K74.6 Элэгний фиброз ба цирроз, B18.1 Дельта вирус хавсраагүй В вируст архаг гепатит

C22.0 Элэгний эст өмөн, B18.0 Дельта вирус хавсарсан В вируст архаг гепатит

A.2 Зааврын хэрэглэгчид

Эрүүл мэндийн байгууллагын шийдвэр гаргагч, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий эмч, мэргэжилтэн

A.3 Зорилго, зорилт

Гепатитын В вирусийн халдвартыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, хянах талаар үр дүнтэй нотолгоонд суурилсан заавар зөвлөмжөөр хангах, өвчтөнд үзүүлэх тусlamж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад чиглэнэ.

A.4 Ашигласан нэр томъёо, тодорхойлолт

Гепатитын вирусийн халдвартыг эрт илрүүлэх (Viral hepatitis screening)	Насанд хүрсэн болон халдварт өртөх эрсдэлтэй хүн амын бүлэгт гепатитын вирусийн халдвартыг эрт илрүүлэх зорилгоор хийх ийлдэс судлалын шинжилгээ
---------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг (Liver cancer screening)	Эрсдэлтэй хүн амын бүлэгт элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх зорилгоор хийх багц шинжилгээ
HBsAg зэрэг (Hepatitis B surface antigen "positive")	Гепатитын В вирусийн гадаргуугийн эсрэгтөрөгч HBsAg илрэх нь гепатитын В вирусийн халдвартайг илтгэнэ.
HBeAg зэрэг (Hepatitis B e-antigen "positive")	Вирусийн үржлийг, вирус өндөр халдвартайг илтгэнэ. Гепатитын В вирусийн халдварын явц, онош тавих үзүүлэлт болдог.
HBV-DNA тодорхойлогдох (HBV viral load)	Гепатитын В вирусийн үржлийг илтгэнэ. Вирусийн ачааллын хэмжээгээр вирусийн эмчилгээний үр дүнг хянана.
Anti-HBs	Гепатитын В вирусийн гадаргуугийн эсрэгбие anti-HBs илрэх нь вирусийн эсрэг дархлаа тогтооныг илтгэнэ.
HDV-RNA тодорхойлогдох (HDV viral load)	Гепатитын D вирусийн үржлийг илтгэнэ. Вирусийн ачааллын хэмжээгээр вирусийн эмчилгээний үр дүнг хянана.
Цочмог В гепатит (Acute hepatitis B)	Гепатитын В вирусийн халдварын явц 6 сар хүртэл үргэлжлэхийг хэлиэ
В вируст архаг гепатит (Chronic hepatitis B)	Гепатитын В вирусийн халдварын явц 6 сараас удаан үргэлжлэхийг хэлнэ.
Гепатитын В ба D вирусийн хам-халдвэр (ко-халдвэр)	Гепатитын В вирусийн халдвартгүй хүнд гепатитын В ба D вирусийн халдвэр нэгэн зэрэг илрэх
Гепатитын В ба D вирусийн давхар халдвэр (супер халдвэр)	Гепатитын В вирусийн халдвартай өвчтөнд гепатитын D вирусийн халдвэр илрэх
HBsAg сероконверс	Эмчилгээний үр дүнд HBsAg сөрөг болж, anti-HBs үүсэх
HBeAg сероконверс	Эмчилгээний үр дүнд HBeAg сөрөг болж, anti-HBe үүсэх

A.5 Тархвар зүй

Дэлхийн 240 сая хүн гепатитын В вирусийн архаг халдвартай амьдарч, жил бүр 650.000 хүн уг халдварын улмаас нас барж байгааг ДЭМБ-аас мэдээлжээ (1). Бага, дунд орлоготой улс орны хүн амын дунд элэгний хорт хавдрын 45%, элэгний циррозын 35% нь гепатитын В вирусийн шалтгаантай байна. Гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтыг нярай, бага насны хүүхдэд хийснээр сүүлийн 30 жилд халдварын шинэ тохиолдол, элэгний өвчлөл эрс буурч байна (1,15). Дэлхий дахинд 12–72 сая орчим хүн гепатитын D вирусийн халдвартайг тооцоолсон байна (1, 2, 3). Гепатитын D вирусийн 1-р генотип зонхилох бөгөөд Хойд Америк, Европ, Номхон далайн өмнөд бүс нутаг, ойрхи Дорнодод илүү тархжээ. Үүнээс Ази, Монголд 1a,

Европ ба Хойд Америкд 1b субгенотип тархсан. Гепатитын В ба D вирусийн хамгийн элэгний хорт хавдараар өвчлөгсдийн 1–3%, давхар халдвараар өвчлөгсдийн 70–80% нь архагших ба элэгний хорт хавдараар өвчлөх эрсдэл 3 дахин нэмэгддэг (1, 3, 6).

Монгол Улс 1992 оноос гепатитын В вирусийн халдварын эсрэг вакциныг дархлаажуулалтын товлолд оруулсан. Дархлаажуулалтын үр дүнд 5 хүртэлх насын хүүхдийн дундах HBsAg-ний тархалтын түвшин 0.53% болтол буурсныг 2010 оны үндэсний судалгаагаар тогтоож, ДЭМБ-ын дэвшүүлсэн зорилтод хүрсэн байна (17).

Манай улсад 2013 онд хийсэн судалгаагаар гепатитын В вирусийн халдвар нийт хүн амын дунд 11.1%-ийн тархалттай байгааг мэдээлжээ (20). Түүнчлэн гепатитын D вирусийн халдвар өргөн тархсан, HBsAg тээгч хүмүүсийн 60-аас дээш хувьд оношлогдож байна (21). Хүн амын дунд гепатитын D вирусийн 1-р генотип зонхицдог (22). Гепатитын D вирусийн шинэ халдвар ихэвчлэн залуусын дунд тохиолдож байгаа ба 2006–2008 онд гепатитын D вирусийн цочмог халдвараар өвчлөгсдийн 46%-ийг 20–29 насын хүмүүс эзэлсэн байна (15, 23).

Манай улс 100 000 хүн амд ноогдох элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт өндөр, дэлхийн дунджаас 8 дахин их байна (6). Сүүлийн 10 жилд нийт нас баралтын 15%-ийг элэгний цирроз, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт эзэлж байна. Элэгний хорт хавдрын шалтгааны 35% нь гепатитын В вирусийн, 14% нь гепатитын B, C вирусийн хавсарсан халдвартай байгааг судлаачид тогтоожээ (10,11,12,13).

Монгол улс гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, элэгний өвчин, эндэгдлийг бууруулах үйл ажиллагааг эрүүл мэндийн салбарын тэргүүлэх асуудлын нэгэнд тооцож, анхаарал хандуулж, Засгийн газраас 2017 онд “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг баталсан (7). Хөтөлбөрийн хүрээнд (2021 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар) гепатитын вирусийн халдварын эрт илрүүлэг шинжилгээнд эрүүл мэндийн даатгалтай нийт 1.099.862 иргэн хамрагдсан нь 15-аас дээш насын хүн амын 58.1 хувийг эзэлж байна. Илрүүлэг шинжилгээнд хамрагдсан хүний 89.734 иргэн буюу 8.1% нь HBsAg илэрсэн. В вирусийн эсрэг эмчилгээнд 12 мянга гаруй хүн хамрагдсан байна.

A.6 Үндсэн ойлголт

Гепатитын В вирусийн халдвар илэрсэн хүнд вирусийн үржил, элэгний үйл ажиллагааг үнэлэн харьяа нутаг дэвсгэрт нь нэн даруй эмчилгээнд хамруулах эсвэл хяналтанд оруулах тусламж үйлчилгээг хялбаршуулан хүргэх зөвлөмжийг ДЭМБ-аас гаргажээ. Хавсарсан өвчлөлтэй, ээнэгшилээ алдсан цирроэстий, 2-оос дээш насын хүүхдийг лавлагаа шатны эмнэлэгт төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтанд эмчилгээг эхлүүлнэ. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эмэгтэйд эхээс хүүхдэд халдвар дамжихыг таслан зогсоох тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Гепатитын B ба D вирусийн халдварын үед тусламж үйлчилгээг өвчтөнд ойртуулах, шуурхай болгох зорилгоор хялбаршуулсан горимыг танилцуулж байна. Эрт илрүүлгээр HBsAg эерэг илэрсэн тохиолдолд вирусийн ачаалал (HBV-DNA) болон гепатитын D вирусийн халдварыг тодорхойлох “рефлекс” шинжилгээг хийж, эмчилгээнд хамруулах, хянах шаардлагатай (Зураг Б.1).

A.7 Эрүүл мэндийн боловсрол

Гепатитын B ба D вирусийн халдвар нь цусаар дамжих ба эрт оношилж, эмчилүүлэхийн ач холбогдлыг ойлгуулах нь чухал юм. Гепатитын B ба D вирусийн халдвар авсан хүн эрт илрүүлэгт хамрагдаж, эрт оношилж, эмчилж, хянаснаар элэгний цирроз, элэгний хорт хавдар түүний хүндэрлээс сэргийлэх талаар

тайлбарлана. Элэгний циррозтой бол нас харгалзахгүй гепатитын В вирусийн эсрэг эмчилгээг эхлэх, вирусийн эсрэг эм ууснаар циррозын хүндрэлээс сэргийлэх ба элэгний циррозын хяналт болон элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт (хэвлийн хэт авиан шинжилгээ болон АФП) З сар тутамд хамрагдаж эмчийн байнгын хяналтанд байх шаардлагатайг зөвлөнө. Бүх хүмүүст амьдралын эрүүл хэв маягийг мөрдөх талаар эрүүл мэндийн боловсрол олгох зөвлөгөөг өгнө.

Б. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ

Б.1 Эрт илрүүлэг

ДЭМБ-аас зөвлөсөн түргэвчилсэн оношлуураар гепатитын В вирусийн халдварт илрүүлэх шинжилгээг хийнэ. Шинжилгээний хариу эерэг буюу HBsAg илэрсэн тохиолдолд рефлекс шинжилгээ хийх буюу тэр даруй anti-HDV, HBV-DNA тодорхойлох шинжилгээ хийнэ.

Эрсдэлд суурилсан илрүүлэг

Гепатитын вирусийн халдварт өртөх эрсдэлтэй бүлгийн хүн амд халдварт илрүүлэх шинжилгээг хийнэ. Үүнд:

- Эрхэлсэн ажил мэргэжлээс хамаарах эрсдэлтэй бүлэг
- Эрүүл мэндийн байдлаас хамаарах эрсдэлтэй бүлэг
- Амьдралын хэв маяг, бэлгийн зан үйлээс хамаарах эрсдэлт бүлэг

Хүн амд суурилсан илрүүлэг (universal)

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2017–2020 онд 15-аас дээш насын иргэдийг гепатитын вирусийн халдвартын эрт илрүүлэгт хамруулсан. 2022 оны 5 сараас эхэлсэн хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн хийж буй эрт илрүүлгийн хүрээнд 18-аас дээш насын хүмүүст гепатитын С ба В вирусийн халдвартыг илрүүлэх шинжилгээг хийж байна.

Жирэмсэн эхийн илрүүлэг


Жирэмсэн эмэгтэй бүрт гепатитын С ба В вирусийн халдварт илрүүлэх шинжилгээг (anti-HCV, HBsAg) хийнэ. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхээс хүүхдэд халдварт дамжихыг таслан зогсоох тусламж үйлчилгээг үзүүлж, хүүхдэд гепатитын В вирусийн эсрэг дархлаа тогтоцыг шалгана.

Б.2 Халдвартыг илрүүлэх, ачаалал тодорхойлох шинжилгээ

Гепатитын вирусийн илрүүлэг ба вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээг Эрүүл мэндийн сайдын “Заавар, техникийн тодорхойлолт батлах тухай” тушаалын дагуу хийж гүйцэтгэнэ.

Гепатитын В вирусийн халдварт өртсөн эсэхийг илрүүлэхийн тулд HBsAg тодорхойлох шинжилгээ хийнэ. HBsAg эерэг илэрсэн хүмүүст anti-HDV, HBV-DNA, HDV-RNA тодорхойлж хавсарсан халдвартыг оношилно (Зураг Б.1).

Эмнэл зүйн шийдвэр гаргаж, эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх зорилгоор шинжилгээнд сорьц авч, рефлекс шинжилгээний зарчмыг баримтлан хариуг өвчтөнд эсвэл асран хамгаалагчид даруй өгнө. Рефлекс шинжилгээг лабараторид ба эмнэлэгт суурилсан 2 аргаар хийнэ.



Зураг Б.1 Гепатитын В ба D вирусийн халдварын эрт илрүүлэг

Лабораторийт суурилсан рефлекс шинжилгээ нь өвчтөнд эмчийн үзлэг хийж, HBsAg илрүүлэх шинжилгээ (зарим тохиолдолд хоёр хуруу шилэнд цус авж болно) хийж, эерэг байвал одоо байгаа эсвэл давхар авсан сорьцыг лабораторийт илгээж, HBV-DNA тодорхойлох, anti-HDV илрүүлэх "рефлекс" шинжилгээг хийж, өвчтөн ба эмчид шинжилгээний хариуг хүргүүлнэ. Өвчтөн дахин ирэх, өвчтнөөс дахин сорьц цуглуулах шаардлагагүй.

Эмнэлэгт суурилсан рефлекс шинжилгээ нь зөвхөн анх удаа эмнэлэгт ирэхэд HBsAg илрүүлэх шинжилгээг түргэвчилсэн аргаар хийх ба хоёр удаа цус авах стратегийг хэлнэ. Хэрэв эерэг бол HBV-DNA тодорхойлох, anti-HDV илрүүлэх шинжилгээнд зориулан (ихэвчлэн 15 минут хүлээсний дараа) тэр даруй хоёр дахь сорьцийг авч HBV-DNA, HDV IgM, HDV IgG, HDV-RNA үзэхээр лабораторийд илгээнэ.

В. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ

В.1 Эмнэл зүйн явц

Гепатитын В вирусийн HBsAg ийлдсэнд 6 сараас дээш хугацаанд эерэг байх тохиолдолд В вирусийн архаг халдвэр гэж үзнэ.

Гепатитын В вирусийн халдварын эмнэлүйн явц нарийн төвөгтэй, өвчний даамжрал нь хэд хэдэн үе шатыг дамжин өөрчлөгддөг (Хүснэгт В.1). Гепатитын эмнэл зүйн үе шатыг зөвхөн ийлдэс судлалын үзүүлэлтээр оношлох нь учир дутагдалтай, эдгээр үе шатууд харилцан адилгүй үргэлжлэх ба зарим тохиолдолд хооронд нь зааглаж ялгах төвөгтэй, заримдаа вирусийн эмчилгээ эхлэх шууд заалт болж чадахгүй тохиолдол ч бий.

Гепатитын В вирусийн халдварын явцыг дараах үе шатаар ангилаа. Үүнд:

HBeAg зэрэг архаг халдвар - *HBsAg* зэрэг байгаа хүүхэд, залуу хүмүүст тохиолддог. Энэ үед ийлдсэнд *HBeAg* зэрэг илэрч, *HBV-DNA* ачаалал (200.000 IU/ml-ээс их) өндөр, АЛАТ-ын түвшин хэвийн буюу ялимгүй ихэсдэг. Элэгний эсэд вирусийн үржил хэдий идэвхтэй явагдах боловч эзэн биеийн дархлаа тэвчилтэй холбоотойгоор элэгний эдийн үрэвсэлт өөрчлөлт нэн сул, элэгний фиброз хараахан үүсээгүй байх болно. Энэ үед *HBV-DNA* ачаалал өндөр тул халдвар тараах магадлал өндөртэй байдаг.

HBeAg зэрэг архаг гепатит - *HBeAg* илэрсэн, дархлаа хариу урвал ба элэгний үрэвсэл идэвхтэй үе. Ийлдсэнд АЛАТ-ын хэмжээ нэмэгдэж, *HBV-DNA* ачаалал хэлбэлзэж байдаг. Элэгний үрэвсэл эмнэл зүйн шинж мөн эдийн шинжилгээнд үрэвсэл, сорвижил тод илэрнэ. Энэ үе хэдэн долоо хоногоос хэдэн арван жил үргэлжлэх ба *HBeAg* арилж, anti-HBe үүсч ийлдэс хувирал (сероконверс) болон *HBV-DNA* ачаалал буурч, *HBeAg* сөрөг архаг халдварт шилжиж болох юм.

HBeAg сөрөг архаг халдвар - *HBeAg* арилж, anti-HBe үүсч ийлдэс хувирал-сероконверс болсон сайжралын дараагаар үүсдэг. *HBeAg* арилсан бол архаг өвчлөл зогсож, элэгний сорвижилт saatаж, АЛАТ хэвийн болж, *HBV-DNA* маш бага (<2000 IU/ml) эсвэл тодорхойлогдохгүй болно. *HBeAg* арилах явдал залуу насанд, элэгний эмгэг хүндрэхээс өмнө үүсвэл элэгний цирроз, элэгний хорт хавдар үүсэх эрсдэлийг эрс бууруулж, тавилан нааштай байдаг. Энэ үед *HBsAg* сөрөг болох буюу сероконверс жилд 1–3% тохиолдох нь бий. Эдгээр өвчтөнүүдийн q*HBsAg* түвшин ихэвчлэн бага буюу 1000IU/ml-ээс доош байдаг.

HBeAg сөрөг архаг гепатит - *HBeAg* сөрөг, anti-HBe зерэг дархлаа идэвхгүй үедээ байгаа боловч АЛАТ ба *HBV-DNA* хэмжээ ихэсч, үхжилт үрэвслийн шинж тэмдэг заримдаа хөнгөн, заримдаа ихэсч хэлбэлзэнэ. Элэгний цирроз үүсэх нь давшигүй явцтай байдаг. Энэ үед гепатитын В вирус үржлийн үедээ байгаа боловч вирусийн геномын цөм-орчим, цөм-суурь хэсэгт явагдах мутаци өөрчлөлтийн улмаас *HBeAg* ялгаруулахаа зогсдог.

HBsAg сөрөг үе: *HBsAg* сөрөг, anti-HBc зэрэг, anti-HBs зэрэг эсвэл сөрөг тодорхойлогдож болох үе юм. Энэ үеийг зарим үед “далд гепатитын В вирусийн халдвар/occult HBV infection” гэж нэрлэдэг. Энэ үед өвчтөний цусанд АЛАТ хэвийн байх ба *HBV-DNA* ихэнхидээ тодорхойлогдохгүй байдаг. Харин элгэнд *HBV-DNA* (cccDNA) тодорхойлогдож байдаг. *HBsAg* сөрөг болох нь элэгний цирроз, хорт хавдар зэрэг хүндрэл үүсэх эрсдлийг багасгана. Харин цирроэст хүнд *HBsAg* сөрөг болсон ч элэгний хорт хавдрын эрсдэл өндөр хэвээр байх тул элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт хамруулна. *HBsAg* ба *HBV-DNA* тодорхойлогдохгүй боловч anti-HBc зэрэг байгаа хүнд дархлаа дарангуйлах эмийн нөлөөгөөр гепатитын В вирус идэвхижих боломжтой.


Хүснэгт В. 1. Гепатитын В вирусийн архаг халдварын үе шат

Үзүүлэлт	<i>HBeAg</i> зэрэг		<i>HBeAg</i> сөрөг	
	Архаг халдвар	Архаг гепатит	Архаг халдвар	Архаг гепатит
<i>HBsAg</i>	Маш өндөр	Өндөр/дунд зэрэг	Бага	Дунд зэрэг
<i>HBeAg</i>	Эерэг	Эерэг	Сөрөг	Сөрөг

HBV-DNA	$>10^7$ IU/ml	10^4 – 10^7 IU/ml	<2000 IU/ml	>2000 IU/ml
АЛАТ	Хэвийн	Өндөр	Хэвийн	Өндөр
Элэгний эмгэг (фиброз)	Байхгүй/бага зэрэг	Дунд/хүнд хэлбэр	Байхгүй	Дунд/хүнд хэлбэр
Хуучин нэршил	Дархлаа тэвчил үе	HBsAg зэрэг дархлаа-идэвхитэй үе	Идэвхигүй тээгч	HBsAg сөрөг архаг гепатит

B.2 Ерөнхий ба бодит үзлэг, багажийн шинжилгээ


Гепатитын В вирусийн халдвартай өвчтөнд вирусийн эсрэг эмчилгээг эхлэхийн өмнө вирусийн ачааллыг тодорхойлж, элэгний фиброз/циррозыг үнэлж, элэгний үйл ажиллагаа, цусны дэлгэрэнгүй шинжилгээ, бөөрний үйл ажиллагаа, хавсарсан өвчин болон эмийн хэрэглээг үнэлнэ (Зураг B.1).




Зураг B.1 Гепатитын В вирусийн халдвартын оношилгоо, эмчилгээний хяналт

B.2.1 Вирусийн ийлдэс судалын шинжилгээ

Гепатитын В вирусийн халдвартын үе шатаас хамаарч харилцан адилгүй хугацаанд вирусийн эсрэгтөрөгч ба эсрэгбиийн уургууд ийлдсэнд илэрдэг (Зураг B.2, B.3).



Зураг B.2 Гепатитын В вирусийн цочмог халдвартын үеийн ийлдсийн шинжилгээ



Зураг B.3 Гепатитын В вирусийн архаг халдвартын үеийн ийлдсийн шинжилгээ

Гепатитын В вирусийн халдвартыг оношлох, үнэлэхдээ ийлдэс судалын дараах үзүүлэлтийг ашигладаг (Хүснэгт B.2, B.3).

Хүснэгт B.2. Гепатитын В вирусийн ийлдэс судалын үзүүлэлтуүдийн тайлбар

Үзүүлэлт	Тайлбар
HBsAg	ГВВ-ийн халдвартайг илэрхийлэх анхдагч үзүүлэлт бөгөөд цочмог ба архаг халдвартын аль алинд цусанд илэрдэг. 6 сараас дээш хугацаанд цусанд илэрсэн үед ГВВ-ийн архаг халдварт гэж үзнэ. Зарим тохиолдолд HBsAg цусанд илрэхгүй боловч HBV-DNA илрэх нь далд халдвартыг илэрхийлнэ.
Anti-HBc	Гепатитын В вирусийн цөмийн эсрэгтөрөгчийн эсрэг IgM эсрэгбие

IgM	HBsAg илэрснээс хойш 2 долоо хоногийн дараа илэрдэг. HBsAg ба HBeAg илрээгүй цонх үеийн гепатитын В вирусийн халдвартыг оношлох гол үзүүлэлт юм. Цочмог В гепатитын гол шалгуур бөгөөд энэ үед anti-HBc IgM таньц өндөр. Өвчний явцад HBsAg арилж, anti-HBs бий болохын өмнө цонх үеийг anti-HBc IgM бөглөж, халдвартайг илтгэнэ. Архаг В гепатитын үед заримдаа цусанд илэрч болох ба цочмог үеэс ялгаатай нь эсрэгбиесийн таньц нь арай бага байдаг
Anti-HBc	Гепатитын В вирусийн цөмийн эсрэгбие (нийт) Гепатитын В вирусээр халдварлагдсан хүн бүрт халдварын дараах 4–10 долоо хоногоос вирусийн цөмийн эсрэгбие үүсэж, насан туршид хадгалагддаг. Зарим тохиолдолд гепатитын В вирусийн халдварын далд хэлбэрийг оношлох цорын ганц арга болдог ба энэ үед ийлдсэнд HBsAg ба anti-HBs серөг, харин HBV-DNA тодорхойлогддог. anti-HBc эерэг өвчтний 10-аас бага хувьд гепатитын В вирус идэвхтэй үржиж байдаг. Тухайн хүн урьд өмнө нь гепатитын В вирусийн халдвар авсан эсэхийг тогтоодог. Энэ шинжилгээ нь донор сонгоход чухал ач холбогдолтой
HBcAg	Гепатитын В вирусийн цөмийн эсрэгтөрөгч Гепатитын В вирусийн нуклеопротейны бүрэлдэхүүн, гадуураа байнга уурагт бүрхүүлтэй тул дангаараа захын цусанд тодорхойлогдохгүй. Нуклеоз(т)идын эм хэрэглээгүй үед гепатитын В вирусийн хэмжээг, нуклеоз(т)идын эм хэрэглэсэн үед элэгний эсийн доторх гепатитын В вирусийн cccDNA-ийн хэмжээг илтгэнэ
HBeAg	Гепатитын В вирусийн HBcAg-ийн задралын бүтээгдэхүүн ө эсрэгтөрөгч HBsAg илэрснээс хойш 3–5 хоногийн дараа ийлдсэнд илэрнэ HBV-DNA-тэй хамт илрэх нь вирус элгэнд үржиж, цусаар бүхэл бүтэн вирус эргэлдэж буйг харуулахаас гадна халдвартай байгааг илтгэнэ Цочмог гепатитын үед HBsAg арилахаас 2–4 долоо хоногийн өмнө, эсвэл HBsAg арилснаас хойш 1–7 хоногийн дараа цуснаас арилна. Зарим тохиолдолд цочмог халдварын үед HBeAg хэдхэн хоног, цөөн долоо хоногийн турш илрэх тул цочмог халдварын үед анх удаа шинжлэхэд сөрөг гарч болно. Удаан хугацааны турш HBeAg эерэг хүнд халдвар идэвхтэй байгааг илэрхийлнэ.
Anti-HBe	Гепатитын В вирусийн ө эсрэгбие. Ердийн үед цочмог В гепатитаар өвчлөгсөд, архаг тээгч хүмүүсийн ийлдсэнд тодорхойлогддог. Архаг В гепатитын үе шатыг тогтоох оношилгоонд ихэвчлэн хэрэглэнэ.
Anti-HBs	Гепатитын В вирусийн гадаргуугийн эсрэгбие. Цочмог В гепатитын здгэрэлтийн шатанд ийлдсэнд тодорхойлогдох ба энэ үед anti-HBc эерэг байна. Вакцины дараа үүсэх дархлааны үед anti-HBs илэрч, харин anti-HBc илрэхгүй.

HBV-DNA	Гепатитын В вирусийн дезоксирибонуклейн хүчил (HBV-DNA) Вирусийн идэвхтэй үржлийг харуулдаг үндсэн үзүүлэлт. HBsAg илэрсэн өвчтөнд шинжилнэ. Архаг В гепатитын сэжигтэй anti-HBc зерэг тохиолдолд тодорхойлох шаардлагатай. Вирусийн эсрэг эмчилгээний үед HBV-DNA тодорхойлогдохгүй байвал эмчилгээ үр дүнтэй болохыг илтгэнэ. Гепатитын В вирусийн эсрэг эмэнд тэсвэртэй мутант үүсч байгаа эсэхийг хянахын тулд HBV-DNA шинжилгээг 6–12 сар тутамд хийж байх шаардлагатай.
HBV-генотип	Генотипийн шинжилгээ нь халдварт дамжих зам, өвчний тавилан, вирусийн эсрэг эмчилгээг сонгоход ач холбогдолтой.
Pre C, CP	Гепатитын В вирусийн генийн мутаци. Өвчний үе шатыг зөв үнэлэх, өвчний тавиланг тогтооход ашиглана.
HBsAg quantitative	Гепатитын В вирусийн гадаргуугийн эсрэгтөрөгчийг тоон аргаар илэрхийлэх шинжилгээ өвчний тавиланг тодорхойлох, эмчилгээний үр дүнг хянана. qHBsAg түвшин буурах нь эмчилгээ үр дүнг илтгэнэ.

Хүснэгт В.3. Гепатитын В вирусийн халдвартын илрүүлэлт шинжилгээний үзүүлэлтийг эмнэл зүйд хэрэглэх

Ийлдэс судлалын үзүүлэлт ба үр дүн	Эмнэл зүйн дүгнэлт
HBsAg (-), anti-HBc (-), anti-HBs (-)	Асуумжаар гепатитын В вирусийн цочмог халдвартыг үгүйсгэх хэрэгтэй
HBsAg (-), anti-HBc (+), anti-HBs (+)	Халдвартын дараах дархлаа тогтсон
HBsAg (-), anti-HBc (-), anti-HBs (+)	Вакцины дараах дархлаа тогтсон
HBsAg (+), Anti-HBc (+), Anti-HBc IgM (+), anti-HBs (-)	Гепатитын В вирусийн цочмог халдварт
HBsAg (+), Anti-HBc (+) Anti-HBc IgM (-), anti-HBs (-)	Гепатитын В вирусийн архаг халдварт
HBsAg (-), anti-HBc (+), anti-HBs (-)	Үрьд нь халдварт авсан (ихэнхдээ) эсвэл Anti-HBc хуурамч зерэг эсвэл Идэвхи багатай архаг халдварт эсвэл Цочмог халдварт эдгэрч байгаа

B.2.2 Элэгний фиброз, циррозыг үнэлэх

Гепатитын В вирусийн эсрэг эмчилгээг эхлүүлэхийн өмнө элэгний фиброзыг үнэлэх ба энэ нь эмчилгээний горим, эмчилгээний хугацааг сонгоход дөхөм болно. Элэгний фиброзыг үнэлэх хатгалтын ба хатгалтын бус аргууд байдаг.

Элэгний фиброз үнэлэх хатгалтын арга: Элэгний эдийн шинжилгээ (элэгний биопси) нь элэгний фиброз, цирроз оношлох алтан стандарт арга. Шалтгаан тодорхойгүй элэгний үйл ажиллагааны өөрчлөлт илрэх, аутоиммун гепатит, цирроз, элэгний хорт хавдрын сэжигтэй үед хийнэ.

Элэгний фиброзын зэргийг үнэлэх хатгалтын бус арга: APRI оноо (<https://www.mdcalc.com/calc/3094/ast-platelet-ratio-index-apri>), FIB-4 оноо

(<https://www.mdcalc.com/calc/2200/fibrosis-4-fib-4-index-liver-fibrosis>) тооцох аргаар дунд зэргийн сорвижлыг METAVIR-ийн үнэлгээгээр F2-F3 (Хүснэгт В.4) тогтоох боломжгүй боловч эдгээр аргууд нь хямд, хэрэглэхэд хялбар тул эмчилгээний загварыг сонгоход тустай. Ялган оношлох шаардлагатай тохиолдолд элэгний фиброзийг тодорхойлох хатгалтын ба хатгалтын бусад аргыг хэрэглэнэ.

Орчин үед элэгний биопсийн шинжилгээний хүндрэл (өвдөлт, цус алдах гэх мэт), олон дахин хийх боломжгүй зэргээс шалтгаалан хатгалтын бус аргаар элэгний фиброзыг тодорхойлох шинжилгээг эмнэл зүйд өргөнөөр ашиглаж байна.

Фиброскан, транзит эластографи нь оношилгооны нарийвчлал сайтай давтан шинжлэхэд аюулгүй зэрэг давуу талтай, элэгний фиброзыг үнэлэх инвазив бус аргын төлөөлөл юм. Өвчтөнд 10 удаагийн амжилттай хэмжилт хийн дундаж утгаар хариу гарна. Даамжирсан фиброзын босго утга 7.5 кПа байна.

Хүснэгт В.4. Элэгний фиброзыг тодорхойлох METAVIR үнэлгээний систем

METAVIR үнэлгээ	F0	F1	F2	F3	F4
	Фиброзгүй	Бага фиброз	Дунд фиброз	Илт фиброз	Элэгний цирроз

B.2.3 Элэгний эмгэг ба хүндрэл оношлох, үнэлэх стандарт шинжилгээ

Лабораторийн шинжилгээ: ЦЕШ, элэгний үйл ажиллагаа (ACAT, АЛАТ, ГПТП, нийт ба шууд билирубин, шүлтлэг фосфотаза, альбумин, нийт уураг), INR, бөөрний үйл ажиллагаа (креатинин), сахар, холестерин, триглициерид, их нягтралт, бага нягтралт липопротейд, бамбайн даавар (TSH, T3, T4), натри ба элэгний хавдрын маркер (АФП, боломжтой бол PIVKA II)

Элэг гэмтээгч бусад шалтгааныг ялгах шаардлагатай үед: Халдвэр (ХДХВ/ДОХ, гепатитын бусад вирусийн халдвэр), Элэгний аутоиммуны маркер

Дүрс оношилгооны аргууд: Хэвлэлийн хэт авиан шинжилгээ, шаардлагатай тохиолдолд хэвлэлийн тодосогчтой КТ, соронзон резонанс томографи MRI шинжилгээг хийнэ.

Улаан хоолой, ходоодны уян дуран: улаан хоолой, ходоодны варикоз үнэлэх

B.2.4 Хавсарсан өвчин ба эмийн харилцан үйлчлэл үнэлэх

Вирусийн эмийн харилцан үйлчлэлийг эм жор бичих эсвэл хяналтын үзлэг бүрт дахин (<https://uptodate.druginteractions.org/>; <https://www.hep-druginteractions.org/>) хэрэглэж байгаа эмийг асууж тодруулан шалгахыг зөвлөж байна.

B.2.5 Архины хэрэглээг тодорхойлох, зөвлөгөө өгөх

Гепатитын В вирусийн халдвартай хүн бүрт архины хэрэглээг үнэлж, дунд ба өндөр хэрэглээтэй бол зан үйлийг бууруулах арга хэмжээг эхлэх хэрэгтэй.

Архи, тамхи, мансууруулах сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ, эрсдэлийг эрт илрүүлэхэд ASSIST (Alcohol, Smoking, Substance Involvement Screening Test) сорилыг ашиглана. ASSIST нь сэтгэц нөлөөт зан үйлийг илрүүлэхэд чиглэсэн ДЭМБ-ын зөвлөмж бөгөөд эрүүл мэндийн анхан шатны байгууллагад түгээмэл хэрэглэдэг сорил юм.

ASSIST сорил нь дараах 3 хэсгээс бүрддэг.

- ASSIST эрт илрүүлгийн асуумж
- ASSIST сууринласан эрсдэлт зан үйлийг запруулах зөвлөмж
- Өөрөө өөрийгөө үнэлж, эрсдэлт зан үйлээс татгалзах, өөрийгөө өөрчлөх зөвлөмж

ASSIST зөвлөмж нь 5-10 минут орчим стандарт ярилцлага хийж, эрсдэлт оноог үнэлэн, тусlamж үзүүлэх түвшинг тодорхойлдог. Дараах 3 түвшний эрсдлийг илрүүлнэ: Үүнд:

- Бага эрсдэлтэй: тусlamж, зөвлөгөө шаардлагагүй
- Дунд эрсдэлтэй: энгийн тусlamж хэрэгтэй
- Өндөр эрсдэлтэй: зан үйлийг үнэлэх, эмчлэх мэргэжилтэн шаардлагатай.

B.3. Вирусийн эсрэг эмчилгээ

Уламжлалт интерфероноос эхлэн, уртасгасан үйлчилгээт интерферон гарч, нуклеоз(т)идын аналог эмийг хэрэглэж, сүүлийн 30 жилд эмчилгээний үр дүн сайжирсан. Одоогоор гепатитын В вирусийн эсрэг дараах эмийг (ламибудин, адефовир, энтекавир, телбевудин, тенофовир, пег-интерферон) хэрэглэж байгаа бөгөөд элэгний циррозын даамжралыг зогсоон, элэгний хорт хавдар үүсэх эрсдлийг бууруулж, амьдрах хугацааг уртасгаж буйг нотолжээ (Хүснэгт B.6).

Нуклеоз(т)идын аналог эмүүд гепатитын В вирусийн полимеразад нөлөөлөх бөгөөд үйлчлэл нь харилцан адилгүй, тухайлбал адефовир транскрипц даих явцыг saatuuлах, ламибудин, тенофовир нь ДНХ-ийн утаслаг нийлэгжилтийг saatuuлах, энтекавир вирусийн үржлийн (репликацын) үе шатанд нөлөөлдөг. Эдгээр эмүүд үйлчлэх механизм, фармокинетик, үйлдлийн хүч, тэсвэржилт үүсэх чадлаараа ялгаатай.

Хүснэгт B.6. Гепатитын В вирусийн халдвартын үед насанд хүрэгчдэд хэрэглэх вирусийн эсрэг эмчилгээ

Эмийн нэр	Тун
Тенофовир алафенамид TAF	25 г хоногт нэг удаа уух
Тенофовир дизопроксил фумарат TDF	300 мг хоногт нэг удаа уух
Энтекавир ETV	0.5 мг хоногт нэг удаа уух
Энтекавир (ламибудин хэрэглэж байсан)	1 мг хоногт нэг удаа уух
Пег-интерферон альфа-2a	180 mcg 7 хоногт нэг удаа арьсан дор тарих
Пег-интерферон альфа-2b	0.5 эсвэл 1.0 mcg 7 хоногт нэг удаа арьсан дор тарих

Нуклеоз(т)ид аналог эмүүд гепатитын В вирусийн үржлийг saatuuлах боловч HBsAg-ийг арилгаж, вирус бүрэн устгах үйлдэлгүй тул урт хугацаагаар эмчилгээнд хэрэглэх шаардлагатай. HBeAg (+) эерэг, 30-аас доош насны өвчтөнд пег-интерферон хэрэглэвэл богино хугацаанд е антигений сероконверс үүснэ.

Гепатитын В вирусийн эмчилгээ эхлүүлэх заалттай тохиолдолд вирусийн эсрэг эмчилгээнд нуклеоз(т)ид аналог эсвэл пег-интерферон эмчилгээ хийх гэсэн 2 сонголт байна (Хүснэгт B.8).

Хүснэгт В.7 Гепатитын В вирусийн эсрэг эмчилгээний сонголт

Эмчилгээний сонголт	Нуклеоз(т)идын аналог эм	Пег-интерферон
1 дүгээр сонголт	Тенофовир алафенамид Тенофовир дизопроксил фумарат Энтекавир	Пег-интерферон альфа-2a Пег-интерферон альфа-2b
2 дугаар сонголт	Ламивидин Телбивудин Адефовир	

Хүснэгт В.8 Нуклеоз(т)ид аналог ба пег-интерферон эмчилгээний сул ба давуу талууд

	Нуклеоз(т)ид аналог эм	Пег-интерферон альфа-2a/2b
Эмчилгээний өмнө		HBV-DNA>10 ⁸ Log, АЛАТ>3 дахин их, ГДВ халдвартай, элэгний үрэвслийн идэвхжил >A2
Эмчилгээний үед	HBeAg эерэг тохиолдолд эмчилгээний 24 ба 48 дахь долоо хоногт HBV-DNA тодорхойлогдохгүй болох нь HBeAg сероконверс болох магадлалтайг харуулна	HBeAg эерэг тохиолдолд эмчилгээний 12 дахь долоо хоногт HBV-DNA тодорхойлогдохгүй болох нь HBeAg сероконверс болох магадлал 50%, HBeAg сөрөг тохиолдолд вирусийн тогтвортой хариу урвал ёгөх магадлал 50% байна
HBsAg буурах	Эмчилгээний 12 ба 24 дэхь долоо хоногт HBsAg-ний түвшин буурах нь HBsAg сероконверс болох магадлалтайг харуулна	
HBV- генотип	Эмчилгээнд HBV-DNA тодорхойлогдохгүй болох нь ГВВ-ийн генотипээс үл хамаарна. Харин А, D генотипд HBsAg сероконверс болох магадлал өндөр	Эмчилгээний үр дүн генотип А, В үед өндөр
Хэрэглэх арга	Ууж хэрэглэнэ	Тарьж хэрэглэнэ
Эмчилгээ үргэлжлэх хугацаа	Тодорхойгүй	48 долоо хоног
Гаж нэлөө	Бага	Их

B.3.1 Эмчилгээ эхлэх заалт

Гепатитын В вирусийн эмчилгээг АЛАТ-ын идэвхижил, HBV-DNA түвшин, элэгний цирроз, наснаас хамаарч эхэлнэ.

Хүснэгт В.9 Гепатитын В вирусийн эсрэг эмчилгээ эхлэх ба эмчилгээ хийхгүй заалт

Заалт	Тайлбар
Эмчилгээ ЭХЛЭХ заалт	<p>Элэгний циррозтой ($APRI > 2$ насанд хүрэгсдэд), гепатитын В вирусийн халдвартай бүх насын хүмүүст (насандаа хүрэгсэд, хүүхэд) эмчилгээг нэн даруй эхлэх заалттай. Элэгний циррозийн эзэнэшилтэй үе шатанд АЛАТ-ын идэвхжил, HBeAg, HBV-DNA хэмжээнээс үл хамаарч эмчилгээг эхэлнэ</p> <p>Элэгний циррозгүй ($APRI < 2$ насанд хүрэгсдэд), гепатитын В вирусийн халдвартай 30-аас дээш насы, АЛАТ байнга идэвхжилтэй, HBeAg зөрөг бол HBV-DNA өндөр ($> 20\,000$ IU/ml), HBeAg сөрөг бол HBV-DNA (> 2000 IU/ml) эмчилгээг эхэлнэ</p>
Эмчилгээ ХИЙХГҮЙ заалт	<p>Элэгний циррозгүй ($APRI < 2$ насанд хүрэгсдэд), АЛАТ тогтвортой хэвийн, HBV-DNA хэмжээ бага (< 2000 IU/ml) гепатитын В вирусийн халдвартай бүх насын хүмүүст (насандаа хүрэгсэд, хүүхэд) эмчилгээ шаардлагагүй бөгөөд HBeAg илрэл ба нас нөлөөлөхгүй.</p> <p>Элэгний циррозгүй, HBV-DNA > 20000 IU/ml өндөр боловч АЛАТ тогтвортой хэвийн байх 30-аас доош насын хүмүүс HBeAg илрээгүй, элэгний циррозгүй, АЛАТ тогтвортой хэвийн байх, HBV-DNA 2000–20000 IU/ml хэлбэлзэдэг 30-аас доош насын хүмүүс HBV-DNA шинжлэх боломжгүй бол HBeAg илэрцээс үл хамаарч АЛАТ тогтвортой хэвийн, элэгний циррозгүй 30-аас доош насын хүмүүст</p> <p>Вирусийн эсрэг эмчилгээ шаардлагагүй гепатитын В вирусийн халдвартай насандаа хүрэгчид, хүүхдэд элэгний өвчин даамжралыг хянах, эмчилгээний заалтыг тодорхойлохын тулд байнгын хяналт хэрэгтэй.</p>

B.3.2 Эмчилгээ зогсоох заалт

Гепатитын В вирусийн HBeAg зөрөг үед нуклеоз(т)ид аналог эмээр эмчилгээг эхлүүлсэн бол HBeAg сероконверс (HBeAg сөрөг, anti-HBe зөрөг) болсноос хойш 12 сар эмээ уугаад зогсоох боломжтой. Харин HBeAg сөрөг үед нуклеоз(т)ид аналог эмийн эмчилгээг HBsAg арилтал уух заалттай ч дээрх эмчилгээний үед HBsAg арилах магадлал жилд 1–5% гэж үздэг. Иймд удаан хугацаагаар нуклеоз(т)ид аналог эмийн эмчилгээг үргэлжлүүлнэ.

Элэгний цирроз оношлогдсон өвчтөнд вирусийн эмчилгээг зогсоох нь вирус дахин идэвхжих, элэгний үрэвсэл даамжрах, элэгний дутагдал үүсэх эрсдэлтэй тул нуклеоз(т)ид аналог эмийг насан туршдаа ууна (Хүснэгт В.10).

Хүснэгт В.10 Вирусийн эсрэг эмчилгээг үргэлжлүүлэх, зогсоох, дахин эхлүүлэх заалт

Заалт	Тайлбар
Нуклеоз(т)идын аналог эмээр насан туршид эмчлэх нь	Элэгний циррозтой ($APRI > 2$ насанд хүрэгсдэд) гепатитын В вирусийн халдвартай бүх хүмүүс нуклеоз(т)идын аналог эм насан туршдаа уух шаардлагатай бөгөөд вирусийн дахин идэвхжил үүсч, архаг гепатитын суурин дээр цочмог гепатит үүсэх тул вирусийн эсрэг эмчилгээг зогсоож болохгүй

Эмчилгээг зогсоох	Элэгний циррозгүй (APRI<2 насанд хүрэгсдэд) дараах тохиолдолд нуклеоз(т)идын аналог эмийг зогсоож болно. Үүнд: Вирусийн үржлийн дахин сэдрэлийг байнга хянуулж байх боломжтой, HBeAg арилж, HBeAb сероконверс (Эмчилгээний өмнө HBeAg зэрэг байсан) үүссэнээс хойш вирусийн эсрэг эмчилгээг 1 жил үргэлжлүүлэх, АЛАТ тогтвортой хэвийн, HBsAg тогтвортой арилсан, түүнээс хойш вирусийн эсрэг эмчилгээг 1 жил үргэлжлүүлсэн бол HBeAg илэрцээс үл хамаарч эмчилгээг зогсоож болно
Эмчилгээг дахин эхлүүлэх	Нуклеоз(т)идыг зогсоосны дараа вирусийн үржил сэдэрсэн бол Вирусийн үржлийг илтгэх шинжүүд тогтвортой илэрвэл (HBsAg эсвэл HBeAg дахин илрэх, АЛАТ идэвх өндөрсөх, HBV-DNA дахин тодорхойлогдох) вирусийн эсрэг эмчилгээг дахин эхлүүлнэ

Орчин үеийн эмчилгээний шинэ хандлага: Вирусийн үржлийн үе шатууд ялангуяа сссДНХ-ийг устгах үйлдэлтэй эмийг бүтээж байна. Вирусийн эсрэг өргөн хүрээний үйлдэлтэй эм нь халдвартай эс рүү чиглэх, дархлааны хариу урвалыг дэмжих, элэгний эс доторх анхдагч дархлааны урвалыг идэвхижүүлэх, эсийн бөөмийн siRNA капсидыг saatуулах үйлдлийг судалж байна.

B.3.3 Эмчилгээний хяналт

Вирусийн эсрэг эмчилгээний өмнө, явцад, дууссаны дараа өвчний даамжрал ба эмчилгээний үр дүнг хянана. Вирусийн эсрэг эмчилгээ эхлэхийн өмнө бөөрний үйл ажиллагааг шалгаж, бөөрөнд хоруу нөлөө үзүүлэх эрсдэлийг урьдчилан үнэлэх хэрэгтэй.

Удаан хугацаагаар тенофовир, энтекавир хэрэглэх үед бөөрний үйл ажиллагаа (Шээсний ерөнхий шинжилгээ, цусанд креатинин, үлдэгдэл азот, мочевин), фосфор, ясны сийрэгжилтийн шинжилгээг жилд 2 удаа, хүүхдийн өсөлтийг жилд бүр үнэлэх хэрэгтэй.

Хүснэгт B.11 Гепатитын В вирусийн архаг халдвартай, бөөрний үйл ажиллагааны дутагдалтай насанд хүрэгчдэд вирусийн эсрэг эмийн тун хэмжээ

Эмийн сонголт	Тунг бууруулах эсвэл тунгийн интервал өөрчлөх зөвлөмж Креатинин клиренс (ml/min)			
	≥50	30-49	10-29	<10, Гемодиализ, байнгын хэвлийн диализ
Тенофовир дизопроксил фумарат	24 цагт 300мг шахмал (7.5 халбага нунтаг)	48 цагт 300мг шахмал (160мг буюу 3 халбага нунтаг)	72–96 цагт 300мг шахмал (60мг нунтаг буюу 1.5 халбага нунтаг)	Диализ дууссанаас хойши 12 цагт 7 хоногт 1 удаа 300мг шахмал (эсвэл 20 мг буюу 0.5 халбага нунтаг)
Энтекавир	Хоногт 0.5 мг	Хоногт 0.25мг эсвэл 48 цагт	Хоногт 0.15 мг эсвэл 72	Хоногт 0.05 мг эсвэл 7 хоногт

		0.5мг	цагт 0.5мг	0.5 мг
Энтекавир (элэгний ээнэгшилгүй)	Хоногт 1 мг	Хоногт 0.5 мг эсвэл 48 цагт 1 мг	Хоногт 0.3мг эсвэл 72 цагт 1 мг	Хоногт 0.1 мг эсвэл 7 хоногт 1 мг
Тенофовир алафенамид	Хоногт 25 мг			Хэрэглэхгүй

Эмчилгээний явц, эмчилгээ дууссаны дараах хяналт, үнэлгээ

Эмчилгээний явцад, мөн дараах хяналтыг хийж, үнэлгээ өгөх нь чухал.

Эмчилгээний үр дүн HBV-DNA тодорхойлогдохгүй болох, HBsAg арилж анти-HBs сероконверс үүсэх, эмчилгээний өмнө HBeAg (+) байсан тохиолдолд HBeAg арилж, анти-HBe сероконверс (ийлдэс хөрвөх) үүссэнээр илрэх боловч маш цөөн хувьд ийм үр дүнд хүрдэг. Иймд эмчилгээний дараа HBsAg арилж, анти-HBs сероконверс үүсээгүй бол, эмчилгээний өмнө HBeAg (+) байсан тохиолдолд HBeAg арилж, анти-HBe сероконверс (ийлдэс хөрвөх) үүсээгүй бол нуклеоз(т)ид, аналог эмийг сероконверс үүстэл, үүссэнээс хойш 1 жил үргэлжлүүлэн уулгана.

Хүснэгт В.12 Гепатитын В вирусийн эсрэг эмчилгээний явц, эмчилгээ дууссаны дараах хяналт, үнэлгээ

	Нуклеоз(т)идын аналог эм	ПЕГ-интерферон
Вирусийн эмчилгээ хийлгэж байх үед	Үр дүнтэй: HBV-DNA <10 IU/ml буурах Анхдагч үр дүнгүй: эмчилгээ эхэлснээс хойш 3 сарын дараа HBV-DNA <1 log буурсан Хагас үр дүнтэй: эмчилгээ эхэлснээс хойш 12 сараас дээш хугацаанд HBV-DNA >1 log буурсан эсвэл HBV- DNA илэрсээр байх Сэдрэл: эмчилгээний явцад HBV-DNA >1 log нэмэгдэх	Үр дүнтэй: HBV-DNA <2000 IU/ml
Вирусийн эмчилгээ дууссаны дараа	Тогтвортой хариу урвал: эмчилгээ дууссанаас хойш 12 сараас дээш хугацаанд HBV-DNA <2000 IU/ml	
Ийлдэс судлалын	HBeAg арилж anti-HBe үүсэх HBsAg арилж anti-HBs үүсэх	
Биохимиин	АЛАТ хэвийн (эмчилгээний дараах 1 жилд 3 сар тутам АЛАТ тодорхойлоход)	
Гистологийн	Эмчилгээний өмнөх гистологийн шинжилгээтэй харьцуулахад фиброз өөрчлөлт нэмэгдээгүй, үхжилт үрэвсэл буурсан байх	

- METAVIR F-3, F-4 фиброзтой өвчтнүүдэд 3-6 сар тутамд хэвлийн хэт авиан шинжилгээ, AFP, боломжтой бол PIVKA II шинжилгээ хийж элэгний хорт хавдарын эрт илрүүлэгт тогтмол хамруулна.

- Элэгний фиброз өөрчлөлт багатай, эмчилгээний төгсгөлд HBsAg сөрөг болсон өвчтөнийг халдвартгуй үйлчлүүлэгчтэй адил үзэх ба хэрэв дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэх бол төрөлжсөн мэргэжлийн эмчийн тогтмол хяналтад байна.
- Тодорхой шалтгаангүйгээр АЛАТ, АСАТ ихэсвэл халдварт дахисан, эсвэл шинэ халдварт авсан гэж үзэж HBV-DNA тодорхойлох шинжилгээ хийнэ.
- Эмчилгээний төгсгөлд HBsAg сөрөг болсон боловч АЛАТ, АСАТ өөрчлөлт илэрсээр байвал бусад шалтгаант элэгний эмгэгийг ялгах шаардлагатай.

Хүснэгт В.13. Гепатитын В вирусийн эмчилгээний дараах хяналт

6 сар тутамд өвчиний явц / эмчилгээний явцыг хянах	12 сар тутамд эмчилгээний хоруу чанарыг хянах	3–6 сар тутамд элэгний хорт хавдрын эрт илрүүлэг (цирроз илэрсэн, удамшлын өгүүлэмжтэй байх) хийх
HBV-DNA, HBeAg, qHBsAg АЛАТ, APRI, FIB-4 Хэвлийн хэт авиа	Бөөрний үйл ажиллагаа	Хэвлийн хэт авиа, AFP

Г.1 ХҮН АМЫН ӨВӨРМӨЦ БҮЛЭГ

Г.1.1 Мансууруулах бодис судсаар тарьж хэрэглэгчид

- Эдгээр хүмүүст вирусийн шалтгаант элэгний өвчин, халдвартын тархалт, нас барагт илүүтэй тохиолдох ба халдвартархах өндөр эрсдэлтэй бүлэгт тооцогддог. Сайн дурын ба товтолт шинжилгээгээр HBsAg, ХДХВ-ийн эсрэгбие илрүүлнэ.
- Эмч, нийгмийн ажилтны багийн тусламжтайгаар эмчилгээний өмнөх зөвлөгөө өгч эрүүл мэндийн боловсрол олгоно.
- Тусламж үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр, тэгш хүртээмжтэй үзүүлнэ.
- Мансууруулах бодисын хор хөнөөлийг бууруулах, зүү тариур солилцох хөтөлбөр хэрэгжүүлнэ
- Гепатитын В вирусийн вакцинжуулалтанд хамруулах, хавсарсан халдвартыг эмчлэх арга хэмжээг хамт хэрэгжүүлнэ

Г.1.2 ХДХВ/ДОХ хавсарсан халдвартай

Гепатитын В вирус ба ХДХВ-ийн хавсарсан халдвартын үед элэгний эмгэг хурдан даамжрах, элэгний цирроз ба элэгний хорт хавдарт шилжих, элэгний эмгэгийн улмаас нас барах, ХДХВ-ийн халдвартгуй хүмүүстэй харьцуулахад эмчилгээнд тэсвэртэй болох зэргээр гепатитын В вирусийн халдвартын өмнөх зүйд онцгой нөлөөтэй. Түүнчлэн ХДХВ/ДОХ ба гепатитын В вирусийн эсрэг өмнөх зүйд онцгой нөлөөтэй болох, эмийн шалтгаант элэгний гэмтэл, РВЭ эмчилгээ нь энэ 2 халдварт зэрэг нөлөөлж чадахгүй бол фульминант гепатит үүсгэх зэрэг үр дагавартай.

РВЭ эмийн эмчилгээг эхлэх: Гепатитын В вирус ба ХДХВ-ийн хавсарсан халдвартай өвчтөнд БЗДХ, ХДХВ/ДОХ-ын эмчтэй хамтран РВЭ-г эхэлж, үр дүнг хянана.

Хүснэгт Г.1 РВЭ эмчилгээ эхлэх заавар

РВЭ эмчилгээнд өвчтөнг бэлтгэх	
РВЭ эмчилгээ эрт эхлэх	ХДХВ-ийн халдварт оношлогдсоноос хойш аль болох эрт РВЭ эмчилгээ эхлэх, үйлчлүүлэгчид РВЭ эмчилгээний талаарх зөвлөнө.

РВЭ эмчилгээ эхлэх

Насанд хүрэгчид ба өсвөр насынхан (10–19 нас)	СД4 эсийн тоо, ДЭМБ-ын эмнэл зүйн үе шатаас үл хамааран РВЭ эмчилгээ эхэлнэ. ХДХВ-ийн халдвартай хүнд явцтай, хожуу үед (ДЭМБ-ын эмнэл зүйн 3 ба 4-р шат) ба СД4 эсийн тоо ≤350 өс/мм ³ үед нэн даруй эхлэх
	Үндсэн горим: TDF+3TC (эсвэл FTC)+EFV Сонгох горим: TDF+3TC (эсвэл FTC)+NVP TDF+3TC (эсвэл FTC)+DTG (эсвэл RAL) AZT+3TC+EFV (эсвэл NVP)

Анхаарах: РВЭ эмийн гаж нөлөө ба түүнтэй холбоотой тулгарч буй асуудлыг БЗДХ, ХДХВ/ДОХ-ын эмнэлзүйч эмчтэй хамтран шийдвэрлэнэ.

Гепатитын В вирусийн дархлаажуулалт: Насанд хүрэгсэд ба өсвөр насыны ХДХВ-ийн халдвартай хүмүүст халвар элбэг тохиолдох тул анх оношлогдож буй ХДХВ-ийн халдвартай хүн бүрт HBsAg, anti-HBs үзэж, гепатитын В вирусийн халдвартай илрүүлж, хэрэв гепатитын В вирусийн эсрэг дархлаагүй бол дархлаажуулалт хийнэ. Гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтын үр дүн ХДХВ-ийн халдвартай CD4 эсийн хэмжээ бага хүмүүст сүл байдаг. Метанализ судалгаагаар ХДХВ/ДОХ-той хүмүүст дархлаажуулалтын тунг 2 дахин нэмж 40 μg-аар 4 удаа хийх нь 20 μg тунгаар 3 удаа тарихаас илүү үр дүнтэйг тогтоожээ.

Г.1.3 Хүүхдэд хийгдэх эмчилгээ

Хүүхдэд гепатитын В вирусийн архаг халдвартай ихэвчлэн шинж тэмдэггүй тохиолдох ба дархлаа тэвчлийн шатандаа байх тул вирусийн эсрэг эмчилгээ хийх шаардлагагүй. Элэгний архаг эмгэгийн даамжралын явцыг хянаж, гэр бүлд элэгний хорт хавдрын өгүүлэмжтэй эсэхийг анхаарна. Элэгний фиброзыг үнэлэх хатгалтын бус шинжилгээний оношийн шалгуурыг хүүхдэд хараахан тогтоогоогүй байна.

Нуклеоз(т)идын аналог ба пег-интерферон вирусийн эсрэг эмчилгээний үр дүн бага, удаан хугацаагаар хэрэглэх тул эмийн тэсвэржилт, гаж нөлөө гарах эрсдэлтэй. Иймд элэгний цирроз үүсэх, эдийн шинжилгээнд үхжилт үрэвсэл идэвхитэй явагдах заалт гартал вирусийн эсрэг эмчилгээг хийхгүй, элэг хамгаалах эмчилгээ хийнэ.

Хүснэгт Г.2. Гепатитын В вирусийн халдвартай үед хүүхдэд хэрэглэх вирусийн эсрэг эмийн тун хэмжээ

Эм	Тун
Тенофовир апафенамид TAF (12-оос дээш насын хүүхэд, 35 кг-ээс дээш жинтэй бол)	25 мг/хоногт
Тенофовир дизопроксил фумарат TDF (хүүхэд 12-оос дээш настай, 35 кг-аас дээш жинтэй бол)	300 мг /хоног
Тенофовир дизопроксил фумарат TDF (хүүхэд 2-оос дээш настай, 17 кг-аас дээш жинтэй бол)	17-22 кг – 150 мг 22- 28 кг - 200 мг 28-35 кг – 250 мг ≥35 кг бол 300 мг тунгаар
Тенофовир дизопроксил фумарат TDF (хүүхэд 2-оос дээш настай, 10 кг-аас дээш жинтэй бол)	8 мг/кг тооцож өдөрт 1 удаа уулгана (300 мг хүртэл)

Энтекавир (2-оос дээш настай, 10 кг-аас дээш жинтэй бол) уусмал эмийг 30 кг хүртэл жинтэй хүүхдэд хэрэглэнэ.	10-11 кг 0.15мг(3мл) >11-14 кг 0.2мг(4мл) >14-17 кг 0.25мг(5мл) >17-20 кг 0.35мг(7мл) >20-23 кг 0.4мг(8мл) >23-26 кг 0.45мг(9мл) >26-30 кг 0.5мг(10мл)
--------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Пег-интерфероныг нэг хүртэлх насны хүүхдэд хэрэглэхгүй. Тенофовир, энтекавирыг 2-оос дээш насны хүүхдэд хэрэглэнэ. 2-оос бага насны хүүхдэд вирусийн эсрэг эмчилгээ судлагдаагүй. Хүүхдэд хэрэглэх гепатитын В вирусийн эсрэг нэгдүгээр сонголтын эмчилгээний заалт ба тунг хүснэгт Г.2-т харуулав.

Г.1.4 Элэгнээс бусад холбогч эдийн тогтолцооны эмгэг

HBsAg эерэг өвчтөнд холбогч эдийг хамарсан элэгний бус шинж болох арьсны өөрчлөлт, полиартрит, зангилаат периarterит, глмерулонефрит илрэх ба вирусийн эсрэг эмчилгээ нуклеоз(т)ид аналог бэлдмэлд мэдрэг байдаг. Элэгний бус шинжийг вирусийн эсрэг эмээр эмчилсэн судалгаа хангалтгуй байна. Ламивидиныг хамгийн түгээмэл хэрэглэсэн ба энтекавир, тенофовирийн эмчилгээний үр дүн илүү сайн байсан. Пег-интерферон дархлааны шалтгаант элэгний бус шинж тэмдгийг дордуулах тул хэрэглэхгүй.

Г.1.5 Гепатитын В вирусийн цочмог халдварт

Гепатитын В вирусийн хүндрэлгүй цочмог халдвартын үед вирусийн эсрэг эмчилгээ шаардлагагүй, дархлаа хэвийн хүмүүсийн 95-аас дээш хувьд 6 сарын дотор гепатитын В вирус арилж, эдгэрдэг. Хүнд явцтай цочмог гепатитын үед энтекавир, тенофовирийг хэрэглэж болох бөгөөд өвчний хүндрэл ба архагшихаас сэргийлнэ. Эмчилгээний үргэлжлэх хугацааг одоогоор тогтоогүй боловч HBsAg арилаагүй ч anti-HBs үүссэнээс хойш 3 сар эсвэл anti-HBe үүссэнээс хойш 12 сар уухыг зөвлөдөг.

Г.1.6 Бөөр орлуулах эмчилгээ ба бөөр шилжүүлэн суулгасан өвчтөн

Бөөрний эмгэгийн төгсгөлийн шат, бөөр шилжүүлэн суулгасан өвчтнүүдэд гепатитын В вирусийн халдварт илрүүлэх шинжилгээ хийж, халдвартгүй бол дархлаажуулалт хийх шаардлагатай. Бөөрний дутагдалтай, бөөр шилжүүлэн суулгасан өвчтнүүдэд вирусийн эсрэг эмийг хэрэглэхдээ тунг тохируулна. Вирусийн эсрэг эмчилгээний явцад бөөрний үйл ажиллагааг хянаж байх ёстой бөгөөд эмчилгээний явцад бөөрний дутагдал гүнзгийрвэл эмчилгээг солих юмуу тунг дахин тохируулах хэрэгтэй. Шилжүүлэн суулгасан бөөр ховхрох эрсдэлтэй байдгаас интерферонд суурилсан эмчилгээ хийхийг зөвлөдөггүй. Бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэж буй HBsAg-эерэг өвчтөн бүр гепатитын В вирус дахин идэвхжихээс сэргийлж нуклеоз(т)идын аналог эмийг хэрэглэх шаардлагатай.

Г.1.7 Гепатитын С вирусийн хавсарсан халдварт

Гепатитын В вирусийн халдвартай хүмүүст гепатитын С вирусийн халдварт хавсрах нь элэгний өвчний даамжуулж, элэгний хорт хавдар үүсгэх, нас барах эрсдэлийг нэмэгдүүлдэг. гепатитын С вирусийн халдварт идэвхитэй үед HBV-DNA ихэвчлэн бага байх, эсвэл тодорхойлогдохгүй, ийм тохиолдолд анхдагч эмчилгээ нь гепатитын С вирусийн халдвартыг эмчилнэ. гепатитын В ба С вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээ хийж, аль вирус идэвхитэй буйг тогтоож эмчилнэ. Эмчилгээний үед, төгсгөлд гепатитын В вирусийн идэвхижил дахилтыг HBV-DNA шинжилгээгээр шалгаж байх ба хэрэв идэвхижвэл нуклеоз(т)ид аналог эмийн эмчилгээг эхэлнэ.

Г.1.8 Сүрьеэгийн хавсарсан халдвар

Эдгээр халдвар нутагшмал гардаг улс оронд хавсарсан халдвар тохиолдох нь элбэг. Энэ үед оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээ нэмэх шаардлагатай. Мансууруулах тариа хэрэглэдэг, шоронгийн хоригдол зэрэг хүмүүст гепатитын В ба С вирус ба сүрьеэгийн хавсарсан халдвар олон тохиолдоно. Гепатитын В вирусийн халдвартай өвчтөнд дөрвөн шинж тэмдгээр сүрьеэгийн халдварын эрт илрүүлгийг хийнэ. Хэрэв ханиалга, жин буурах, халуурах, шене хөлрөх зэрэг шинж тэмдэг илэрвэл идэвхитэй сүрьеэг илтгэх ба цаашид оношийг нотлох шинжилгээг төлөвлөх шаардлагатай. Гепатитын В ба С вирус, ХДХВ/ДОХ халдварын үед сүрьеэгийн эсрэг эм изонаизид, рифампицин, пиразинамид хэрэглэхэд эмийн шалтгаант элэгний гэмтэл үүсч, АЛАТ идэвхиждэг.

Г.1.9 Элэг шилжүүлэн суулгах эмчилгээ

Элэг шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх заалттай өвчтөнүүд хагалгааны өмнө элэг шилжүүлэн суулгах багийн гепатолог эмчийн хяналтанд нуклеоз(т)ид аналог эм ууна. Элэгний В вирусийн шалтгаант эмгэгүүд (элэгний цирроз, элэгний хавдар, элэгний дутагдал г.м)-ийн улмаас элэг шилжүүлэн суулгуулсан өвчтнүүдэд В вирусийн халдвар дахих эрсдлийг бууруулах зорилгоор В вирусийн эсрэг эмүүдийг элэг шилжүүлэн суулгасны дараах эмчилгээнд зайлшгүй зөвлөдөг. Уг эмчилгээг сонгоходоо элэг шилжүүлэн суулгахын өмнө HBV-DNA төвшин ямар байснаас дахин халдвар үүсэх, халдвар сэргэх эрсдэл бий эсэхийг дүгнэж болно. Тухайлбал мэс заслын өмнө HBV-DNA идэвхгүй буюу тоологдоогүй бол халдвар дахин идэвхжих эрдсэл бага байдаг. Нуклеоз(т)идын аналог эмүүдийг мэс заслын өмнө аль болох эрт амаар уулгах нь нь гепатитын В вирусийн халдвар дахин идэвхжихээс сэргийлдэг бөгөөд, мэс заслын дараа HBIG хэрэглэх шаардлагагүй. Харин гепатитын В, D вирусийн хавсарсан халдвартай, HBV-DNA идэвх бага үед мэс заслын дараа аль болох эрт HBIG болон нуклеоз(т)ид аналог эмийн хослолыг эхлүүлэх нь вирусийн халдвар дахин идэвхжихээс сэргийлж буй эмчилгээний алтан стандарт юм. HBIG хэрэглэх тун нь олон улсын томоохон төвүүдэд харилцан адилгүй байгаа бөгөөд дийлэнх төвүүд anhepatitic үед HBIG 10.000IU судсанд дуслаар, үргэлжлүүлээд өдөрт 600-1000IU булчин/судсанд 7 хоног, цаашид 7 хоногт нэг удаа 3 долоо хоног, сард нэг удаа 3-6 сар хэрэглэхийг зөвлөж байна.

Г.1.10 Элэгний ба бусад хорт хавдар

Гепатитын В вирусийн эсрэг эмчилгээ эхлэхийн өмнө элэгний хорт хавдрыг үгүйсгэх шаардлагатай. Элэгний хорт хавдрын улмаас төгс (мэс засал, этанол тарих эмчилгээ, түлэх эмчилгээ, судас бөглөх) эмчилгээ хийгдсэн, хавдар дахилтгүй бол мөн бусад эрхтний хавдрын төгс эмчилгээ хийгдсэн тохиолдолд гепатитын вирусийн эсрэг энтекавир, тенофовир, тенофовир алафенамид эмчилгээ эхэлж болно. Вирусийн идэвхжил тодорхойлогдохгүй болох, HBsAg, HBeAg сероконверс болсноос хойш эмчилгээг 1 жил үргэлжлүүлнэ. Эмчилгээний явцад AFP, хэвлийн хэт авиа, шаардлагатай бол хэвлийн тодостогчтой компьютер хийлгэж хянана.

Хорт хавдрын үеийн химиин эмчилгээ ба бусад эмчилгээ хийж байх үед эзэн биеийн дархлаа суларсны суурь дээр гепатитын В вирусийн халдвар идэвхжих эрсдэлтэй байдаг ба энэ үед өвчтнүүдэд (HBsAg зэрэг; HBsAg серөг боловч anti-HBc зэрэг) вирусийн эсрэг эмчилгээ хийх нь элэгний үйл ажиллагааг дэмжих суурь эмчилгээ болдог. Хорт хавдрын эсрэг бүх эмчилгээний үед вирусийн идэвхжилтэй хавсарсан АЛАТ, АСАТ, шарлалт, элэгний дутагдал үүсэх зэрэг шинж тэмдэг илэрдэг. Ялангуяа хөхний хавдар, цусны лимфома, цуллаг эрхтэний хавдрын үед өндөр тунгаар хийгдэж байгаа хими, стероид хосолсон эмчилгээ, элэгний хорт хавдар, хорт хавдрын мэс засал, мэс заслын бус бүх эмчилгээний үед тохиолдож болдог. Иймд:

- Хорт хавдрын эсрэг эмчилгээ, дархлаа дарангуйлах эмчилгээ эхлэх үетэй зэрэгцээд HBsAg, anti-HBs, anti-HBc илрүүлэх шинжилгээ хийнэ.
- Гепатитын В вирусийн халдвартай бол хавдартай өвчтөнд вакцин хийлгэхийг зөвлөнө.
- Гепатитын В вирусийн халдвэр (HBsAg эерэг; HbsAg сөрөг боловч anti-HBc зерэг) илэрсэн хорт хавдрын эмчилгээнд орж байгаа бүх тохиолдолд вирусийн эсрэг эмчилгээг архаг гепатитын үеийн заавраар эмчилгээг эхэлнэ. Мөн эмчилгээний үеийн хяналтыг тус зааврын дагуу хийж, хими, хавдрын эсрэг эмчилгээг дууссанаас хойш 6 сараас эхлэн вирусийн хяналтын шинжилгээг хийнэ.


Г.1.11 Жирэмсний үеийн халдвэр

Эхээс хүүхдэд ХДХВ, гепатитын В вирус, тэмбүүгийн халдвэр дамжихаас сэргийлэх зааврыг мөрдөнө.

Нөхөн үржихүйн насты эмэгтэйчүүдийн гепатитын В вирусийн илрүүлэг шинжилгээнд хамруулж, халдвэр илэрсэн тохиолдолд хяналтанд авна. Жирэмсний эрт үед гепатитын В вирусийн илрүүлэг шинжилгээнд хамруулах нь эхээс хүүхдэд дамжих халдвартыг таслан зогсоох эхний арга хэмжээ бөгөөд Зураг Г.1-т үзүүлсэн зохих арга хэмжээг дэс дараалан авч хэрэгжүүлнэ. Үүнээс гадна эхээс хүүхдэд гепатитын В вирусийн халдвэр дамжихаас сэргийлэх арга хэмжээг Зураг Г.2-т харуулсан дагуу мэдээлнэ.

Жирэмсэн эхийн хяналт

- Жирэмсний эхний сард хяналтад ороход гепатитын В вирусийн халдвартын илрүүлэг шинжилгээ (HBsAg) хийнэ.
- Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эмэгтэйн хяналтыг харьяа аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төвийн эх барих эмэгтэйчүүдийн эмч нь төрөлжсөн мэргэжлийн эмчтэй хамтарч хийнэ. Өрх, сум, тосгоны эмч давхар хянана.
- Жирэмсэн эхэд гепатитын В вирусийн халдвэр дамжихаас сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох: жирэмсэн эхээс хүүхдэд халдвэр дамжих эрсдэл, түүнийг бууруулах арга зам, хүүхдийг төрснөөс хойш 12 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтын вакцины эхний тун ба гепатитын В вирусийн эсрэг иммуноглобулинийг (HBIG) эрт хийлгэхийн ач холбогдлыг тайлбарлана.
- Гепатитын В вирусийн идэвхжил, элэгний үрэвслийг оношлох: гепатитын В вирусийн халдвэр илэрсэн (HBsAg+) бол онош тодруулах нэмэлт шинжилгээг хийж, вирусийн эсрэг эмчилгээ эхлэх эсэхийг шийдвэрлэнэ. Дараах шинжилгээг хийнэ:
 - Вирусийн үржил, ачааллал тодорхойлох: HBeAg, HBV-DNA
 - Гепатитын D вирусийн халдвартын илрүүлэг: anti-HDV
 - Хэвллийн хэт авиа
 - Биохими: элэг ба бөөрний үйл ажиллагаа
 - Цусны ерөнхий шинжилгээ
 - Цус бүлэгнэлт - INR
 - Элэгний фиброзыг үнэлэх инвазив бус шинжилгээ: APRI, FIB4.



Зураг Г.1. Эхээс хүүхдэд гепатитын В вирусийн халдвартай дамжихаас сэргийлэлт Жирэмсэн эхийн эмчилгээ

Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхийн В вирусийн эсрэг эмчилгээг насанд хүрэгчдийн адил АЛАТ, HBV-DNA түвшин, элэгний өвчний хүндрэлийн үзүүлэлтээс хамаарч Зураг Г.1-т үзүүлсний дагуу үндсэн эмчилгээ, хяналтыг сонгоно. Хэрэв элэгний циррозтой бол тенофовир дизопроксил фумарат эмийг эхэлнэ.

Гепатитын В вирусийн эмчилгээ хийлгэж байсан эх санамсаргүйгээр жирэмсэн болбол эмчилгээг үргэлжлүүлэх эсэхийг дахин үнэлэх ба эмчилгээ үргэлжлүүлэх бол эмийн сонголт нь тенофовир дизопроксил фумарат байна. HBV-DNA (HBV-DNA >5.3 Log IU/ml буюу >200 000 IU/ml) өндөр тодорхойлогдож байгаа мөн HBeAg зерэг эсвэл qHBsAg >4Log IU/ml жирэмсэн эхэд жирэмсний 28 дахь долоо хоногоос тенофовир дизопроксил фумарат эмчилгээг эхлүүлж, төрсний дараах 12 долоо хоног хүртэл үргэлжлүүлнэ.

Жирэмсний явцад эм ууж хэрэглэж байгаа эсэхээс үл хамааран элэгний үрэвсэл сэдрэх магадлалтай тул жирэмсний үеийн хяналтыг тогтмол хийнэ.

Жирэмсний үед вирусийн эсрэг тенофовир дизопроксил фумарат (TDF) эмийг 300 мг тунгаар хоногт нэг удаа тогтмол цагт ууна. Тенофовир дизопроксил фумарат эмийг уухын өмнө бөөрний үйл ажиллагааг шалгаж, бөөрөнд хоруу нөлөө үзүүлэх эрсдэлтэй бол тунг тохируулна (Зураг Г.1, Зураг В.1).

Төрсний дараа эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ


Гепатитын В вирусийн халдвартай эх, хүүхдийг өрх, сум, тосгоны эмч нь харьяа

аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, дүүргийн эрүүл мэндийн төвийн төрөлжсэн мэргэжлийн эмчтэй хамтарч хянана.

Хэрэв эхэд элэгний үрэвсэл идэвхижилгүй, элэгний циррозгүй бол гепатитын В вирусийн эсрэг эмийг төрсний дараа 4–12 долоо хоног хүртэл үргэлжлүүлэн ууж, эмчийн заалтаар зогсоож болно. Элэгний үрэвсэл болон вирусийн идэвхжил, хэвллийн хэт авиан шинжилгээг 6 сар тутам хийж хянана. Хэрэв элэгний циррозтой бол вирусийн эсрэг нуклеоз(т)ид аналог эмийг насан туршдаа ууна.

Хөхөөр хооллолт: Гепатитын В вирусийн халдвартай эх хүүхдээ хөхөөр хооллохыг дэмжинэ. Гепатитын В вирусийн эсрэг эм хэрэглээгүй, хөхний толгой гэмтэж шархлаагүй бол хүүхдээ хөхөөр хооллоно. Гепатитын В вирусийн эсрэг эм хөхний сүүгээр шимэгдэх хэмжээ маш бага, энэ нь хөхөөр хооллох эсрэг заалт болохгүй, энэ тохиолдолд хүүхдээ хөхөөр хооллох шийдвэрийг эх нь гаргана.

Хүүхдийн хяналт: Хүүхдэд гепатитын В вирусийн халдвартын эсрэг дархлал тогтоцыг В вирусийн эсрэг вакцины 4 дэх тунг хийснээс хойш 2 сарын дараа (7 -12 сартайд) HBsAg, anti-HBs шинжилгээ хийж, дархлал тогтсон, эхээс халдвартамжсан эсэхийг үнэлнэ (Зураг Г.3).



Зураг Г.3. Гепатитын В вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхдийн хяналт

Хүснэгт Г.3 Хүүхдийн дархлаажуулалтын дараах шинжилгээ

Ийлдэс судлалын үзүүлэлтүүд	Эмнэлэйн дүгнэлт, шинжилгээний тайлбар
HBsAg сөрөг (-) anti-HBs сөрөг (-)	Гепатитын В вирусийн халдвартай, гепатитын В вирусийн эсрэг дархлаа тогтоогүй
HBsAg ээрэг (+) anti-HBs сөрөг (-)	Гепатитын В вирусийн халдвартай
HbsAg сөрөг (-) anti-HBs ээрэг (+)	Вакцины дараах дархлаа тогтсон

Г.1.12 Эрүүл мэндийн ажилтан

Гепатитын В вирусийн илрүүлэг шинжилгээнд хамруулж, HBsAg илрээгүй тохиолдолд ГВВ-ийн эсрэг вакцинд хамруулах нь гепатитын D вирусийн халдвараас сэргийлнэ. HBsAg илэрсэн үед эрүүл мэндийн ажилтнуудад зааврын дагуу тусlamж үйлчилгээ үзүүлнэ.

НОМ ЗҮЙ

1. Guidelines for the prevention, care and treatment of persons with chronic hepatitis B infection, WHO, March 2015
2. Chen HY, Shen DT, Ji DZ, Han PC, Zhang WM, Ma JF, Chen WS, Goyal H, Pan S, Xu HG. Prevalence and burden of hepatitis D virus infection in the global population: a systematic review and meta-analysis. Gut. 2019 Mar;68(3):512-521. doi: 10.1136/gutjnl-2018-316601. Epub 2018 Sep 18. PMID: 30228220.
3. Stockdale AJ, Kreuels B, Henrion MYR, Giorgi E, Kyomuhangi I, de Martel C, Hutin Y, Geretti AM. The global prevalence of hepatitis D virus infection: Systematic review and meta-analysis. J Hepatol. 2020 Sep;73(3):523-532. doi: 10.1016/j.jhep.2020.04.008. Epub 2020 Apr 23. PMID: 32335166; PMCID: PMC7438974.
4. D.Davaalkham Hepatitis Delta virus infection in Mongolia: Analyses of geographic distribution, risk factors and disease severity The American journal of tropical medicine and hygiene 75(2):365-9·August 2006
5. Ц. Оюунсүрэн. Монголын хүн амын дунд тархсан гепатитын В, С, дельта вирусийн молекул генетик онцлог. 2011 он, Улаанбаатар
6. AASLD 2018, Recommendations for testing, managing, and treating hepatitis B
7. APASL 2016, Consensus statements and recommendation on treatment of hepatitis B
8. T.Oyunsuren et al. High frequency of hepatocellular carcinoma in Mongolia: association with mono-, or co-infection with hepatitis C, B, and Delta viruses. J Med Virol, 2006
9. National program on prevention and reduction of morbidity and mortality from viral hepatitis. Government resolution of Mongolia 2017.

10. A.Jazag et al. Status Quo of ChronicLiver Diseases, including Hepatocellular Carcinoma, in Mongolia. Korean J Intern MeD, 2012
11. R. Sanduijav et al. HCC in Mongolia. APASL 2008 Abstract, Hepatology International 2008, p278
12. O. Baatarkhuu et al. Current situation of HCC in Mongolia. Oncology. 2011;81 Suppl 1:148-51
13. B. Tsatsralt-Od et al. High prevalence of dual or triple infection of hepatitis B, C, and Delta viruses among patients with chronic liver Disease in Mongolia. J Med Virol. 2005 Dec;77(4):491-9.
14. Tillmann HL, Zachou K, Dalekos GN. Management of severe acute to fulminant hepatitis B: to treat or not to treat or when to treat? Liver Int. 2012;32(4):544–53.
15. Health Indicators 2022, Center for Health Development
16. APASL Consensus statements and recommendation on treatment of hepatitis B. Hep Int 2016
17. EASL Recommendations on treatment of hepatitis B, 2017
18. EASL Clinical Practice Guidelines: Liver transplantation. J of Hepatology (2016), vol.64/433-485
19. Davaalkham D, Batzorig B, Surenkhand G, Sodbayar D, Shatar S. Impact assessment of the national immunization program against hepatitis B in Mongolia. In: American Public Health Association 139th Annual Meeting and Exposition, Washington, DC, 29 October–2 November. 2011.
20. Dashtseren B, Bungert A, Bat-Ulzii P, Enkhbat M, Lkhagva-Ochir O, Jargalsaikhan G, Enkhbat A, Oidovsambuu O, Klemen J, Dashdorj N, Dashdorj N, Genden Z, Yagaanbuyant D. Endemic prevalence of hepatitis B and C in Mongolia: A nationwide survey amongst Mongolian adults. J. Viral Hepat. 2017 Feb 17
21. Regional Framework for the Triple Elimination of Mother-to-Child Transmission of HIV, Hepatitis B and Syphilis in Asia and the Pacific, 2018–2030
<https://iris.wpro.who.int/bitstream/hanDle/10665.1/14193/9789290618553-eng.pdf>
22. Screening and Testing for Hepatitis B Virus Infection: CDC Recommendations — United States, 2023, MMWR Recomm Rep 2023;72(No. RR-1):1–25
23. EASL Clinical Practice Guidelines on hepatitis delta virus CLINICAL PRACTICE GUIDELINES| VOLUME 79, ISSUE 2, P433-460, AUGUST 2023
24. WHO. Guidelines on hepatitis B and C testing. 2017.
25. WHO. Prevention of mother-to-child transmission of hepatitis B virus: guidelines in antiviral prophylaxis in pregnancy. 2020

ТӨВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АЛАТ	Аланинаминотрансфераз
ACAT	Аспартатаминотрансфераз
АФП	Альфа-фетопротейн
ГГТ	Гаммаглутаминтранспептидаз
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
КТ	Компьютертомографийн шинжилгээ
ПГУ	Полимеразын гинжин урвал
РВЭ	Ретровирусийн эсрэг
ФХЭБҮ	Фермент холбоот эсрэг биеийн урвал
ХДХВ/ДОХ	Хүний Дархлал Хомсдлын Вирус/ Дархлалын Олдмол Хомсдол
ЦЕШ	Цусны ерөнхий шинжилгээ
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
APRI	AST-to-platelet ratio index
Anti-HBc	ГВВ-ийн цөмийн эсрэгбие
Anti-HBs	ГВВ-ийн гадаргуугийн эсрэгбие
Anti-HBe	ГВВ-ийн е эсрэгбие
Anti HBc-IgM	ГВВ-ийн цөмийн эсрэгбие - иммуноглобулин M
Anti-HDV	ГДВ-ийн эсрэгбие
Anti HDV-IgM	ГДВ-ийн эсрэгбие - иммуноглобулин M
Anti HDV-IgG	ГДВ-ийн эсрэгбие - иммуноглобулин G
FIB-4	Fibrosis-4 index for liver fibrosis
INR	International normalised ratio
IU/ml	International unit/milliliter - олон улсын нэгж
HBsAg	ГВВ-ийн гадаргуугийн эсрэгтөрөгч
HBcAg	ГВВ-ийн цөмийн эсрэгтөрөгч
HBeAg	ГВВ-ийн е эсрэгтөрөгч
HBV-DNA	ГВВ-ийн дезоксирибонуклейн хүчил
HDV RNA	ГДВ-ийн рибонуклейн хүчил



ГЕПАТИТЫН С ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ЭМНЭЛ ЗҮЙН ЗААВАР

A. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

A.1 Онош, Өвчний олон улсын 10 дугаар ангилаал (ICD-10)

B17.1	Цочмог С гепатит	Acute hepatitis C
B18.2	Архаг С вируст гепатит	Chronic viral hepatitis C

Тайлбар: Гепатитын С вирусийн халдвартын шалтгаант элэгний цирроз, элэгний хорт хавдар үүссэн бол Өвчний олон улсын 10 дугаар ангилаалын дагуу үндсэн оношийг тавьж, бусад хавсарсан шалтгааны оношийг хавсаргана. Жишээ нь:

K74.6 Элэгний фиброз ба цирроз, B18.2 Архаг С вируст гепатит

C22.0 Элэгний эст өмөн, B18.2 Архаг С вируст гепатит

A.2 Зааврын хэрэглэгчид

Эрүүл мэндийн байгууллагын шийдвэр гаргагч, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий эмч, мэргэжилтэн

A.3 Зорилго, зорилт

Гепатитын С вирусийн халдвартыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, хянах талаар үр дүнтэй нотолгоонд суурилсан заавар зөвлөмжөөр хангах, өвчтөнд үзүүлэх тусlamж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах гепатитын С вирусийн шинэ халдвартыг таслан зогсооход чиглэнэ.

A.4 Ашигласан нэр томъёо, тодорхойлолт

Гепатитын вирусийн халдвартын эрт илрүүлэг (Viral hepatitis screening)	Насанд хүрсэн болон халдварт өртөх эрсдэлтэй хүн амын бүлэгт гепатитын вирусийн халдвартыг эрт илрүүлэх зорилгоор хийх ийлдэс судлалын шинжилгээ
Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг (Liver cancer screening)	Эрсдэлтэй хүн амын бүлэгт элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх зорилгоор хийх багц шинжилгээ
anti-HCV эерэг / Гепатитын С вирусийн эсрэгбие илрэх	anti-HCV илрэх нь гепатитын С вирусийн халдварт өртсөнийг илтгэнэ. Халдвартай эсвэл халдвартай эсэхийг ялгах боломжгүй
HCV-RNA тодорхойлогох	anti-HCV илэрсэн хүмүүст HCV-RNA тодорхойлогох болон гепатитын С вирусийн идэвхитэй халдвар болохыг илтгэнэ
Цочмог С гепатит (Acute hepatitis C)	Гепатитын С вирусийн халдвар 6 сар хүртэл үргэлжлэхийг хэлнэ.
Архаг С вируст гепатит (Chronic hepatitis C)	Гепатитын С вирусийн халдвар 6 сараас дээш үргэлжлэхийг хэлнэ.
Вирусийн үржил дахих	Вирусийн эсрэг шууд үйлчилгээт (ВЭШҮ) эмийн

(Relapse)	эмчилгээ дуусахад HCV-RNA илрэхгүй болсон ч эмчилгээ дууссанаас хойших хяналтын явцад шинэ халдварт өртөөгүй үед HCV-RNA дахин тодорхойлогдох
Вирусийн тогтвортой хариу урвал (Sustained virological response SVR12, SVR24)	Эмчилгээ дууссанаас хойш 12 ба 24 долоо хоногийн дараа HCV-RNA илрэхгүй байх нь халдвар устан, эмчлэгдсэнийг илтгэнэ.
Эмчилгээ үр дүнгүй (Treatment failure)	ВЭШҮ эмийн эмчилгээ хийсний дараа, эмчилгээ дууссанаас хойш 3 буюу түүнээс дээш сарын дараа HCV-RNA тодорхойлогдох

A.5 Тархвар зүй

Дэлхий дахинд 58 сая хүн гепатитын С вирусийн архаг халдвартай амьдарч, 21% нь оношлогдож, 13% нь эмчилгээнд хамрагдсан. Жил бүр 1.5 сая шинэ халдварын тохиолдол бүртгэгдэж байгааг ДЭМБ мэдээлсэн. 2019 онд 290 000 орчим хүн гепатитын С вирусийн архаг халдварын улмаас элэгний цирроз, элэгний хорт хавдрын шалтгаанаар нас баржээ [1]. ДЭМБ-аас гаргасан 2022-2030 оны стратегийн дагуу 2030 он гэхэд вируст гепатитын халдварыг таслан зогсоох зорилго тавьсан [2]. Хэдийгээр зарим оронд нааштай үр дүн гарч байгаа ч оношилгоо, эмчилгээг сайжруулах шаардлагатай байна [3].

Манай улс гепатитын С вирусийн халдварын тархалт өндөртэй орны тоонд ордог ба насанд хүрэгчдийн 11-16% гепатитын С вирусийн халдварт өртсөн судалгаа байна [4,5]. Манай улс 100 000 хүн амд ноогдох элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт өндөр, дэлхийн дунджаас 8 дахин их байна [6]. Сүүлийн 10 жилд нийт нас баралтын 15%-ийг элэгний цирроз, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт эзэлж байна [7]. Элэгний хорт хавдартай өвчтөнүүдийн дунд гепатитын С вирусийн халдвар 35-45%-ийг эзэлж байна [8].

Монгол Улс гепатитын С вирусийн халдвараас сэргийлэх, элэгний өвчин, эндэгдлийг бууруулах үйл ажиллагааг эрүүл мэндийн салбарын тэрүүлэх асуудлын нэг болж, анхаарал хандуулж байна. Монгол Улсын Засгийн газраас 2015 онд гепатитын вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах, халдварыг эрт илрүүлж, хүн амын дундах вируст халдварын тархалтыг хязгаарлах, вируст гепатитын шалтгаант элэгний цирроз, элэгний хорт хавдрын нас баралтыг бууруулахад чиглэсэн үндэсний дэд хөтөлбөр, 2017 онд “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг баталсан [9].

“Элэг Бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 9 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар гепатитын вирусийн халдварын эрт илрүүлэг шинжилгээнд эрүүл мэндийн даатгалтай нийт 1,099,862 иргэн хамрагдсан нь 15-аас дээш насны хүн амын 50%-ийг эзэлж байна. Илрүүлэг шинжилгээнд хамрагдсан хүний 102,861 иргэн буюу 9.3% нь anti-HCV илэрч, вирусийн эсрэг эмчилгээнд 52 мянга гаруй хүн хамрагджээ [10]. Улаанбаатар хотын 2018 онд хийсэн судалгааны дүнг 2013 онтой харьцуулахад гепатитын С вирусийн ачаалал тодорхойлогдсон хүний эзлэх хувь 71.9%-аас 35.3% болж буурсан байна.

A.6 Үндсэн ойлголт

Эрт илрүүлэгт хамрагдаж anti-HCV илэрсэн хүнийг вирусийн ачаалал HCV-RNA тодорхойлох шинжилгээнд хамруулна. Вирусийн ачаалал тодорхойлогдож байгаа хүнийг эмчилгээнд хамруулах ба өмнө нь гепатитын С вирусийн эсрэг шууд

үйлчилгээт (ВЭШҮ) эмийн эмчилгээ хийлгэж байгаагүй, элэгний циррозгүй эсвэл ээнэгшилтэй циррозтой, бусад хавсарсан өвчингүй насанд хурсэн хүмүүсийг харьяа нутаг дэвсгэрт нь эмчилгээнд хамруулж, тусламж үйлчилгээг хялбаршуулан хүргэнэ. Хавсарсан өвчлөлтэй, ээнэгшилгүй циррозтой, 3-аас дээш насны хүүхдүүд, өмнө нь эмчилгээ хийлгээд үр дүнгүй болсон хүнийг төрөлжсөн мэргэшлийн эмчийн хяналтад эмчилнэ.

Эмчилгээ дууссанаас хойш 12 долоо хоногийн дараа вирусийн тогтвортой хариу урвал (SVR) өгсөн эсэхийг вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээгээр нягтална. Эмчилгээ үр дүнтэй болж, гепатитын С вирус устсан элэгний циррозгүй хүнд амьдралын эрүүл хэв маяг мөрдөх, архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах зөвлөгөө өгнө. Элэгний циррозтой өвчтөнг эмчилгээ үр дүнтэй болсон эсэхээс үл хамааран элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт 6 сар тутамд хамруулж, хэвлийн хэт авиа болон AFP шинжилгээ хийнэ.

Гепатитын С вирусийн халдвартын үед тусламж үйлчилгээг өвчтөнд ойртуулах, шуурхай үзүүлэх хялбаршуулсан горимыг танилцуулж байна. Эрт илрүүлгээр anti-HCV илэрсэн хүнд тэр даруйд нь вирусийн ачаалал тодорхойлох (HCV-RNA) "рефлекс" шинжилгээ, эмийн эмчилгээг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хийнэ. Оношилгоо, эмчилгээний өрөнхий дарааллыг Зураг Б.1.

A.7 Эрүүл мэндийн боловсрол

Гепатитын С вирусийн халдвартын цусаар дамжих ба эрт оношилж эмчлүүлэхийн ач холбогдлыг ойлгуулах нь чухал юм. Гепатитын С вирусийн халдварт авсан хүн эрт илрүүлэгт хамрагдаж, эрт оношилж, эмчилж, хянаснаар элэгний цирроз, элэгний хорт хавдар түүний хүндрэлээс сэргийлэх талаар тайлбарлана. Элэгний циррозтой бол гепатитын С вирусийн эсрэг эмчилгээг хийлгэж, вирусийг устгаснаар өвчний явцыг зогсоож, хүндрэл гарахаас сэргийлэх, элэгний циррозын хяналт болон элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт (хэвлийн хэт авиан шинжилгээ болон AFP) 6 сар тутамд эмчийн байнгын хяналтанд байх шаардлагатайг зөвлөнө. Бүх хүмүүст амьдралын эрүүл хэв маягийг мөрдөх талаар эрүүл мэндийн боловсрол олгох зөвлөгөөг өгнө.

Б. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ

Б.1 Эрт илрүүлэг

ДЭМБ-аас зөвлөсөн түргэвчилсэн оношлуураар гепатитын С вирусийн халдварт илрүүлэх шинжилгээг хийнэ. Шинжилгээний хариу зерэг гарсан тохиолдолд рефлекс шинжилгээ хийх буюу тэр даруй вирус тодорхойлох шинжилгээ хийнэ.

Эрсдэлд суурилсан илрүүлэг

Гепатитын вирусийн халдварт өртөх эрсдэлтэй бүлгийн хүн амд халдварт илрүүлэх шинжилгээг хийнэ. Үүнд:

- Эрхэлсэн ажил мэргэжлээс хамаарах эрсдэлтэй бүлэг
- Эрүүл мэндийн байдлаас хамаарах эрсдэлтэй бүлэг
- Амьдралын хэв маяг, бэлгийн зан үйлээс хамаарах эрсдэлт бүлэг

Хүн амд суурилсан илрүүлэг (universal)

"Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлберийн хүрээнд 2017–2020 онд 15-аас дээш насны иргэдийг гепатитын вирусийн халдвартын эрт илрүүлэгт хамруулсан. 2022 оны 5 сараас эхэлсэн хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн хийж буй эрт илрүүлгийн хүрээнд 18-аас дээш насны хүнд гепатитын С ба В вирусийн халдвартыг илрүүлэх шинжилгээг хийж байна.

Жирэмсэн эхийн илрүүлэг

Жирэмсэн эмэгтэй бүрт гепатитын С ба В вирусийн халдвар илрүүлэх шинжилгээг (anti-HCV, HBsAg) хийнэ.

Б.2 Халдварыг илрүүлэх, ачаалал тодорхойлох шинжилгээ

Гепатитын вирусийн илрүүлэг ба вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээг Эрүүл мэндийн сайдын “Заавар, техникийн тодорхойлолт батлах тухай” тушаалын дагуу хийж гүйцэтгэнэ.

Гепатитын С вирусийн халдварт өртсөн эсэхийг anti-HCV илрүүлэх шинжилгээгээр тогтооно. anti-HCV нь халдварт өртсөнээс хойш 2-3 сарын дараа цусанд илэрдэг. Цочмог халдварын эхний 2-3 сард цусанд anti-HCV тодорхойлогдохгүй байвал цонх үе гэж үзнэ. Цонх үээс 3 сарын дараа шинжилгээг давтан хийж, оношийг баталгаажуулна. Гепатитын С вирусийн халдварт өртсөн хүмүүсийн 15-45%-д нь халдварт өртсөнээс хойших 6 сарын дотор вирус арилж болно. anti-HCV илэрсэн ч HCV-RNA тодорхойлогдохгүй байх нь гепатитын С вирусийн халдвартыг илтгэнэ. Иймээс цусанд anti-HCV илрэх нь одоогийн халдвар ба халдварт өртөж байсныг аль алийг нь илэрхийлнэ. Гепатитын С вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдаж, С вирус нь бүрэн эмчлэгдсэн хүнд ч ийлдэс судлалын шинжилгээнд anti-HCV илэрсэн хэвээр байх тул зөвхөн HCV-RNA тодорхойлох шинжилгээг үндэслэн идэвхтэй халдварыг тогтооно [14].

Лабораторит сууринсан вирусийн нуклейн хүчлийн шинжилгээний өөр хувилбар нь гепатитын С вирусийн цөмийн (p22) эсрэгтөрөгчийг илрүүлэх шинжилгээ юм. Гепатитын С вирусийн цөмийн эсрэгтөрөгч (HCVcAg) буюу гепатитын С вирусийн нуклеокапсид пептид 22 [p22] нь вирусийн идэвхжлийн үед цусны сийвэнд ялгардаг бөгөөд халдварын эхэн болон бүх үед илэрдэг тул шинжилгээгээр халдварын идэвхжил, виремийг үнэлэх боломжтой [15,16]. HCVcAg илрүүлэх ийлдэс судлалын аргууд нь нуклейн хүчлийн шинжилгээтэй харьцуулахад зардал бага, төвлөрсөн лаборатори шаардахгүй боловч энэхүү шинжилгээний хэрэглээ хязгаарлагдмал байна. Одоогоор HCVcAg-ийг бие даан илрүүлэх хэд хэдэн оношуурыг худалдаанд гаргаж байна [15–18]. HCVcAg нь anti-HCV эрт илрэх боломжтой тул HCVcAg-ийг илрүүлэх нь дөрөв дэх үеийн HCV Ag/Ab зэрэг илрүүлэх комбо ийлдэс судлалын шинжилгээнд нэмэлт маркер болгон ашиглаж болно.

Тусlamж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэхийн тулд эрт илрүүлгийн шинжилгээний хариу эерэг бол рефлекс шинжилгээний зарчмаар HCV-RNA тодорхойлох шинжилгээг тэр даруй сорьц авч, боломжтой газарт HCV-RNA тодорхойлох шинжилгээг тэр дор нь хийж, тухайн өдөртөө эмчилгээг шийдвэрлэнэ.

Тусlamж үйлчилгээний цэгт (point-of-care) буюу өвчтений дэргэд хийх шинжилгээг эрсдэлт хүн ам болох мансууруулах бодис тарьдаг, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал, хяналтад ороход түвэгтэй, хүрч үйлчлэхэд алслагдсан орон нутагт оршин суугаа хүмүүст вирусийн халдварыг оношлох нэмэлт арга болгон ашиглахыг зөвлөж байна.


Тусlamж үйлчилгээний цэгт цусанд түргэвчилсэн шинжилгээ (anti-HCV) болон шинэ технологийн аргад ДЭМБ-аас Xpert гепатитын С вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээг (Сефеид, АНУ) дурдажээ [19].

Молекул биологийн технологи полимеразын гинжин урвал (ПГУ) эсвэл нуклейн хүчлийн дараалалд сууринсан олшруулалт (NASBA) эсвэл транскрипцэд сууринсан олшруулалт (TMA) нь маш бага хэмжээний вирусийн нуклейн хүчлийг (РНХ, ДНХ

эсвэл нийт нуклейн хүчил) илрүүлж чаддаг. Хэдийгээр нуклейн хүчлийн шинжилгээний технологи нь виремийг (цусанд вирус байгааг) илрүүлэхэд маш мэдрэмтгий, өвөрмөц шинж чанартай байдаг ч тусгай анализатор эсвэл нарийн лабораторийн тоног төхөөрөмж, чадварлаг боловсон хүчин шаарддаг.

Гепатитын С вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээг бодит хугацааны ПГУ-ын аргаар, илрүүлэх доод хязгаар нь 20 IU/ml буюу түүнээс бага өөрөөр хэлбэл шинжлүүлэгчийн цусанд 20 IU/ml буюу түүнээс дээш хэмжээний HCV-RNA байхад олж илрүүлэх чадвартай өндөр нарийвчлалтай тоног төхөөрөмжтэй, лабораторийн чанарын гадаад хяналтын хөтөлбөрт тогтмол хамрагддаг, бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчний нөөц бүхий лабораторид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн оношуур урвалж, стандарт, хяналт ашиглан хийнэ.

Манай улсад өмнө хийгдсэн судалгаагаар гепатитын С вирусийн халдвартай хүмүүсийн 98% нь вирусийн 1b генотиптэй байна. Иймээс ихэнх хүмүүст 1b генотипийн эмчилгээг сонгох боломжтой боловч эмчлэгч эмч шаардлагатай гэж үзвэл вирусийн генотипийг (1a, 1b, 2, 3, 4, 5 ба 6) ялган дүйх шинжилгээг нэмэлтээр хийж эмчилгээний загвар, эмчилгээ үргэлжлэх хугацааг сонгоход ашиглана.




Зураг Б.1. Гепатитын С вирусийн эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний дараалал B. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ

B.1 Эмнэлзүйн явц

Гепатитын С вирусийн халвар нь цочмог ба архаг явцтай. Гепатитын С вирусийн цочмог халварын 15–45% нь аяндаа эдгэрдэг бол 55–85% нь архаг халдварт шилждэг [11–13].

Гепатитын С вирусийн халдвартай ихэнх өвчтөний цусанд anti-HCV нь фермент холбох урвалын (enzyme immunoassay, EIA) шинжилгээгээр илрэх боловч цочмог халварын эрт үед ба дархлаа дарангуйлагдсан хүнд сөрөг гарч болно. Цочмог халвар аяндаа эдгэх эсвэл эмчилгээ хийлгэж эдгэрсэн HCV-RNA тодорхойлогдохгүй болсон үед ч anti-HCV илэрсээр байдаг. Гэвч зарим хүнд вирус тодорхойлогдохгүй болсноос хойш anti-HCV титр буурч сөрөг болж болно.




Зураг В.1. Гепатитын С вирусийн халдварын эмнэлзүйн явц

Гепатитын С вирусийн цочмог, архаг халдварын оношилгоо нь HCV-RNA тодорхойлох шинжилгээнд үндэслэнэ. anti-HCV илрэх нь халдварт өртсөн байдлыг илэрхийлэх бол вирусийн нуклейн хүчлийн ачаалал (HCV-RNA) тодорхойлогдож байх нь идэвхтэй халдварыг илэрхийлнэ. Гепатитын С вирусийн архаг халдварын үед ихэнхдээ шинж тэмдэг илрэхгүй байсаар 15-30% нь элэгний циррозд шилжих ба [11–13] эдгээрийн 2-4%-д элэгний хорт хавдар үүсдэг (Зураг В.1).

Гепатитын С вирусийн архаг халдварын үед элэгний фиброзын зэргийг тодорхойлох нь элэгний цирроз, элэгний хорт хавдрын оношилгоо, эмчилгээний асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэхэд ач холбогдолтой. Элэгний цирроздын ээнэгшилгүй үед хэвлэлийд шингэн хурах, улаан хоолой, ходоодны хураагуур судас өргөсөх, цус алдах, дэлүү томрох, хавдар үүсэх, элэгний дутагдал давамгайлсан олон эрхтний дутагдал, үжил зэрэг амь насанд аюултай хүндрэлүүд үүсдэг тул элэгний циррозд оношлогдсон үеэс улирал тутамд хяналт хийнэ.

B.2 Ерөнхий ба бодит үзлэг, багажийн шинжилгээ

Гепатитын С вирусийн идэвхитэй халдвартай хүнд вирусийн эсрэг шууд үйлчилгээт эмийн эмчилгээ өхлэхийн өмнө элэгний фиброз/цирроз, элэгний үйл ажиллагаа, цусны дэлгэрэнгүй шинжилгээ, бөөрний үйл ажиллагаа, хавсарсан өвчлөл болон эмийн хэрэглээ зэргийг үнэлнэ (Зураг B.2).



*Элэгний циррозтой өвчтөнүүдэд нэмэлтээр заавал хийнз.

Zuраг B.2 Гепатитын С вирусийн халдвартын оношилгоо, эмчилгээ

B.2.1 Элэгний фиброз, циррозыг үнэлэх

Гепатитын С вирусийн эмчилгээг өхлүүлэхийн өмнө элэгний фиброзыг үнэлэх ба энэ нь эмчилгээний горим, эмчилгээний хугацааг сонгоход дөхөм болно. Элэгний фиброзыг үнэлэх хатгалтын ба хатгалтын бус аргуудыг ашиглана. Орчин үед элэгний биопсийн шинжилгээний хүндэрэл (өвдөлт, цус алдах гэх мэт), олон дахин хийх боломжгүй зэргээс шалтгаалан хатгалтын бус аргаар элэгний фиброзыг тодорхойлох шинжилгээг эмнэл зүйд өргөнөөр ашиглаж байна.

1. Элэгний фиброзын зэргийг үнэлэх хатгалтын арга: Элэгний эдийн шинжилгээ (элэгний биопси) нь элэгний фиброз, цирроз оношлох алтан стандарт арга юм. Шалтгаан тодорхойгүй элэгний үйл ажиллагааны өөрчлөлт илрэх, аутоиммун гепатит, цирроз, элэгний хорт хавдрын сэжигтэй ба шалтгаан тодорхойгүй

циррозын үед хийгдэнэ.

2. Элэгний фиброзын зэргийг үнэлэх хатгалтын бус арга: APRI, FIB-4 аргаар (<https://www.mdcalc.com/calc/3094/ast-platelet-ratio-index-apri>, <https://www.mdcalc.com/calc/2200/fibrosis-4-fib-4-index-liver-fibrosis>) дунд зэргийн сорвижлыг (META VIR ийн үнэлгээгээр F2-F3, Хүснэгт В.1) тогтоох боломжгүй боловч эдгээр аргууд нь хямд, хэрэглэхэд хялбар тул эмчилгээний загварыг сонгоход тустай.

Хүснэгт В.1 Элэгний фиброзыг тодорхойлох META VIR үнэлгээ

META VIR үнэлгээ	F0	F1	F2	F3	F4
	Фиброзгүй	Бага фиброз	Дунд фиброз	Илт фиброз	Элэгний цирроз

Фиброскан, транзит эластографи нь оношилгооны нарийвчлал сайтай давтан шинжлэхэд аюулгүй давуу талтай, элэгний фиброзыг үнэлэх инвазив бус арга юм. Өвчтөнд 10 удаагийн амжилттай хэмжилт хийж дундаж хэмжилтийг хариу болгоно. Гепатитын С вирусийн халдвартын үед цирроз оношлох cut off утга 14.5кПа болон түүнээс дээш байна.

B.2.2 Элэгний эмгэг ба хүндрэл оношлох, үнэлэх стандарт шинжилгээ

Лабораторийн шинжилгээ:

ЦЕШ, элэгний үйл ажиллагаа (ACAT, АЛАТ, ГГТП, нийт ба шууд билирубин, шүлтлэг фосфотаза, альбумин, нийт уураг, амилаза), INR, бөөрний үйл ажиллагаа (креатинин), сахар, холестерин, триглициерид, их нягтралт, бага нягтралт липопротейд, бамбайн даавар (TSH, T3, T4), ба элэгний хавдрын маркер (AFP, боломжтой бол PIVKA II)

Элэг гэмтээг бусад шалтгааныг ялгах шаардлагатай үед:

Хавсарсан халдвартын буюу ХДХВ/ДОХ, ГВВ ба ГДВ-ийн халдвартын (anti-HIV IgG, HBsAg, anti-HBs, anti-HBc, anti-HDV IgM, anti-HDV IgG),

Элэгний аутоиммуун маркер

Дүрс оношилгооны аргууд:

Хэвлэлийн хэт авиан шинжилгээ, шаардлагатай тохиолдолд хэвлэлийн тодосогчтой КТ, соронзон резонанс томографийн шинжилгээг хийнэ.

Улаан хоолой, ходоодны уян дуран: улаан хоолой, ходоодны варикоз үнэлэх

B.2.3 Хавсарсан өвчин ба эмийн харилцан үйлчлэл үнэлэх

ВЭШҮ эмийн эмчилгээг олон улсад бүх шатлалын эмнэлгийн байгууллагуудад гепатитын С вирусийн халдвартай өвчтөнд эрсдэл багатай, өндөр үр дүнтэй байна. Гэвч эмчилгээний өмнө хавсарсан өвчин болон хэрэглэж байгаа эмийг нягталж үнэлэх нь эмчилгээний үеийн хяналтын давтамж болон хялбаршуулсан горимоор эмчилж болох эсэхийг сонгоход маш чухал.

Хавсарсан өвчингүй элэгний циррозгүй, зэнэгшилтэй цирроэстий, нэмэлт эмийн хэрэглээгүй, өмнө нь эмчилгээнд хамрагдаж байгаагүй насанд хүрсэн хүнийг хялбаршуулсан горимоор эмчилгээнд хамруулж болно.

Харин хавсарсан өвчлөлтэй тухайлбал чихрийн шижин, бөөрний эмгэг, хавсарсан халдвартай (ХДХВ, ГВВ г.м), нэмэлт эмийн хэрэглээтэй, өмнөх эмчилгээ амжилтгүй болсон эсвэл 3-аас дээш насны хүүхдийг төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтад эмчилнэ. ВЭШҮ эмийн эмчилгээний үед протоны шахуургын дарангуйлагч, статины төрлийн эм, этилэстрадиол агуулдаг жирэмснээс хамгаалах бэлдмэл, уналт таталтын эсрэг эм, амиодарон, дархлаа дарангуйлагч циклоспорины дарангуйлагч, mTOR дарангуйлагч болон РВЭ эмүүдтэй харилцан үйлчлэл үүсч болзошгүй. Ялангуяа, софосбувитрэй хавсарсан эмүүдийг амиодаронтой хэрэглэх үед ноцтой брадикарди үүсдэг тул эсрэг заалттай. ВЭШҮ эмийн харилцан үйлчлэлийг (<https://uptodate.druginteractions.com/>) нягталж шалгахыг зөвлөж байна.

B.2.4 Архины хэрэглээг тодорхойлох, зөвлөгөө өгөх

Гепатитын С вирусийн халдвартай хүн бүрт архины хэрэглээг үнэлж, дунд ба өндөр хэрэглээтэй бол архи хэрэглэх зан үйлийг бууруулах арга хэмжээг авч эхлэх хэрэгтэй.

Архи, тамхи, мансууруулах сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ, эрсдэлийг эрт илрүүлэхэд ASSIST (Alcohol, Smoking, Substance Involvement Screening Test) сорилыг ашиглана. ASSIST нь сэтгэц нөлөөт зан үйлийг илрүүлэхэд чиглэсэн ДЭМБ-ын зөвлөмж бөгөөд эрүүл мэндийн анхан шатны байгууллагад түгээмэл хэрэглэдэг сорил юм. ASSIST сорил нь дараах 3 хэсгээс бүрддэг.

- ASSIST эрт илрүүлгийн асуумж
- ASSIST сууриссан эрсдэлт зан үйлийг запруулах зөвлөмж
- Өөрөө өөрийгөө үнэлж, зан үйлээс татгалзах, өөрийгөө өөрчлөх зөвлөмж.

ASSIST зөвлөмж нь 5-10 минут орчим стандарт ярилцлага хийж, эрсдэлт оноог үнэлэн, тусlamж үзүүлэх түвшинг тодорхойлдог. Дараах 3 түвшний эрсдлийг илрүүлнэ. Үүнд:

- Бага эрсдэлтэй: тусlamж, зөвлөгөө шаардлагагүй
- Дунд эрсдэлтэй: энгийн тусlamж хэрэгтэй
- Өндөр эрсдэлтэй: зан үйлийг үнэлэх, эмчлэх мэргэжилтэн шаардлагатай.

B.3. Вирусийн эсрэг эмчилгээ

Гепатитын С вирусийн эсрэг эмчилгээ нь өндөр үр дүнтэй, эмчилгээний дараа элэгний бүтцийн өөрчлөлт засарч сайжрах алсын үр дүн сайн бөгөөд эмчилгээний өртөг буурсан, хүртээмж сайжирсантай холбоотойгоор гепатитын С вирусийн ачаалал тодорхойлгдсон, эмчилгээний эсрэг заалтгүй, эмчлүүлэх хүсэлтэй хүн бүрийг эмчилгээнд хамруулна.

Гепатитын С вирусийн эсрэг шууд үйлчилгээт эмийн эмчилгээ хийснээр элэгний өвчний хүндрэл болох элэгний цирроз, элэгний хорт хавдрын өвчлөл болон нас барагтыг бууруулдаг болохыг судалгаагаар харуулсан [20–22].

Олон улсын хэмжээнд бүх генотип нөлөөт – пангенотипын эмчилгээг өргөн хэрэглэх болж, өмнө нь эмчилгээ хийлгэж байгаагүй, элэгний циррозгүй эсвэл ээнэгшилтэй циррозтой гепатитын С вирусийн халдвартай хүнд хялбаршуулсан горимоор тусlamж үзүүлэхийг зөвлөж байна. Хялбаршуулсан горим нь тусlamж үйлчилгээг хүртээмжтэй болгож, халдвартай тархалтыг таслан зогсох боломж бүрдүүлэх юм. Олон улсад хийсэн судалгаагаар хялбаршуулсан горимоор тусlamж үйлчилгээ үзүүлэхэд гарч буй үр дүн нь хэвийн горимоор хянаж, эмчилгээтэй адилхан байсан [23]. Хялбарчилсан горимоор ГСВ эмчилгээ хийхэд гол анхаарах зүйл нь өвчтөнийг зөв сонгох юм (Зураг B.3).

Халбаршуулсан горимын дагуу эмчилгээ, хяналт хийж болох хүмүүс:

ГСВ-ийн архаг халдвартай насанд хүрэгчид, үүнд ХДХВ- халдвартай хүмүүс орж болно:

- Аль ч генотипийн халдвэр байж болно
- Өмнө нь ГСВ-ийн эмчилгээ хийлгэж байгаагүй
- Циррозгүй эсвэл ээнэгшилтэй циррозтой (Чайлд-Пью А) болох нь дараах шинжилгээгээр бататгасан :
 - ▶ FibroScan >12.5kPa
 - ▶ FIB-4 >3.25
 - ▶ Инвазив бус ийлдэс судлалын шинжилгээ
 - ▶ Элэгний биопси
 - ▶ Хэт авиа; элэгний зангилаа эсвэл дэлүү томрох
 - ▶ Ялтас эс < 150,000/mm³

Стандарт хяналтын дагуу төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтад илгээх хүмүүс:

ГСВ-ийн архаг халдвартай насанд хүрэгчид:

- Өмнө нь ГСВ-ийн эмчилгээнд хамрагдсан
- HBsAg зэрэг илэрсэн
- Ээнэгшилтэй циррозтой (Чайлд-Пью А) бөөрний төгсгелийн шатны эмгэгтэй ($eGFR<30\text{ mL/min/m}^2$)
- Одоогийн эсвэл хуучин ээнэгшил алдсан циррозтой, Чайлд-Пью оноо ≥ 7
- Жирэмсэн эмгэгтэй
- Элэгний хорт хавдар
- Элэг шилжүүлэн суулгасан

Зураг В.3 Гепатитын С вирусийн халдвартай насанд хүрэгчдэд анхын эмчилгээний хялбаршуулсан горим

B.3.1 Анх удаагийн эмчилгээ

Пангенотипын ВЭШҮ эмчилгээ гарснаар анх эмчилгээ хийлгэж байгаа хүний эмчилгээний хугацаа богиносох боломжтой болсон. Олон улсын, нэг бүлэгт, нээлттэй, эмнэлзүйн 3-р шатны EXPEDITION-8 “Өмнө нь эмчилгээнд хамрагдаж байгаагүй ГСВ (генотип 1-6) архаг халдвартай, ээнэгшилтэй циррозтой хүнд глекапревир/пибрентасвир 8 долоо хоног хэрэглэсэн нь” судалгааны үр дүнд тулгуурлан эмчилгээний хугацааг богиносгосон [24]. Мөн POLARIS-3 эмнэлзүйн 3-р шатны судалгааны үр дүнд тулгуурлан софосбувир/велпатасвир/воксилапревир хавсарсан эмийг генотип 3 халдвартай хүмүүсийн эмчилгээнд 2-р эгнээний сонголтоор зөвлөх болсон [25]. Элбасвир/гразопревирыг генотип 1а халдвартай хүмүүсийн эмчилгээнд нэгдүгээр сонголтоор зөвлөж байсан нь өөрчлөгдөж 2-р эгнээний сонголт болгосон нь RAS (resistance-associated substitution) шинжилгээ хийх шаардлагаас үүдэлтэй байна. Хүснэгт В.3-т анхны удаа хийх эмчилгээний сонголтуудыг харуулав.

Хүснэгт В.3 Гепатитын С вирусийн халдвартай насанд хүрэгчдэд анх удаа хийх эмчилгээ

Эмчилгээний дэглэм	Генотип	Ангилал	Үргэлжлэх хугацаа	Нотолгоо	Анхааруулга ба бусад анхаарах зүйлс
Элэгний циррозгүй эсвэл ээнэгшилтэй циррозтой, өмнө нь эмчилгээнд орж байгаагүй өвчтөн					
Глекапревир (300мг)/ Пибрентасвир (120мг)	1-6	1-р эгнээний сонголт	8 долоо хоног	I, A ^a	
Софосбувир (400мг)/ Велпатасвир (100мг)	1-6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, A ^b	Ээнэгшилтэй циррозтой генотип 3-ын халдвартай үед NS5A RAS шинжилгээ хийнэ. Хэрвээ

					NS5A Y93H илэрвэл жингээс хамаарч Рибавирийн нэмэх эсвэл бусад эмчилгээний дэглэм сонгоно.
Ледипасвир (90мг)/ Софосбувир (400мг)	1,4,5,6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, A ^c	6 ^е генотипын халдвартай үед зөвлөхгүй
	Цирроз гүй генотип 1	1-р эгнээний сонголт	8 долоо хоног	I, B	ХДХВ хавсарсан халдвартай, элэгний циррозгүй өвчтэнд хэрэглэх боломжтой, мөн HCV-RNA <6 сая IU/mL бага байх
Софосбувир (400мг)/ Даклатаасвир (60мг*)	1-4	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, A*	
Элбасвир (50мг)/ Гразопревир (100мг)	1b, 4	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, A ^d	
	1a	2-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, A	1а генотипын халдвартай үед NS5A RAS шинжилгээ хийнэ. Хэрвээ RAS-үүд илэрвэл (өөрөөр хэлбэл, 28, 30, 31, эсвэл 93 амин хүчлийн байрлалд орлуулах мутаци), бусад эмчилгээний дэглэм хэрэглэнэ.
Софосбуви р (400мг)/ Велпатаасви р (100мг) +Рибавирийн**	3	2-р эгнээний сонголт	12 долоо хоног	IIa, A	Ээнэгшилтэй циррозтой 3 генотипын халдвартай болон NS5a Y93 RAS суурь үзүүлэлттэй бол
Софосбувир (400мг)/ Велпатаасвир (100мг)/ Воксилапрев ир (100мг)		2-р эгнээний сонголт	12 долоо хоног	IIa, B	Ээнэгшилтэй циррозтой 3 генотипын халдвартай болон NS5a Y93 RAS суурь үзүүлэлттэй бол

^a Нотолгооны түвшин нь I, ээнэгшилтэй цирроз B

^b Нотолгооны түвшин нь I, генотип 5, 6 B

^c Нотолгооны түвшин нь I, генотип 5, 6 , генотип 4 болон энэгшилтэй цирроз B

^d Нотолгооны түвшин нь I, генотип 4 болон энэгшилтэй цирроз B

* Ээнэгшилтэй циррозтой хүмүүст 24 долоо хоногийн эмчилгээ хийнэ

** Рибавирийн жинд нь тохируулна >75кг-д 1200мг, <75кг-д 600мг

B.3.2 Давтан эмчилгээ

ВЭШҮ эмийн эмчилгээнд орсон хүмүүсийн тодорхой хувьд эмчилгээ үр дүнгүй болж, давтан эмчилгээ хийх шаардлага тулгардаг. Давтан эмчилгээний сонголтуудыг Хүснэгт B.4-т нэгтгэн харуулав.

Софосбувир суурьтай эмчилгээ үр дүнгүй болсон хүмүүст Софосбувир/ Велпатасвир/ Воксилапревир эмчилгээг хийхээр зөвлөсөн [26, 27] бол Глекапревир/Пибрентасвир эмчилгээ үр дүнгүй болсон хүмүүст давтан эмчилгээ хийх зөвлөмжийг MAGELLAN-3 эмнэлзүйн судалгааны үр дүнд тулгуурлан гаргажээ [28].

Хүснэгт B.4 Гепатитын С вирусийн халдвартай насанд хүрэгчдэд эмчилгээ үр дүнгүй болсон үед давтан эмчилгээ

Эмчилгээний дэглэм	Генотип	Ангилал	Үргэлжлэх хугацаа	Нотолгоо	Анхааруулга ба бусад анхаарах зүйлс
Софосбувир суурьтай эмчилгээнд үр дүнгүй болсон, элэгний циррозгүй эсвэл ээнэгшилтэй цирроз					
Софосбувир/ Велпатасвир/ Воксилапревир	1-6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, A	Ээнэгшилтэй циррозтой генотип 3 халдвартай үед эсрэг заалтгүй бол жинд нь тохирсон Рибавирин нэмэх
Глекапревир/ Пибрентасвир	1,2,4,5 ,6	2-р эгнээний сонголт	16 долоо хоног	I, A	NS5A хориглогч болон NS3/4A протеаза хориглогч үр дүнгүй бол өвчтөнүүдэд зөвлөхгүй
Глекапревир/Пибрентасвир эмчилгээнд үр дүнгүй болсон, элэгний циррозгүй эсвэл ээнэгшилтэй цирроз					
Глекапревир/ Пибрентасвир/ Софосбувир + Рибавирин*	1-6	1-р эгнээний сонголт	16 долоо хоног	IIa, B	
Софосбувир/ Велпатасвир/ Воксилапревир	1-6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	IIa, B	Ээнэгшилтэй циррозтой өвчтөнд жинд нь тохирсон Рибавирин нэмэх (IIa, C)
Софосбувир/Велпатасвир/Воксилапревир эсвэл Софосбувир + Глекапревир/ Пибрентасвир эмчилгээнд үр дүнгүй болсон, элэгний циррозгүй эсвэл ээнэгшилтэй цирроз					
Глекапревир/ Пибрентасвир + Софосбувир + Рибавирин*	1-6	1-р эгнээний сонголт	16 долоо хоног	IIa, B	Дараах хүнд тохиолдлуудад (ээнэгшилтэй циррозтой генотип 3 халдвартай үед) эсвэл Софосбувир + Глекапревир/ Пибрентасвир эмчилгээнд үр дүнгүй байсан бол эмчилгээг 24 долоо хоног сунгах боломжтой

Софосбувир/ Велпатаасвир/ Воксилапревир +Рибавирин *	1-6	1-р эгнээний сонголт	24 долоо хоног	IIa, B	
------------------------------------------------------------------	-----	----------------------------	-------------------	--------	--

*Рибавириныг жинд нь тохируулна >75кг-д 1200мг, <75кг-д 600мг

B.3.3 Эмчилгээний үеийн эмийн тогтвортой хэрэглээ

Эмийн хэрэглээг урт хугацаагаар таслах нь эмчилгээ үр дүнгүй болоход нөлөөтэй. Зарим судалгаанд ВЭШҮ эмчилгээ хийлгэж байгаа хүмүүсийн багагүй хувь нь эмийн хэрэглээг тасалдуулдаг болохыг мэдээлжээ [29, 30]. Өмнө нь эмчилгээ хийлгэж байгаагүй, циррозгүй эсвэл ээнэгшилтэй цирроэзийг глекапревир/ пибрентасвир эсвэл софосбувир/ велпатаасвир хэрэглэж байгаа өвчтөнүүдэд эмийн хэрэглээ тасалдах үед эмийн эмчилгээг дахин эхлүүлэх зааврыг Зураг B.4-т үзүүлэв.

ВЭШҮ эмийн эмчилгээний эхний 28 хоног дотор эмчилгээ тасалдуулах үед

7 болон түүнээс бага хоног тасалсан бол

ВЭШҮ эмийн эмчилгээг яаралтай дахин эхлүүлж анх төлөвлөсөн хугацаагаар эмчилгээг хийж дуусгах (8 эсвэл 12 долоо хоног)

8 болон түүнээс олон хоног тасалсан бол

- ВЭШҮ эмийн эмчилгээг яаралтай дахин эхлүүлэх нь HCV-RNA үзэхээс илүү чухал.
- HCV-RNA аль болох хурдан шинжлэх, эсвэл ВЭШҮ эмчилгээг дахин эхлүүлсэн едрээ шинжлэх
- Хэрвээ HCV-RNA серег (тоологдохгүй) гарвал үндсэн эмчилгээний төлөвлөгөөг дагах (8 эсвэл 12 долоо хоног). Генотип 3 болон/эсвэл ээнэгшилтэй цирроэзийг өвчтөнд ВЭШҮ эмчилгээг 4 долоо хоног сунгах.
- Хэрвээ HCV-RNA зөврөг (>25IU/L тоологдовол) эсвэл HCV-RNA шинжилгээ хийгээгүй тохиолдолд ВЭШҮ эмчилгээг нэмэлт 4 долоо хоног үргэлжлүүлэх.

ВЭШҮ эмийн эмчилгээний 28 хоногоос хойш эмчилгээ тасалдуулах үед

7 болон түүнээс бага хоног тасалсан бол

ВЭШҮ эмийн эмчилгээг яаралтай дахин эхлүүлж анх төлөвлөсөн хугацаагаар эмчилгээг хийж дуусгах (8 эсвэл 12 долоо хоног)

8-20 хоног дараалан тасалсан бол

- ВЭШҮ эмийн эмчилгээг яаралтай дахин эхлүүлэх нь HCV-RNA үзэхээс илүү чухал.
- HCV-RNA аль болох хурдан шинжлэх, эсвэл ВЭШҮ эмчилгээг дахин эхлүүлсэн едрээ шинжлэх
- Хэрвээ HCV-RNA серег (тоологдохгүй) гарвал үндсэн эмчилгээний төлөвлөгөөг дагах (8 эсвэл 12 долоо хоног). Генотип 3 болон/эсвэл ээнэгшилтэй цирроэзийг өвчтөнд ВЭШҮ эмчилгээг 4 долоо хоног сунгах.
- Хэрвээ HCV-RNA зөврөг (>25IU/L тоологдовол) эсвэл HCV-RNA шинжилгээ хийгээгүй тохиолдолд DAA эмчилгээг зогсох, цаашид сэдрэх үеийн эмчилгээний зөвлөмжийг баримтлах

21-ээс дээш хоног дараалан тасалсан бол

ВЭШҮ эмийн эмчилгээг зогсох ба вирусийн тогтвортой хариу урвалыг (SVR12) үзэлэх. Хэрвээ SVR12 үр дүнгүй бол сэдэрэлийн эмчилгээний зөвлөмжийг мэrdж дахин эмчилгээ хийх.

Зураг B.4 Гепатитын С вирусийн ВЭШҮ эмийн эмчилгээг тасалсан тохиолдолд эмчилгээний зөвлөмж

Гепатитын С вирусийн халдвартай, анх удаа эмчилгээ хийлгэж буй элэгний циррозгүй насанд хүрэгчдийн оношилгоо, эмчилгээний хялбаршуулсан заавар

Эмчилгээнд хамрагдах заалт

Элэгний циррозгүй, өмнө нь эмчилгээнд орж байгаагүй, хавсарсан өвчлөлгүй гепатитын С вирусийн халдвартай насанд хүрэгчид

Эмчилгээний эсрэг заалт

Дараах хүмүүс энэ заавраар эмчилгээнд орж болохгүй

- Өмнө нь эмчилгээ хийлгэж байсан
- Циррозтой
- Хавсарсан халдвартай (ГВВ-ийн халдвартай гм)
- Жирэмсэн
- Хорт хавдар
- Элэг шилжүүлэн суулгасан
- Хүүхэд
- Хавсарсан эмгэгтэй

Эмчилгээнээс өмнө хийгдэх шинжилгээнүүд

- Элэгний цирроз, фиброз үнэлэх - дор дурдсаны аль нэг бол циррозтой гэж үзнэ
 - FIB-4 оноо >3.25
 - Фиброскан $>12.5\text{kPa}$
 - Эмнэлзүйн шинж (Хэвлэйн хэт авиан шинжилгээнд дэлүү том, элэг барзгар, ялтас эс $<150,000/\text{mm}^3$ гм)
- Хэрэглэж байгаа эмүүд, хавсарсан өвчлөлд байнга уудаг эмүүдийг асууж эм хоорондын харилцан үйлчлэл гарах эсэхийг үнэлэх, доорх холбоосоор орж үнэлгээ хийнэ (<https://www.hep-druginteractions.org/>)
- Хэвлэйн хэт авиа
- Өвчтөнд эмээ таслахгүй уух, эм нэмэлтээр уух бол эмчтэй зөвлөх
- Лабораторийн шинжилгээнүүд
 - Цусны ерөнхий шинжилгээ
 - Элэгний үйл ажиллагааны шинжилгээ
 - Эмэгтэйд жирэмсэн эсэхийг эмчилгээний өмнө шинжлэх
 - Хавсарсан халдвартай эсэхийг тогтоох (ГВВ, ХДХВ)
 - eGFR (бөөрний түүдгэнцэрийн шүүх хурдыг Cockcroft ба Gault-ийн томъёо)

Эмчилгээний сонголт

- Глекапревир 300мг/Пибрентасвир 120мг — 8 долоо хоног (хоолтой хамт)
- Софосбувир 400мг/Велпатасвир 100мг — 12 долоо хоног
- Софосбувир 400мг/Ледипасвир 90мг — 12 долоо хоног
- Софосбувир 400мг/Даклатаасвир 60мг — 12 долоо хоног

Эмчилгээний үеийн хяналт

- Чихрийн шижинтэй өвчтөнд гипогликеми үүсч болзошгүй тул глюкозын хяналтыг байнга хийнэ
- Варфарин ууж буй өвчтөнд цусны бүлэгнэлт өөрчлөгдөж болох тул INR

тогтмол хянана

- Шаардлагатай бол нэмэлт үзлэг төлөвлөнө

Эмчилгээний дараах хяналт

- Эмчилгээ дууссанаас 3 буюу түүнээс дээш сарын дараа элэгний үйл ажиллагааны болон HCV-RNA тодорхойлох шинжилгээг давтана
- HCV-RNA тодорхойлох шинжилгээгээр эмчилгээ үр дүнг (SVR) үнэлнэ
- Эмчилгээ үр дүнтэй (SVR12), элэгний циррозгүй, элэгний үйл ажиллагааны хэвийн өвчтөнд нэмэлт хяналт хийх шаардлагагүй
- Гепатитын С вирусийн халдварт авах эрсдэлтэй бол (судсаар мансууруулах бодис хэрэглэх, хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох) эрсдэлийг бууруулах зөвлөгөө өгч, жил бүр хяналтын шинжилгээнд хамрагдах
- Эмчилгээ үр дүнтэй (SVR) болсон боловч элэгний үйл ажиллагаа өөрчлөлттэй байвал элэгний бусад өвчнийг ялгах
- Согтууруулах ундаа хэтрүүлэх, хэт таргалахаас сэргийлэхийг зөвлөнө

Вирусийн тогтвортой хариу урвал (SVR) илрээгүй өвчтний хяналт

- Гепатитын С вирусийн анхны эмчилгээ нь үр дүнгүй, HCV-RNA тодорхойлогдож байвал давтан эмчилгээг төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтад хийнэ.
- Давтан эмчилгээ хийх хүртэл 6-12 сар тутамд элэгний үйл ажиллагаа, ЦЕШ, INR шинжилгээ хийж явцыг үнэлнэ.
- Согтууруулах ундаа хэтрүүлэх, хэт таргалахаас сэргийлэхийг зөвлөнө

Гепатитын С вирусийн халдвартай, эмчилгээ хийлгэж байсан, ээнэгшилтэй циррозтой насанд хүрэгчдийн оношилгоо, эмчилгээний хялбаршуулсан заавар

Эмчилгээнд хамрагдах заалт

Өмнө нь эмчилгээ хийлгэж байсан, элэгний циррозын Чайлд Пью А зэрэгтэй, хавсарсан хүнд өвчингүй гепатитын С вирусийн халдвартай насанд хүрэгчид

Эмчилгээний эсрэг заалт

Дараах хүмүүс энэ заавраар эмчилгээнд орж болохгүй

- ▶ лэгний циррозын ээнэгшил алдагдал CTP ≥ 7 (асцит, элэгний энцефалопати, нийт билирубин $>2.0 \text{ mg/dL}$, альбумин $\leq 3.5 \text{ g/dL}$, INR ≥ 1.7)
 - ▶ Өмнө нь гепатитын С вирусийн эсрэг эмчилгээ хийлгэж байсан
 - ▶ Бөөрний архаг өвчний үе шат 3 болон түүнээс дээш
 - ▶ ГВВ эсвэл ГВВ/ГДВ-ийн хавсарсан халдвар
 - ▶ Жирэмсэн
 - ▶ Хорт хавдар
 - ▶ Элэг шилжүүлэн суулгасан
 - ▶ Хүүхэд
 - ▶ Хавсарсан хүнд эмгэгтэй
- ▶

Эмчилгээ эхлэхээс өмнө хийгдэх шинжилгээнүүд

- Элэгний цирроз, фиброз үнэлэх - дор дурдсаны аль нэг бол цирrozтой гэж үзнэ
 - ▶ FIB-4 оноо >3.25
 - ▶ Фиброскан $>12.5 \text{ kPa}$
 - ▶ Эмнэлзүйн шинж (Хэвллийн хэт авиан шинжилгээнд дэлүү том, элэг барзгар, ялтас эс $<150,000/\text{mm}^3 \text{ гм}$)
- Чайлд Пью оноо тооцох (CTP ≥ 7 бол хялбаршуулсан заавраар эмчилгээнд орохгүй төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтад эмчилгээг хийнэ)
- Хэрэглэж байгаа эмүүд, хавсарсан өвчлөлд байнга уудаг эмүүдийг асууж эм хоорондын харилцан үйлчлэл гарах эсэхийг үнэлэх, доорх холбоосоор орж үнэлгээ хийнэ (<https://www.hep-druginteractions.org/>)
- Хэвллийн хэт авиан шинжилгээнд элэгний хорт хавдар болон асцит үнэлэх
- Эмээ таслахгүй уух, эм нэмжк уух хэрэгтэй бол эмчтэй зөвлөх
- Лабораторийн шинжилгээнүүд
 - ▶ Цусны ерөнхий шинжилгээ
 - ▶ INR
 - ▶ Элэгний үйл ажиллагааны шинжилгээ
 - ▶ Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд жирэмсний тест- эм ууж эхлэхээс өмнө шинжилнэ.
 - ▶ Хавсарсан халдвартай эсэхийг тогтоох (ГВВ, ХДХВ)
 - ▶ eGFR (бөөрний түүдгэнцэрийн шүүх хурдыг Cockcroft ба Gault-ийн томъёо)

Эмчилгээний сонголт

- Глекапревир 300мг/Пибрентасвир 120мг — 8 долоо хоног (хоолтой хамт)
- Софосбувир 400мг/Велпатасвир 100мг — 12 долоо хоног
- Софосбувир 400мг/Ледипасвир 90мг — 12 долоо хоног
- Софосбувир 400мг/Даклатаасвир 60мг — 24 долоо хоног

Эмчилгээний үеийн хяналт

- Эмчилгээний явцад элэгний үйл ажиллагааг хянах ба элэгний үйл ажиллагааны шинжилгээний өөрчлөлт эсвэл арьс салст шарлах зэрэг шинж тэмдэг гарвал лавлагaa шатанд илгээнэ.
- Чихрийн шижинтэй өвчтөнд гипогликеми үүсч болзошгүй тул глюкозын хяналтыг байнга хийнэ.
- Варфарин ууж буй өвчтөнд цусны бүлэгнэлт өөрчлөгдөж болох тул INR-ийг тогтмол хянана.
- Шаардлагатай бол нэмэлт үзлэг төлөвлөнө.

Эмчилгээний дараах хяналт

- Эмчилгээ дууссанаас 3 буюу түүнээс дээш сарын дараа элэгний үйл ажиллагаа, HCV-RNA тодорхойлох шинжилгээг давтана.
- HCV-RNA тодорхойлох шинжилгээгээр эмчилгээ үр дүнтэй (SVR12) болсон эсэхийг үнэлнэ.
- Элэгний хавдрын эрт илрүүлэгт тогтмол хамруулж 6 сар тутамд хэвлийн хэт авиа, AFP шинжилгээ хийнэ.
- Улаан хоолойн варикозын эрт илрүүлэгт хамруулах
- Гепатитын С вирусийн халдвэр авах эрсдэлтэй бол (судсаар мансууруулах бодис хэрэглэх, хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох) эрсдэлийг бууруулах зөвлөгөө өгч, жил бүр хяналтын шинжилгээнд хамрагдах
- Эмчилгээ үр дүнтэй (SVR) болсон боловч элэгний үйл ажиллагаа өөрчлөлттэй байвал элэгний бусад өвчнийт ялгах
- Согтууруулах ундаа хэтрүүлэх, хэт таргалахаас сэргийлэхийг зөвлөнө

Вирусийн тогтвортой хариу урвал (SVR) илрээгүй өвчтөний хяналт

- Гепатитын С вирусийн анхны эмчилгээ нь үр дүнгүй болсон, HCV-RNA тодорхойлогдож буй өвчтөнүүдийг дахин эмчилгээ хийх зааврын дагуу төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтад эмчилнэ
- Дахин эмчилгээ хийх хүртэл 6-12 сар тутамд элэгний үйл ажиллагаа, ЦЕШ, INR шинжилгээ хийж өвчний явцыг үнэлнэ
- Согтууруулах ундаа хэтрүүлэх, хэт таргалахаас сэргийлэхийг зөвлөнө

Г.1 ХҮН АМЫН ӨВӨРМӨЦ БҮЛЭГ

Г.1.1 Ээнэгшил алдагдсан элэгний циррозын үеийн эмчилгээ

Ээнэгшил алдагдсан элэгний циррозтой хүмүүсийг лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад нарийн мэргэжлийн эмчийн хяналтад эмчилгээнд оруулна. Чайлд Пью В, Сангилалд орох хүмүүсийг лавлагаа шатны элэг шилжүүлэн суулгах төвүүдэд илгээж зөвлөгөө авах зайлшгүй шаардлагатай. Ээнэгшил алдагдсан циррозтой өвчтөнүүдэд гепатитын С вирусийн эсрэг эмчилгээний зааврыг Хүснэгт Г.1 болон Хүснэгт Г.2 -с харна уу.

Хүснэгт Г.1 Гепатитын С вирусийн халдвартай, ээнэгшилгүй циррозтой өвчтний эмчилгээ

Эмчилгээний дэглэм	Генотип	Ангилал	Үргэлжлэх хугацаа	Нотолгоо	Анхааруулга ба бусад анхаарах зүйлс
Софосбувир (400мг)/ Велпатасвир (100мг) +Рибавирин*	1-6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, A ^a	Чайлд Пью С циррозтой өвчтөнд рибавирин бага тунгаар (600мг) эхлэхийг зөвлөнө. Өвчтөнд зохимжтой бол тунг нэмнэ.
Софосбувир (400мг)/ Велпатасвир (100мг)	1-6	1-р эгнээний сонголт	24 долоо хоног	I, A ^a	Рибавирин тохирохгүй өвчтөнд зөвлөх боломжтой
Ледипасвир (90мг)/ Софосбувир (400мг) + Рибавирин*	1,4,5,6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, A ^b	Чайлд Пью С циррозтой өвчтөнд рибавирин бага тунгаар (600мг) эхлэхийг зөвлөнө. Өвчтөнд зохимжтой бол тунг нэмнэ.
Ледипасвир (90мг)/ Софосбувир (400мг)	1,4,5,6	1-р эгнээний сонголт	24 долоо хоног	I, A ^b	Рибавирин тохирохгүй өвчтөнүд зөвлөх боломжтой

^a Нотолгоо нь зөвхөн генотип 6 халдвартай, ээнэгшилтэй циррозтой хүмүүст

^b Нотолгоо нь зөвхөн генотип 5, 6 халдвартай, цөөн тооны ээнэгшилтэй циррозтой хүмүүст
*Рибавириныг жинд нь тохируулна >75кг-д 1200мг, <75кг-д 600мг

Хүснэгт Г.2 Гепатитын С вирусийн халдвартай, ээнэгшилгүй циррозтой, өмнө нь софосбувир эсвэл NS5A хориглогч суурьтай эмчилгээ үр дүнгүй болсон өвчтний эмчилгээ

Эмчилгээний дэглэм	Генотип	Ангилал	Үргэлжлэх хугацаа	Нотолгоо	Анхааруулга ба бусад анхаарах зүйлс
Софосбувир эсвэл NS5A хориглогч суурьтай эмчилгээнд үр дүнгүй, ээнэгшилгүй цирроз					
Софосбувир/ Велпатасвир/ + Рибавирин*	1-6	1-р эгнээний сонголт	24 долоо хоног	IIa, C ^a	Чайлд Пью С циррозтой өвчтөнд рибавирин (600мг) бага тунгаар эхлэхийг зөвлөнө. Өвчтөнд зохимжтой бол тунг нэмэх.

Ледипасвир/ Софосбувир + Рибавирин*	1,4,5,6	1-р эгнээний сонголт	24 долоо хоног	IIa, C ^b	Чайлд Пью С циррозтой өвчтөнд рибавирин (600мг) бага тунгаар эхлэхийг зөвлөне. Өвчтөнд зохимжтой бол тунг нэмэх
----------------------------------------------	---------	----------------------------	-------------------	---------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------

^a Нотолгоо нь зөвхөн генотип 5,6 халдвартай, цөөн тооны ээнэгшилтэй цирроз

^b Нотолгоо нь зөвхөн генотип 6 халдвартай, ээнэгшилтэй цирроз

*Рибавириныг жинд нь тохируулна >75кг-д 1200мг, <75кг-д 600мг

Г.1.2 Хүүхдэд хийгдэх эмчилгээ

Гепатитын С вирусийн халдвар хүүхдэд түгээмэл тохиолддоггүй боловч дэлхий дахинд 18-аас доош насы 3.26 сая хүүхэд архаг халдвартай гэсэн тооцоо гаргажээ [31]. Насанд хүрэгчдийн дунд гепатитын С вирусийн халдвар өндөр байгаа улс оронд хүүхдийн дунд өндөр бөгөөд халдвар нь гол телөв эмчилгээний ажилбар, эхээс хүүхдэд дамжина. Ялангуяа ХДХВ/ДОХ-ын халдвартай эхээс хүүхдэд халдвар дамжих эрсдэл 17-25% гэж үздэг. Манай оронд хийгдсэн судалгаагаар хүүхдийн дундах гепатитын С вирусийн халдварын тархалт 0.6-1.1% байна. Эмчилгээний ажилбар хийгдсэн, цус цусан бүтээгдэхүүн сэлбүүлсэн, гепатитын С вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхэд бүрийг гепатитын С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулна.

Хүснэгт Г.3 Хүүхдэд гепатитын С вирусийн халдвар илрүүлэх зөвлөмж

Гепатитын С вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхэд бүрийг 18 сартайгаас хойш anti-HCV илрүүлэх шинжилгээнд хамруулна

Хэрэв хүүхэд 18 сартайгаас хойш anti-HCV илэрвэл 3 наснаас хойш HCV-RNA тодорхойлох шинжилгээг хийж, гепатитын С вирусийн архаг халдварыг батална

Эхээс халдвар авсан байж болзошгүй гепатитын С вирусийн халдвартай хүүхдийн гэр бүлийнхнийг шинжилгээнд хамруулна

Хүүхдэд гепатитын С вирусийн халдвар хүндэрч цирроз, элэгний хорт хавдар болох нь ховор боловч бусад өвчинтэй хавсарсан үед хүндрэх боломжтой.

2017 онд Европын Холбооны эмийн Агентлаг ба АНУ-ын Хүнс, Эмийн Агентлагаас софосбувир (400мг) ба ледипасвир (90мг) холимог шахмал эмийн (генотип 1,4,5 ба 6-д) эмчилгээг 12-17 насы 35кг-аас дээш жинтэй гепатитын С вирусийн архаг халдвартай хүүхдийн эмчилгээнд хэрэглэхийг зөвшөөрсөн. 2021 онд пангенотипын эмчилгээг 3-аас дээш насы хүүхдэд хэрэглэхийг зөвшөөрсөн. Хүүхдүүдийн дунд хийгдсэн эмнэлэлзүйн судалгааны үр дүн насанд хүрэгчдийн үр дүнтэй адилхан байгаа тул 3-аас дээш насы гепатитын С вирусийн халдвартай бүх хүүхдэд ВЭШҮ эмийн эмчилгээг зөвлөсөн байна [32-35].

Хүүхдэд хүүхдийн хоол боловсруулах тогтолцоо судлалаар мэргэшсэн эмчийн байнгын хяналтанд Хүснэгт Г.4 болон Хүснэгт Г.5 -т харуулсан дагуу эмчилгээг хийнэ.

Хүснэгт Г.4 Вирусийн эсрэг эмчилгээний үргэлжлэх хугацаа

Насны ангилал	Пангенотипын ВЭШҮ эмчилгээ			Пангенотипын биш ВЭШҮ эмчилгээ ²
	Софосбувир/ Дакпатасвир ¹	Софосбувир/ велпатасвир	Глекапревир/ пибрентасвир	
>18 нас	12 долоо хоног	12 долоо хоног	8 долоо хоног	12 долоо хоног
12-17 нас	12 долоо хоног	12 долоо хоног	8 долоо хоног	12 долоо хоног
6-11 нас	12 долоо хоног	12 долоо хоног	8 долоо хоног	12 долоо хоног
3-5 нас	12 долоо хоног	12 долоо хоног	8 долоо хоног	12 долоо хоног

¹Өмнө нь эмчилгээ хийлгэж байсан эсвэл ээнэгшилтэй элэгний цирроэзтой бол 24 долоо хоног эмчилгээ хийхийг зөвлөж байна. Генотип 3 өндөр тархалттай (>10%) байгаа нөхцөлд зөвлөж болно.

²Генотип-1, 4, 5, 6 халдвартай бол зөвлөнө.

Хүснэгт Г.5 Эмчилгээний тунг жинд тооцох

Пангенотипын ВЭШҮ эмчилгээ			Пангенотипын биш ВЭШҮ эмчилгээ ¹
Софосбувир/ Дакпатасвир ²	Софосбувир/ велпатасвир	Глекапревир/ Пибрентасвир ³	Софосбувир/ ледипасвир
26кг-аас дээш бол 400/60 мг өдөрт 1 удаа уух (шахмал эм)	30 кг-аас дээш бол 400/100 мг өдөрт 1 удаа уух (шахмал эм)	45 кг-аас дээш бол 300/120 мг өдөрт 1 удаа уух (шахмал эм эсвэл 6 пакет үрлэн эм)	35 кг-аас дээш бол 90/400 мг өдөрт 1 удаа уух (шахмал эм)
14-25 кг жинтэй бол 200/30 мг өдөрт 1 удаа уух (Софосбувир 100мг жижиг шахмалаар хэрэглэх)	17-29 кг жинтэй бол 200/50 мг өдөрт 1 удаа уух (шахмал эм эсвэл капсул эм)	30-45 кг жинтэй бол 250/100 мг өдөрт 1 удаа уух (5 пакет үрлэн эм) 20-30 кг жинтэй бол 200/80 мг өдөрт 1 удаа уух (4 пакет үрлэн эм)	17-35 кг жинтэй бол 45/200мг уух (шахмал эм)
	17 кг-аас доош бол 150/37.5 мг өдөрт 1 удаа уух (бүрхүүлтэй капсул эм)	20 кг-аас доош бол 150/60 мг өдөрт 1 удаа уух (3 пакет үрлэн эм)	17 кг-аас доош бол 33.75/150 мг уух (шахмал капсул үрлэн эм)

¹Генотип 1, 4, 5, 6-ийн халдвартай эсвэл генотип 3-ийн халдвар ховор тохиолддог бүс нутагт хэрэглэнэ. Сахарын цэлөөс өмнөх Африкийн зарим бүс нутаг, улс орнуудад

генотипийн дэд хэвшиижүйгээр гепатитын С вирусийн халдвартын анхны эмчилгээ байна.

² Хүн амын фармакокинетик загварчлалын судалгаанд үндэслэсэн тунгийн хэмжээ юм.

³ Тухайн улсын бүртгэлд баталгаажснаар бүтээгдэхүүн нь 100/40 мг шахмал (FDC) болон 50/20 мг амаар үрэл эсвэл капсул хэлбэртэй.

Г.1.3 ХДХВ/ДОХ хавсарсан халдвар

Хялбаршуулсан горимоор эмчилгээ хийхийг нотолсон MINMON эмнэлзүйн судалгаа нь гепатитын С вирус ба ХДХВ-ийн хавсарсан халдвартай эмчилгээ хийлгэж байгаагүй хүмүүсийн дунд хийсэн судалгаа юм [23]. Хялбаршуулсан горимын дагуу (Зураг В.2) оношилгоо, эмчилгээ болон эмийн сонголт нь бусад өвчтөний адил генотип ба элэгний цирроз байгаа эсэхээс хамаарна.

Г.1.4 Гепатитын С вирусийн цочмог халдвар

Гепатитын С вирусийн цочмог халдвартын үед эдгэрэлтийг нь хүлээлгүйгээр вирусийн эсрэг эмчилгээ хийхийг зөвлөж байна. Цочмог халдвартын үед элэг гэмтээх эм бэлдмэл (ацетоаминофен), архи согтууруулах ундааг хэрэглэхгүй, бусдад халдвар дамжихаас сэргийлэхийг зөвлөнө.

Г.1.5 Жирэмсний үеийн гепатитын С вирусийн халдвар

Гепатитын С вирусийн халдвартай нехэн үржихүйн наслы эмэгтэйчүүдэд жирэмслэхийн өмнө эмчилгээнд хамрагдахыг зөвлөнө. Жирэмсний хяналтын үзлэгээр гепатитын вирусийн халдвартын илрүүлэгт хамрагдаж, anti-HCV илэрвэл HCV-RNA ачаалал тодорхойлох шинжилгээ хийж, халдвартай нь батлагдвал төрөлжсөн мэргэжлийн эмийн хяналтад орно. Цөөн жирэмсэн эхийг хамруулсан судалгаагаар эх урагт аюулгүй гэж мэдээлсэн ч [36, 37] том хүрээний судалгаа хийгдээгүй тул эмчилгээ хийхгүй (Хүснэгт Г.6).

Хүснэгт Г.6 Гепатитын С вирусийн халдвартай жирэмсэн эхийг хянах

ЗӨВЛӨМЖ	НОТОЛГОО
Жирэмсний хяналтад орох үед anti-HCV илэрсэн бол HCV-RNA болон элэгний үйл ажиллагааны шинжилгээ хийж, элэгний өвчний хүндрэл, эхээс хүүхдэд дамжих халдвартын эрсдэлийг үнэлнэ.	I, B
Гепатитын С вирусийн халдвартай эхийг жирэмсний хяналт, төрөх үед зохих дэмжлэг үзүүлнэ. Эхээс хүүхдэд дамжих халдвартын эрсдэлийг бууруулах нотлогдсон арга байхгүй.	I, B
Гепатитын С вирусийн халдвартай жирэмсэн эхэд шарлах, арьс загатнах зэрэг шинж тэмдэг, зовуурь илэрвэл жирэмсний үеийн элгэн дэх цэс зогсонгишил (intrahepatic cholestasis of pregnancy) сэжиглэж АЛАТ, АСАТ, цэсний хучил зэрэг шинжилгээ хийнэ.	I, B
Гепатитын С вирусийн халдвартай, элэгний циррозтой эхийг өндөр эрсдэлтэй жирэмслэлт гэж үзэж лавлагaa шатлалын төрөх, эмэгтэйчүүдийн эмийн хяналтад авна.	I, B
Гепатитын С вирусийн халдвартай жирэмсэн эх төрсний дараа хүүхдээ хөхөөр хооллож болох боловч хөхний толгой хагарсан үед хүүхдээ хөхөөр хооллохгүй байхыг зөвлөнө.	I, B

Гепатитын С вирусийн халдвартай жирэмсэн эхэд төрсний дараа HCV-RNA тодорхойлох шинжилгээ хийж, өөрөө аяндаа эдгэрсэн эсвэл эмчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлно.	I, B
------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------

Г.1.6 Гепатитын В вирусийн хавсарсан халдвэр

Гепатитын В вирусийн халдвартай хүнд HCV-RNA ачаалал тодорхойлогдохгүй байвал В вирусийн халдвартын үеийн оношилгоо, эмчилгээ, хяналтыг хийнэ. Харин HCV-RNA ачаалал тодорхойлогдсон бол ВЭШҮ эмийн эмчилгээг гепатитын В вирусийг дарангуйлах нуклеоз(т)идын аналог эмийг хавсран удирдамжийн дагуу эмчилнэ.

Г.1.7 Сүрьеэгийн хавсарсан халдвэр

Ханиалгах, жин буурах, халуурах, шөнө хөлрөх зэрэг шинж тэмдэг илэрвэл сүрьеэг сэжиглэн онош тодруулахаар төрөлжсөн мэргэжлийн эмчид илгээнэ.

ВЭШҮ эмүүд рифабутин, рифампин, рифапентин зэрэг сүрьеэгийн эсрэг эмтэй хамт хэрэглэхэд элгэнд явагдах эмийн хувиралд нөлөөлөх тул эдгээр эмийг хамт хэрэглэхгүй.

Г.1.8 Эрхтэн шилжүүлэн суулгах үеийн эмчилгээ

Элэг, бөөр шилжүүлэн суулгасны дараах гепатитын С вирусийн халдвартын эмчилгээний зөвлөмж нь MAGELLAN-2 болон бусад судалгааны үр дүнд суурилсан байна [38-40].

Хүснэгт Г.7 Эрхтэн шилжүүлэн суулгасны дараах гепатитын С вирусийн халдвартыг эмчлэх

Эмчилгээний дэглэм	Генотип	Ангилал	Үргэлж лэх хугацаа	Нотолгоо	Анхааруулга ба бусад анхаарах зүйлс
Элэг шилжүүлэн суулгасны дараа гепатитын С вирусийн халдвэр дахисан (элэгний циррозгүй)					
Глекапревир/ Пибрентасвир	1-6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, B	
Софосбувир/ Велпатасвир	1-6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, B	
Ледипасвир/ Софосбувир	1,4,5,6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, B	
Элэг шилжүүлэн суулгасны дараа гепатитын С вирусийн халдвэр дахисан (ээнэгшилтэй циррозтой)					
Софосбувир/ Велпатасвир	1-6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, B	
Глекапревир/ Пибрентасвир	1-6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, C	

Ледипасвир/ Софосбувир	1,4,5,6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, A	
Беэр шилжүүлэн суулгасны дараа гепатитын С вирусийн халдварт дахисан (элэгний циррозгүй болон ээнэгшилтэй циррозтой)					
Глекапревир/ Пибрентасвир	1-6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, A ^a IIa, C ^b	
Софосбувир/ Велпатасвир	1-6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	IIa, C	
Ледипасвир/ Софосбувир	1,4,5,6	1-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, A	
Элбасвир/ Гразопревир	1,4	2-р эгнээний сонголт	12 долоо хоног	I, B	Элбасвирийг NS5a RAS өөрчлөлтгүй өвчтөнд зөвлөнө

^a Нотолгооны ангиалал нь циррозгүй хүнд тулгуурласан

^b Нотолгооны ангиалал нь ээнэгшилтэй циррозтой хүнд тулгуурласан.

Эрхтэн шилжүүлэн суулгасан хүнд гепатитын С вирусийн эсрэг эмчилгээ хийхэд гол анхаарах зүйл нь кальцинеурины хориглогч болон ВЭШҮ эмийн харилцан үйлчлэл юм Хүснэгт Г.8.

Хүснэгт Г.8 Вирусийн эсрэг шууд үйлчилгээт эм ба кальцинеурин хориглогч эмүүдийн харилцан үйлчлэл

Эмийн нэр	Циклоспорин (CSA)	Такролимус (TAC)
Софосбувир	SOF AUC 4.5 дахин ↑, гэвч GS-331007 метаболит өөрчлөлтөд ордоггүй; эмийн тунг тусгайлан өөрчлөх шаардлагагүй	Харилцан үйлчлэл ажиглагдаагүй; эмийн тунг тусгайлан өөрчлөх шаардлагагүй
Ледипасвир	Судалгаа байхгүй; эмийн тунг тусгайлан өөрчлөх шаардлагагүй	Судалгаа байхгүй; эмийн тунг тусгайлан өөрчлөх шаардлагагүй
Велпатасвир	Харилцан үйлчлэл ажиглагдаагүй; эмийн тунг өөрчлөх шаардлагагүй	Судалгаа байхгүй; эмийн тунг тусгайлан өөрчлөх шаардлагагүй
Глекапревир/ Пибрентасвир	CSA өндөр тунтай (400mg) үед 5-fold ↑ in GLE AUC 5 дахин ↑; CSA тун өдөрт >100mg шаардлагатай үед уг хослолыг зөвлөхгүй.	TAC AUC 1.45 дахин ↑; эмийн тунг тусгайлан өөрчлөх шаардлагагүй; TAC түвшин хянах, шаардлагатай бол TAC түвшин титрлэх
Софосбувир/ велпатасвир/ воксилапревир	VOX AUC 9.4 дахин ↑; уг хослолыг хэрэглэхийг зөвлөхгүй.	Судалгаа байхгүй; эмийн тунг тусгайлан өөрчлөх шаардлагагүй
Элбасвир/ Гразопревир	GZR AUC 15 дахин ↑, EBR AUC 2 дахин ↑; уг хослолыг зөвлөхгүй.	TAC 43% ↑; эмийн тунг тусгайлан өөрчлөх шаардлагагүй

AUC, area under curve - муруйн доорх талбай

Г.1.8 Элэгний хорт хавдрын үеийн эмчилгээ

Гепатитын С вирусийн эмчилгээ хийж вирус устсан, элэгний циррозтой өвчтөн нь элэгний хорт хавдар үүсэх эрсдэлтэй тул хавдрын эрт илрүүлэгт хамруулж, б сар тутам хэвллийн хэт авиа болон AFP шинжилгээ хийнэ. ВЭШҮ эмийн эмчилгээний үр дүнгийн судалгаанд элэгний хавдрын эрсдэлийг бууруулж байгааг харуулж байна [40-47]. Иймээс ч олон улсын эмнэл зүйн зааварт гепатитын С халдвартай хүмүүсийг эмчилгээнд оруулахыг зөвлөж байна.

Элэгний хорт хавдар оношлогдсон хүмүүст ВЭШҮ эмийн эмчилгээ хийснээс болж элэгний хорт хавдар дахих эсвэл хүндэрч байгаа нь судалгаагаар нотлогдоогүй [48]. 2020 онд Америкийн элэг судлалын холбооноос хийсэн мета-анализаар ВЭШҮ эмчилгээ нь шинээр хавдар үүсэх эрсдэлийг бууруулсныг мэдээлжээ [49]. Эдгээр судалгааны үр дүнд үндэслэн элэгний хорт хавдрын эрт үед (BCLC A/B) оношлогдож, хавдрын эмчилгээнд орсон хүнд ВЭШҮ эмчилгээ санал болгох нь зүйтэй.

Элэгний хорт хавдар оношлогдсон хүнд ВЭШҮ эмийн эмчилгээ хийхдээ элэгний үйл ажиллагаа, элэгний цирроз зэргийг үнэлж бусад өвчтөний адил эмийн сонголт хийнэ. Элэг шилжүүлэн суулгахаар телөвлөж байгаа, элэгний хорт хавдар хожуу шатанд оношлогдсон өвөрмөц тохиолдлыг эмч нарын зөвөлгөөнөөр шийдвэрлэнэ.

Г.1.9 Бөөрний үйл ажиллагааны дутагдалтай үеийн эмчилгээ

Гепатитын С вирусийн архаг халдвэр нь бөөрний архаг эмгэг үүсгэх нэг эрсдэлт хүчин зүйл болдог [50]. Вирусийн халдвартыг эмчилснээр амьдрах хугацаа уртсах болон элэгнээс гаднах бусад шинж тэмдэг буурах зэрэг эмнэл зүйн ач холбогдолтой болохыг судалгааны үр дүн харуулжээ [51, 52]. Иймд бөөрний үйл ажиллагааны дутагдалтай гепатитын С вирусийн халдвартай өвчтөнг эмчилгээнд хамруулах нь чухал юм. Глекапревир, пибрентасвир, велпратасвир, воксилапревир зэрэг нь бөөрөөр гадагшилдаггүй. Софосбувир нь бөөрөөр гадагшилдаг боловч тунд өөрчлөлт хийх шаардлагагүй [53, 54]. Бөөрний үйл ажиллагааны дутагдалтай хүмүүст ВЭШҮ эмийн тунд ямар нэг өөрчлөлт хийхгүй. Харин рибавириин хавсарч хийх бол тунг багасгаж хэрэглэнэ.

Бөөрний өвчний төгсгөлийн шатны өвтөнүүдийн тусламж үйлчилгээнд дараах зүйлсийг анхаарна (Хүснэгт Г.9). Үүнд:

- Байнгын гемодиализ эмчилгээтэй үйлчлүүлэгчийг гепатитын С вирусийн халдвэр авахаас сэргийлэх, гепатитын В, D вирусийн халдвартыг илрүүлэх, халдвартгүй тохиолдолд гепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулах
- Анх удаа гемодиализ эмчилгээнд орох, нэг гемодиализийн төвөөс нөгөөд шилжих бүрт anti-HCV ба HCV-RNA-г тодорхойлох, вирусийн халдвэр илэрсэн тохиолдолд тухайн өвчтний хэрэглэх гемодиализийн аппаратыг тусгаарлах
- Бөөр шилжүүлэн суулгуулахаар хүлээж буй өвчтөнд anti-HCV илэрч, HCV-RNA ачаалал тодорхойлогдсон бол хагалгаанд орохын өмнө вирусийн эсрэг эмчилгээ, хяналтыг элэг шилжүүлэн суулгах багийн гепатолог эмч хийх
- Бөөр шилжүүлэн суулгасан өвчтөнд anti-HCV илэрч, HCV-RNA ачаалал тодорхойлогдсон бол вирусийн эсрэг эмчилгээ, хяналтыг элэг шилжүүлэн суулгах багийн гепатолог эмч хийнэ.

Хүснэгт Г.9 Бөөрний архаг эмгэгийн үеийн гепатитын С вирусийн тусламж үйлчилгээ

Зөвлөмж	Нотолгоо
Одоо хэрэглэгдэж буй пангенотип нөлөөт эмийн эмчилгээний үед эмийн тунд ямар нэг өөрчлөлт хийхгүй. ^b	I, A or IIa,B ^c

^a Бөөрний архаг өвчний үе шат: 1 = хэвийн (ТШХ>90мл/мин); 2 = хөнгөн (ТШХ 60-89 мл/мин); 3 = дунд (ТШХ 30-59 мл/мин); 4 = хүнд(ТШХ 15-29 мл/мин); 5 =бөөрний эмгэг төгсгөлийн шат (ТШХ<15 мл/мин)

^b Бөөрний архаг өвчний үе шат 3,4, 5 үед рибавирины тунг бууруулах шаардлагатай байж болно.

^c Нотолгооны түвшин бөөрний архаг өвчний үе шат 1,2,3 үед А; бөөрний архаг өвчний үе шат 4, 5 үед В

Бөөрний түүдгэнцрийн шүүлтийн хурдыг Cockcroft ба Gault-ийн доорх томъёогоор бодно:

$$\text{CreatClear} = \text{Sex} * ((140 - \text{Age}) / (\text{SerumCreat})) * (\text{Weight} / 72)$$

CCr (creatinine clearance) = mL/minute

Age = years

Weight = kg

SCr (serum creatinine) = mg/dL

Sex: Эр – 1, Эм – 0.85

https://www.kidney.org/professionals/KDOQI/gfr_calculatorCoc,

<https://www.mdcalc.com/creatinine-clearance-cockcroft-gault-equation> линк ашиглах

НОМ ЗҮЙ

1. World Health Organization. Hepatitis B and C burden in WHO regions-Renewed focus needed to address disparities in WHO regions [Internet]. Available from: <https://apps.who.int>.
2. World Health Organization. Global health sector strategies on, respectively, HIV, viral hepatitis and sexually transmitted infections for the period 2022-2030. 2022.
3. World Health Organization. Hepatitis B and C burden in WHO regions-Renewed focus needed to address disparities in WHO regions [Internet]. Available from: <https://apps.who.int>.
4. Dashtseren B, Bungert A, Bat-Ulzii P, et al. Endemic prevalence of hepatitis B and C in Mongolia: A nationwide survey amongst Mongolian adults. J Viral Hepat. 2017; 24(9).
5. Baatarkhuu O, Kim DY, Ahn SH, et al. Prevalence and genotype distribution of hepatitis C virus among apparently healthy individuals in Mongolia: A population-based nationwide study. Liver International. 2008; 28(10).
6. Rumgay H, Arnold M, Ferlay J, et al. Global burden of primary liver cancer in 2020 and predictions to 2040. J Hepatol. Elsevier B.V.; 2022; 77(6):1598–1606.
7. Center for Health Development of Mongolia. Health Indicators. Ulaanbaatar; 2021.
8. Martel C de, Maucort-Boulch D, Plummer M, Franceschi S. World-wide relative contribution of hepatitis B and C viruses in hepatocellular carcinoma. Hepatology. 2015; 62(4).
9. Монгол Улсын Засгийн Газар. Элэг Бүтэн Монгол Хөтөлбөр. Apr 12, 2017.
10. Үндэсний аудитын газар. Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлан. 2022 [cited 2023 Nov 16]; . Available from: <https://audit.mn/?p=16167>
11. Lingala S, Ghany MG. Natural History of Hepatitis C. Gastroenterol Clin North Am. 2015.

12. The natural history of hepatitis C virus (HCV) infection. *Int J Med Sci.* 2006
13. Westbrook RH, Dusheiko G. Natural history of hepatitis C. *J Hepatol.* 2014.
14. World Health Organization. New recommendation on hepatitis C virus testing and treatment for people at ongoing risk of infection Policy brief. 2023.
15. Lamoury FMJ, Soker A, Martinez D, et al. Hepatitis C virus core antigen: A simplified treatment monitoring tool, including for post-treatment relapse. *Journal of Clinical Virology.* 2017; 92.
16. Eid M, Melek S, Sharafeldin M, El-Shouny WA. Quantitative and Qualitative Evaluation of Hepatitis C Virus Core Antigen (HCVcAg) as an Alternative Diagnostic Marker in Chronic HCV Infection. *Delta Journal of Science.* 2023; 46(3).
17. Shilton S, Markby J, Japaridze M, et al. Feasibility and effectiveness of HCV viraemia testing at harm reduction sites in Georgia: A prospective three-arm study. *Liver International.* 2022; 42(4).
18. Kumbhar N, Ramachandran K, Kumar G, Rao Pasupuleti SS, Sharma MK, Gupta E. Utility of hepatitis C virus core antigen testing for diagnosis and treatment monitoring in HCV infection: A study from India. *Indian J Med Microbiol.* 2021; 39(4).
19. Wlassow M, Poiteau L, Roudot-Thoraval F, et al. The new Xpert HCV viral load real-time PCR assay accurately quantifies hepatitis C virus RNA in serum and whole-blood specimens. *Journal of Clinical Virology.* 2019; 117.
20. Choi GH, Jang ES, Kim YS, et al. Hepatocellular carcinoma, decompensation, and mortality based on hepatitis C treatment: A prospective cohort study. *World J Gastroenterol.* 2022; 28(30).
21. Tran L, Jung J, Carlin C, Lee S, Zhao C, Feldman R. Use of Direct-Acting Antiviral Agents and Survival among Medicare Beneficiaries with Dementia and Chronic Hepatitis C. *Journal of Alzheimer's Disease.* 2021; 79(1).
22. Kalidindi Y, Jung J, Feldman R, Riley T. Association of Direct-Acting Antiviral Treatment With Mortality Among Medicare Beneficiaries With Hepatitis C. *JAMA Netw Open.* 2020; 3(7).
23. Solomon SS, Wagner-Cardoso S, Smeaton LM, et al. A simple and safe approach to HCV treatment: Findings from the a5360 (MINMON) trial. *Top Antivir Med.* 2021; 29(1).
24. Brown RS, Buti M, Rodrigues L, et al. Glecaprevir/pibrentasvir for 8weeks in treatment- naïve patients with chronic HCV genotypes 1–6 and compensated cirrhosis: The EXPEDITION-8 trial. *J Hepatol.* 2020; 72(3).
25. Jacobson IM, Lawitz E, Gane EJ, et al. Efficacy of 8 Weeks of Sofosbuvir, Velpatasvir, and Voxilaprevir in Patients With Chronic HCV Infection: 2 Phase 3 Randomized Trials. *Gastroenterology.* 2017; 153(1).
26. Bourlière M, Gordon SC, Schiff ER, et al. Deferred treatment with sofosbuvir– velpatasvir– voxilaprevir for patients with chronic hepatitis C virus who were previously treated with an NS5A inhibitor: an open-label substudy of POLARIS-1. *Lancet Gastroenterol Hepatol.* 2018; 3(8).
27. Bourlière M, Gordon SC, Flamm SL, et al. Sofosbuvir, Velpatasvir, and Voxilaprevir for Previously Treated HCV Infection. *New England Journal of Medicine.* 2017; 376(22).
28. Wyles DL, Weiland O, Yao B, et al. Retreatment of hepatitis C infection in patients

- who failed glecaprevir/pibrentasvir. *Top Antivir Med.* 2018; 26.
29. Mason K, Dodd Z, Guyton M, et al. Understanding real-world adherence in the directly acting antiviral era: A prospective evaluation of adherence among people with a history of drug use at a community-based program in Toronto, Canada. *International Journal of Drug Policy.* 2017; 47.
30. Serper M, Evon DM, Stewart PW, et al. Medication Non-adherence in a Prospective, Multi-center Cohort Treated with Hepatitis C Direct-Acting Antivirals. *J Gen Intern Med.* 2020; 35(4).
31. Schmelzer J, Dugan E, Blach S, et al. Global prevalence of hepatitis C virus in children in 2018: a modelling study. *Lancet Gastroenterol Hepatol.* 2020; 5(4).
32. Sokal E, Schwarz KB, Rosenthal P, et al. Safety and efficacy of sofosbuvir/velpatasvir for the treatment of chronic hepatitis C infection in adolescents and children aged 3 to 17 years old through 24 weeks post-treatment. *Hepatology.* 2020; 72(1 SUPPL).
33. Nicastro E, Norsa L, Giorgio A Di, Indolfi G, D'Antiga L. Breakthroughs and challenges in the management of pediatric viral hepatitis. *World J Gastroenterol.* 2021.
34. Malik F, Bailey H, Chan P, et al. Where are the children in national hepatitis C policies? A global review of national strategic plans and guidelines. *JHEP Reports.* 2021; 3(2).
35. Ventslovayte ND, Goriacheva LG, Greshnyakova VA, Efremova NA, Shilova I V. HCV treatment experience in children over 12 years old with a combined direct acting antiviral containing glecaprevir and pibrentasvir. *Infectious Diseases: News, Opinions, Training.* 2021; 10(3).
36. Yattoo GN. Treatment of chronic hepatitis C with ledipasvir/sofosbuvir combination during pregnancy. *Hepatol Int.* 2018; 12 (2).
37. Chappell CA, Scarsi KK, Kirby BJ, et al. Ledipasvir plus sofosbuvir in pregnant women with hepatitis C virus infection: a phase 1 pharmacokinetic study. *Lancet Microbe.* 2020; 1(5).
38. Reau N, Kwo PY, Rhee S, et al. Glecaprevir/Pibrentasvir Treatment in Liver or Kidney Transplant Patients With Hepatitis C Virus Infection. *Hepatology.* 2018; 68(4).
39. Ajlan A, Al-Jedai A, Elsiesy H, et al. Sofosbuvir-based therapy for genotype 4 HCV recurrence post-liver transplant treatment-experienced patients. *Can J Gastroenterol Hepatol.* 2016; 2016.
40. Woolley AE, Singh SK, Goldberg HJ, et al. Heart and Lung Transplants from HCV-Infected Donors to Uninfected Recipients. *New England Journal of Medicine.* 2019; 380(17).
41. Veldt BJ, Heathcote EJ, Wedemeyer H, et al. Sustained virologic response and clinical outcomes in patients with chronic hepatitis C and advanced fibrosis. *Ann Intern Med.* 2007; 147(10).
42. George SL, Bacon BR, Brunt EM, Mihindukulasuriya KL, Hoffman J, Bisceglie AM Di. Clinical, virologic, histologic, and biochemical outcomes after successful HCV therapy: A 5- year follow-up of 150 patients. *Hepatology.* 2009; 49(3).
43. Morgan RL, Baack B, Smith BD, Yartel A, Pitasi M, Falck-Ytter Y. Eradication of hepatitis C virus infection and the development of hepatocellular carcinoma: A meta-analysis of observational studies. *Ann Intern Med.* 2013.
44. Kanwal F, Kramer J, Asch SM, Chayanupatkul M, Cao Y, El-Serag HB. Risk of

- Hepatocellular Cancer in HCV Patients Treated With Direct-Acting Antiviral Agents. *Gastroenterology*. 2017; 153(4).
45. Li DK, Ren Y, Fierer DS, et al. The short-term incidence of hepatocellular carcinoma is not increased after hepatitis C treatment with direct-acting antivirals: An ERCHIVES study. *Hepatology*. 2018; 67(6).
 46. Ioannou GN, Green PK, Beste LA, Mun EJ, Kerr KF, Berry K. Development of models estimating the risk of hepatocellular carcinoma after antiviral treatment for hepatitis C. *J Hepatol*. 2018; 69(5).
 47. Kanwal F, Kramer JR, Asch SM, Cao Y, Li L, El-Serag HB. Long-Term Risk of Hepatocellular Carcinoma in HCV Patients Treated With Direct Acting Antiviral Agents. *Hepatology*. 2020; 71(1).
 48. Singal AG, Rich NE, Mehta N, et al. Direct-Acting Antiviral Therapy for Hepatitis C Virus Infection Is Associated With Increased Survival in Patients With a History of Hepatocellular Carcinoma. *Gastroenterology*. 2019; 157(5).
 49. He S, Lockart I, Alavi M, Danta M, Hajarizadeh B, Dore GJ. Systematic review with meta-analysis: effectiveness of direct-acting antiviral treatment for hepatitis C in patients with hepatocellular carcinoma. *Aliment Pharmacol Ther*. 2020.
 50. Fabrizi F, Verdesca S, Messa P, Martin P. Hepatitis C Virus Infection Increases the Risk of Developing Chronic Kidney Disease: A Systematic Review and Meta-Analysis. *Dig Dis Sci*. 2015; 60(12).
 51. Park H, Chen C, Wang W, Henry L, Cook RL, Nelson DR. Chronic hepatitis C virus (HCV) increases the risk of chronic kidney disease (CKD) while effective HCV treatment decreases the incidence of CKD. *Hepatology*. 2018; 67(2).
 52. Söderholm J, Millbourn C, Büsch K, et al. Higher risk of renal disease in chronic hepatitis C patients: Antiviral therapy survival benefit in patients on hemodialysis. *J Hepatol*. 2018; 68(5).
 53. Desnoyer A, Pospai D, Lê MP, et al. Pharmacokinetics, safety and efficacy of a full dose sofosbuvir-based regimen given daily in hemodialysis patients with chronic hepatitis C. *J Hepatol*. 2016; 65(1).
 54. Liu CH, Chen CY, Su WW, et al. Sofosbuvir/velpatasvir with or without low-dose ribavirin for patients with chronic hepatitis C virus infection and severe renal impairment. *Gut*. 2020.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АЛАТ Аланинаминотрансфераз

ACAT Аспартатаминотрансфераз

АФП Альфа-фетопротейн

ВЭШҮ Вирусийн эсрэг шууд үйлчилгээт

ГГТП Гаммаглутаминтранспептидаз

ДЭМБ Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

КТ Компьютер томографийн шинжилгээ

ПГУ Полимеразын гинжин урвал

РВЭ Ретровирусийн эсрэг

РНХ Рибонуклейн хүчил

ФХЭБҮ Фермент холбоот эсрэгбиийн урвал

ХДХВ/ДОХ Хүний дархлал хомсдлын вирус/ дархлалын дутагдлын олдмол хамшинж

ЦЕШ Цусны ерөнхий шинжилгээ

ЭМЯ Эрүүл мэндийн яам

anti-HCV Hepatitis C virus antibody

APRI AST-to-platelet ratio index

HCV-RNA Hepatitis C virus ribonucleic acid

INR International normalised ratio

IU/ml International unit/milliliter

NS3/NS4A Non-structural protein 3/non-structural protein 4A

NS5B Non-structural protein 5B (of HCV)

ГЕПАТИТЫН D ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ЭМНЭЛ ЗҮЙН ЗААВАР

A. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

A.1 Онош, Өвчний олон улсын 10 дугаар ангилал (ICD-10)

B16.0	Элэгний комоор хүндэрсэн, В ба Дельта хавсарсан цочмог гепатит Acute hepatitis B with delta -agent, with hepatic coma
B16.1	Элэгний комгүй, В ба Дельта хавсарсан цочмог гепатит Acute hepatitis B with delta -agent, without hepatic coma
B16.2	Элэгний комоор хүндэрсэн, Дельта үүсгэгчгүй, В вирусийн цочмог гепатит Acute hepatitis B without delta -agent, with hepatic coma
B17.0	В гепатитын вирус тээгч цочмог Дельта халдвэр авсан Acute delta - (super) infection of hepatitis B carrier
B18.0	Дельта вирус хавсарсан архаг В вируст гепатит Chronic viral hepatitis B with delta-agent

Тайлбар: Гепатитын D вирусийн халдвартын шалтгаант элэгний цирроз, элэгний хорт хавдар үүссэн бол Өвчний олон улсын 10 дугаар ангиллын дагуу үндсэн оношийг тавьж, бусад хавсарсан шалтгааны оношийг тусгана. Жишээ нь:
K74.6 Элэгний фиброз ба цирроз, B18.0 Дельта вирус хавсарсан архаг В вируст гепатит

C22.0 Элэгний эст карцином, B18.0 Дельта вирус хавсарсан архаг В вируст гепатит

A.2 Зааврын хэрэглэгчид

Эрүүл мэндийн байгууллагын шийдвэр гаргагч, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий эмч, мэргэжилтэн

A.3 Зорилго, зорилт

Гепатитын D вирусийн халдвартыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, хянах талаар үр дүнтэй нотолгоонд сууринласан заавар зөвлөмжээр хангах, өвчтөнд үзүүлэх тусlamж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад чиглэнэ.

A.4 Ашигласан нэр томъёо, тодорхойлолт

Гепатитын вирусийн халдвартын эрт илрүүлэг (Viral hepatitis screening)	Насанд хүрсэн болон халдварт өртөх эрсдэлтэй хүн амын бүлэгт гепатитын вирусийн халдвартыг эрт илрүүлэх зорилгоор хийх ийлдэс судлалын шинжилгээ
Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг (Liver cancer screening)	Эрсдэлтэй хүн амын бүлэгт элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх зорилгоор хийх багц шинжилгээ

ГВВ ба Гепатитын D вирусийнхавсарсан халдварыг илрүүлэх рефлекс шинжилгээ	Гепатитын В вирусийн халдварыг илрүүлэх шинжилгээнд HBsAg эерэг илэрсэн хүнд нэн даруй гепатитын D вирусийн хавсарсан халдварыг илрүүлэх шинжилгээ
Anti-HDV	Гепатитын D вирусийн эсрэг бие илрэх нь гепатитын D вирусийн халдвартайг илтгэнэ
HDV-RNA тодорхойлох	Гепатитын D вирусийн үржлийг илтгэнэ Вирусийн ачааллын хэмжээгээр вирусийн эмчилгээний үр дүнг хянана
ГВВ ба Гепатитын D вирусийнхам-халдвар (ко халдвар)	Гепатитын В вирусийн халдвартайг хүнд гепатитын В ба D вирусийн халдвар нэгэн зэрэг илрэх
ГВВ ба Гепатитын D вирусийндавхар халдвар (супер халдвар)	Гепатитын В вирусийн халдвартай өвчтөнд гепатитын D вирусийн цочмог халдвар илрэх
Вирусийн тогтвортой хариу урвал (Sustained virological response)	Эмчилгээ дууссанаас хойш зургаан сарын дараа HBV-DNA , HDV-RNA илрэхгүй байх

A.5 Тархвар зүй

Хүнээс хүнд парентераль замаар халдварладаг гепатитын D вирус (ГДВ)-ээр үүсгэгддэг элгийг сонгомлоор гэмтээн элэгний хатуурал, ээнэгшил алдагдал, элэгний хорт хавдар үүсгэдэг архаг явцтай халдварт өвчин. Гепатитын D вирус нь рибонуклэйн хүчил (РНХ) агуулсан вирион ба дангаараа элэгний эсэд нэвтэрч халдварлуулах чадваргүй, зөвхөн Гепатитын В вирусийн гадаргуугийн уураг (HBsAg)-ийн тусламжтайгаар элэгний эсэд нэвтэрч транскрипц болдог мутацтай вирус юм.

ДЭМБ-ийн мэдээгээр дэлхийн дээр 296 сая хүн гепатитын В вирусийн архаг халдвартай амьдарч байна (1). 2019 оны байдлаар дэлхийн хүн амын HBsAg эерэг хүн амын 14.57% буюу нийт 74 сая хүн гепатитын D вирусийн халдвартай гэж таамаглаж байна (2). Гепатитын D вирусийн 1 генотип зонхилох бөгөөд Хойд Америк, Европ, Номхон далайн өмнөд бүс нутаг, ойрхи Дорнодод тархжээ (3). Гепатитын В вирусийн халдвар бага тархсан бүс нутагт цустай байнга харьцааг хүмүүс, гемофилитэй өвчтөн, судсаар хар тамхи хэрэглэгчид, эрэгтэйчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрэгтэйчүүдийн дунд илүүтэй тохиолддог (4).

Монгол улсад хийсэн 2018 оны 10-65 насны 10040 хүнийг хамруулсан судалгаанд оролцогчдын 8.1%-д гепатитын В вирусийн халдвар илэрсэн (5). Манай улсад гепатитын D вирусийн халдвар өргөн тархсан цөөн улс орны нэг бөгөөд, HBsAg эерэг хүмүүсийн 60-65%-д anti-HDV эерэг оношлогдож байна (6-7). Хүн амын дунд гепатитын D вирусийн 1-р генотип зонхилдог (7-9). Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 15-аас дээш насны хүн амыг гепатитын вирусийн халдварын эрт илрүүлэгт анх удаа хамруулсан. Эрт илрүүлэгт хамрагдаж HBsAg эерэг гарсан 89734 хүний HBV-DNA вирусийн ачаалал болон гепатитын D вирусийн халдвар тодорхойлох шинжилгээнд хамруулах шаардлагатай байна.

A.6 Үндсэн ойлголт

Гепатитын В вирусийн халдвар илэрсэн хүнд вирусийн үржил, элэгний үйл ажиллагааг үнэлэн харьяа нутаг дэвсгэрт нь нэн даруй эмчилгээнд хамруулах эсвэл хяналтанд оруулах тусlamж үйлчилгээг хялбаршуулан хүргэх зөвлөмжийг ДЭМБ-аас гаргажээ. Хавсарсан өвчлөлтэй, ээнэгшилээ алдсан циррозтой, 2-оос дээш насын хүүхдийг лавлагаа шатны эмнэлэгт төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтанд эмчилгээг эхлүүлнэ. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эмэгтэйд эхээс хүүхдэд халдвар дамжихыг таслан зогсоох тусlamж үйлчилгээг үзүүлнэ.

Гепатитын В ба D вирусийн халдварын үед тусlamж үйлчилгээг өвчтөнд ойртуулах, шуурхай болгох зорилгоор хялбаршуулсан горимыг танилцуулж байна. Эрт илрүүлгээр HBsAg зэрэг илэрсэн тохиолдолд вирусийн ачаалал (HBV-DNA) болон гепатитын D вирусийн халдварыг тодорхойлох “рефлекс” шинжилгээг хийж, эмчилгээнд хамруулах, хянах шаардлагатай (Зураг Б.1).

A.7 Эрүүл мэндийн боловсрол

Гепатитын В ба D вирусийн халдвар нь цусаар дамжих ба эрт оношилж, эмчлүүлэхийн ач холбогдлыг ойлгуулах нь чухал юм. Гепатитын В ба D вирусийн халдвар авсан хүн эрт илрүүлэгт хамрагдаж, эрт оношилж, эмчилж, хянаснаар элэгний цирроз, элэгний хорт хавдар түүний хүндрэлээс сэргийлэх талаар тайлбарлана. Элэгний циррозтой бол нас харгалзахгүй гепатитын В вирусийн эсрэг эмчилгээг эхлэх, вирусийн эсрэг эм ууснаар циррозын хүндрэлээс сэргийлэх ба элэгний циррозын хяналт болон элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт (хэвлийн хэт авиа, AFP) 3 сар тутамд хамрагдаж эмчийн байнгын хяналтанд байх шаардлагатайг зөвлөнө. Бүх хүмүүст амьдралын эрүүл хэв маягийг мөрдөх талаар эрүүл мэндийн боловсрол олгох зөвлөгөөг өгнө.

Б. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ

Б.1 Эрт илрүүлэг

ДЭМБ-аас зөвлөсөн түргэвчилсэн оношлуураар гепатитын В вирусийн халдвар илрүүлэх шинжилгээг хийнэ. Шинжилгээний хариу зэрэг буюу HBsAg илэрсэн тохиолдолд рефлекс шинжилгээ хийх буюу тэр даруй anti-HDV, HBV-DNA тодорхойлох шинжилгээ хийнэ.

Эрсдэлд суурилсан илрүүлэг

Гепатитын вирусийн халдварт өртөх эрсдэлтэй бүлгийн хүн амд халдвар илрүүлэх шинжилгээг хийнэ. Үүнд:

- Эрхэлсэн ажил мэргэжлээс хамаарах эрсдэлтэй бүлэг
- Эүүл мэндийн байдлаас хамаарах эрсдэлтэй бүлэг
- Амьдралын хэв маяг, бэлгийн зан үйлээс хамаарах эрсдэлт бүлэг

Хүн амд суурилсан илрүүлэг (universal)

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2017–2020 онд 15-аас дээш насын иргэдийг гепатитын вирусийн халдварын эрт илрүүлэгт хамруулсан. 2022 оны 5 сараас эхэлсэн хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн хийж буй эрт илрүүлгийн хүрээнд 18-аас дээш насын хүмүүст гепатитын C ба В вирусийн халдварыг илрүүлэх шинжилгээг хийж байна.

Жирэмсэн эхийн илрүүлэг

Жирэмсэн эмэгтэй бүрт гепатитын C ба В вирусийн халдвар илрүүлэх шинжилгээг (anti-HCV, HBsAg) хийнэ. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхээс хүүхдэд халдвар дамжихыг таслан зогсоох тусlamж үйлчилгээг үзүүлж, хүүхдэд гепатитын В вирусийн эсрэг дархлаа тогтоцыг шалгана.


Б.2 Халдварыг илрүүлэх, ачаалал тодорхойлох шинжилгээ

Гепатитын вирусийн илрүүлэг ба вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээг Эрүүл мэндийн сайдын “Заавар, техникийн тодорхойлолт батлах тухай” тушаалын дагуу хийж гүйцэтгэнэ.

Гепатитын В вирусийн халдварт өртсөн эсэхийг илрүүлэхийн тулд HBsAg тодорхойлох шинжилгээ хийнэ.

HBsAg зөвхөн илэрсэн хүмүүст anti-HDV, HBV-DNA, HDV-RNA тодорхойлж хавсарсан халдварыг оношилно (Зураг Б.1).

Эмнэл зүйн шийдвэр гаргаж, эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх зорилгоор шинжилгээнд сорьц авч, рефлекс шинжилгээний зарчмыг баримтлан хариуг өвчтөнд эсвэл асран хамгаалагчид даруй өгнө. Рефлекс шинжилгээг лабораторит ба эмнэлэгт сууринсан хоёр аргаар хийнэ.



Зураг Б.1 Гепатитын В ба D вирусийн халдварын эрт илрүүлэг

Лабораторит сууринсан рефлекс шинжилгээ нь өвчтөнд эмчийн үзлэг хийж, HBsAg илрүүлэх шинжилгээ (зарим тохиолдолд хоёр хуруу шилэнд цус авж болно) хийж, зөвхөн одоо байгаа эсвэл давхар авсан сорьцыг лабораторит илгээж, HBV-DNA тодорхойлох, anti-HDV илрүүлэх “рефлекс” шинжилгээг хийж, өвчтөн ба эмчид шинжилгээний хариуг хүргүүлнэ. Өвчтөн дахин ирэх, өвчтнөөс дахин сорьц цуглуулах шаардлагагүй.

Эмнэлэгт сууринсан рефлекс шинжилгээ нь зөвхөн анх удаа эмнэлэгт ирэхэд HBsAg илрүүлэх шинжилгээг түргэвчилсэн аргаар хийж ба хоёр удаа цус авах стратегийг хэлнэ. Хэрэв зөвхөн одоо байгаа эсвэл давхар авсан сорьцыг лабораторит илгээж, HBV-DNA тодорхойлох, anti-HDV илрүүлэх шинжилгээнд зориулан (ихэвчлэн 15 минут хүлээсний дараа) тэр даруй хоёр дахь сорьцийг авч HBV-DNA, HDV IgM, HDV IgG, HDV-RNA үзэхээр лабораторид илгээнэ.

В. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ

В.1 Эмнэл зүйн явц

Гепатитын В ба D вирусийн халдвар нь илүү хүнд, давшингүй явцтайгаар элэгний циррозд шилжиж, элэгний дутагдал, нас баралтад хүргэдэг (10). Элэгний циррозд шилжих хугацаа дунджаар 5-10 жил үргэлжилдэг бөгөөд нийт Гепатитын D вирусийн халдвартай хүмүүсийн 60-70 хувьд элэгний цирроз үүсдэг байна. Гепатитын D вирусийн халдварын нас баралт 2-20% буюу гепатитын B вирусийн халдвараас 10 дахин өндөр байна (11). Испанид хийсэн судалгаагаар гепатитын D вирусийн халдвартай 158 хүнийг 13 жил дагаж судлахад 18%-д нь элэгний ээнэгшил алдагдаж, 3 хүнд элэгний хорт хавдар үүссэн (12) бол Тайваны судалгаагаар дунджаар 11 жилийн 52%-д ээнэгшил алдагдсан элэгний өвчин, түүнээс шалтгаалсан нас баралт бүртгэгдсэн (13).

Халдвар авсан байдлаар нь:

- Гепатитын B ба D вирусийн хам халдвар
- Гепатитын B ба D вирусийн давхар халдвар гэж ангилна.

Гепатитын B ба D вирусийн хам халдвар

Өмнө нь халдвар авч байгаагүй хүний биед гепатитын B ба D вирус зэрэг халдварласнаас үүсэх ба хам халдвар авсан тохиолдолд 95%-д гепатитын B вирусийн цочмог халдвартай адил бүрэн эдгэрдэг. Эмнэл зүй нь хөнгөнөөс нэн хүнд хэлбэрээр явагдаж 1% нь элэгний цочмог дутагдлаар хүндэрч, 5% нь архаг халдварт шилждэг. Эмнэл зүйн илрэл нь гепатитын D вирусийн генотип, халдвар авсан хүний дархлалын хариу урвалын байдал, гепатитын B вирусийн генотип, репликац зэргээс хамаардаг.


Хам халдвар нь гепатитын B вирус ба бусад вирусийн цочмог халдвараас эмнэл зүй, гистологийн хувьд ялгаагүй. Хам халдварын үед өвчин архагшиж болох ч төгсгөлийн үедээ ихэнх тохиолдолд гепатитын B вирусийн репликаци зогсож эдгэрдэг.

Гепатитын D вирусийн давхар (супер) халдвар

Гепатитын B вирусийн архаг халдвартай өвчтөнд гепатитын D вирус нэмж халдварлахыг хэлнэ. Энэ халдварын 5% нь элэгний дутагдал, 80–90% нь элэгний архаг үрэвсэлд шилжиж улмаар богино хугацаанд элэгний цирроз, элэгний хорт хавдарт шилждэг. Эмнэл зүйн шинж тэмдэг нь ихэвчлэн хүнд хэлбэрээр явагдаж ерөнхий хордлого, шарлалт, цусархаг хам шинж тод ажиглагдана.

B.2 Ерөнхий ба бодит үзлэг, багажийн шинжилгээ

Гепатитын B ба D вирусийн халдвартай өвчтөнд вирусийн эсрэг эмчилгээг эхлэхийн өмнө вирусийн ачааллыг тодорхойлж, элэгний фиброз/циррозыг үнэлж, элэгний үйл ажиллагаа, цусны дэлгэрэнгүй шинжилгээ, бөөрний үйл ажиллагаа, хавсарсан өвчин болон эмийн хэрэглээг үнэлнэ (Зураг B.2).



Зураг В.2 Гепатитын В ба D вирусийн халдвартын оношилгоо, эмчилгээний хяналт

Тайлбар: Вирусийн ачаалал Log2-оор буурах нь 100 дахин буурах буюу жишээ нь өвчтөний HDV-RNA эмчилгээний өмнө 5.000.000 IU/ml байсан бол эмчилгээний явцад 50.000 IU/ml эсвэл түүнээс бага болохыг Log2 болон түүнээс ихээр буурсан гэж хэлнэ.

Хүснэгт В.1. Гепатитын D вирусийн ийлдэс судлалын үзүүлэлтүүдийн тайлбар

HBsAg	ГВВ-ийн халдвартайг илэрхийлэх анхдагч үзүүлэлт бөгөөд цочмог ба архаг халдвартын аль алинд цусанд илэрдэг. 6 сараас дээш хугацаанд цусанд илэрсэн үед ГВВ-ийн архаг халдварт гэж үзнэ. Зарим тохиолдолд HBsAg цусанд илрэхгүй боловч HBV-DNA илрэх нь далд халдвартыг илэрхийлнэ.
HBsAg quantitative	ГВВ-ийн гадаргуугийн эсрэгтерэгчийг тоон аргаар илэрхийлэх шинжилгээ өвчний тавиланг тодорхойлох, эмчилгээний үр дүнг хянана. qHBsAg түвшин буурах нь эмчилгээний үр дүнг илэрхийлнэ.
Anti-HDV	Гепатитын D вирусийн эсрэгбие ба IgM ба IgG гэсэн 2 терэлтэй.
Anti-HDV IgM	Цочмог халдвартын үед зөвөг байдаг ч архаг халдвартай ихэнх өвчтөнд илэрнэ. Гепатитын D вирусийн репликацийг тодорхойлох орлуулагч маркер болгон хэрэглэж болно. Гэвч өвөрмөц, мэдрэг чанар өндөр биш.
Anti-HDV IgG	Гепатитын D вирусийн халдварт өртсөн хүн болгонд зөвөг гарна. Гепатитын D вирус идэвхжилгүй үед ч зөвөг гарч болно.
HDV-RNA	Вирусийн идэвхитэй үржлийг харуулдаг. anti-HDV зөвөг өвчтөнд үзнэ. Архаг халдвартай хүмүүст тоологдох ба өөрөө аяндаа эсвэл эмчилгээний дунд вирус идэвхжилгүй үед сөрөг гарна. Гепатитын D вирусийн эсрэг эмчилгээ хийж буй үед эмчилгээний үр дүнг хянахын тулд HDV-RNA шинжилгээг 3–6 сар тутамд хийж байх шаардлагатай.

В.2.2 Элэгний фиброз, циррозыг үнэлэх

Гепатитын В вирусийн эсрэг эмчилгээг эхлүүлэхийн өмнө элэгний фиброзыг үнэлэх ба энэ нь эмчилгээний горим, эмчилгээний хугацааг сонгоход дөхөм болно. Элэгний фиброзыг үнэлэх хатгалтын ба хатгалтын бус аргууд байдаг.

Элэгний фиброз үнэлэх хатгалтын арга: Элэгний эдийн шинжилгээ (элэгний биопси) нь элэгний фиброз, цирроз оношлох алтан стандарт арга. Шалтгаан тодорхойгүй элэгний үйл ажиллагааны өөрчлөлт илрэх, аутоиммун гепатит, цирроз, элэгний хорт хавдрын сэжигтэй үед хийнэ.

Элэгний фиброзын зэргийг үнэлэх хатгалтын бус арга: APRI оноо (<https://www.mdcalc.com/calc/3094/ast-platelet-ratio-index-apri>), FIB-4 оноо (<https://www.mdcalc.com/calc/2200/fibrosis-4-fib-4-index-liver-fibrosis>) тооцох аргаар дунд зэргийн сорвижлыг METAVIR-ийн үнэлгээгээр F2-F3 (Хүснэгт В.2) тогтоох боломжгүй боловч эдгээр аргууд нь хямд, хэрэглэхэд хялбар тул эмчилгээний загварыг сонгоход тустай. Ялган оношлох шаардлагатай тохиолдолд элэгний фиброзийг тодорхойлох хатгалтын ба хатгалтын бусад аргыг хэрэглэнэ.

Орчин үед элэгний биопсийн шинжилгээний хүндрэл (өвдөлт, цус алдах гэх мэт), олон дахин хийх боломжгүй зэргээс шалтгаалан хатгалтын бус аргаар элэгний фиброзыг тодорхойлох шинжилгээг эмнэл зүйд өргөнөөр ашиглаж байна.

Фиброскан, транзит эластографи нь оношилгооны нарийвчлал сайтай давтан шинжлэхэд аюулгүй зэрэг давуу талтай, элэгний фиброзыг үнэлэх инвазив бус аргын төлөөлөл юм. Өвчтөнд 10 удаагийн амжилттай хэмжилт хийн дундаж утгаар хариу гарна. Даамжирсан фиброзын босго утга 7.5 кПа байна.

Хүснэгт В.2. Элэгний фиброзыг тодорхойлох METAVIR үнэлгээний систем

METAVI R үнэлгээ	F0	F1	F2	F3	F4
	Фиброзгүй	Бага фиброз	Дунд фиброз	Илт фиброз	Элэгний цирроз

В.2.3 Элэгний эмгэг ба хүндрэл оношлох, үнэлэх стандарт шинжилгээ

Лабораторийн шинжилгээ: ЦЕШ, элэгний үйл ажиллагаа (ACAT, АЛАТ, ГГТП, нийт ба шууд билирубин, шүлтлэг фосфотаза, альбумин, уураг), INR, бөөрний үйл ажиллагаа (креатинин), сахар, холестерин, триглицерид, их нягтралт, бага нягтралт липопротейд, бамбайн даавар (TSH, T3, T4), натри, элэгний хавдрын маркер (AFP, боломжтой бол PIVKA II)

Элэг гэмтээг бусад шалтгааныг ялгах шаардлагатай үед: Халдвэр (ХДХВ/ДОХ, гепатитын бусад вирусийн халдвэр), элэгний аутоиммуны маркер

Дүрс оношилгооны аргууд: Хэвлэлийн хэт авиан шинжилгээ, шаардлагатай тохиолдолд хэвлэлийн тодосгогчтой КТ, соронзон резонанс тогтолцоогоо MRI шинжилгээг хийнэ.

Улаан хоолой, ходоодны уян дуран: улаан хоолой, ходоодны варикоз үнэлэх

В.2.4 Хавсарсан өвчин ба эмийн харилцан үйлчлэл үнэлэх

Вирусийн эмийн харилцан үйлчлэлийг эм жор бичих эсвэл хяналтын үзлэг бүрт дахин (<https://uptodate.druginteractions.org/>; <https://www.hep-druginteractions.org/>) хэрэглэж байгаа эмийг асууж тодруулан шалгахыг зөвлөж байна.

В.2.5 Архины хэрэглээг тодорхойлох, зөвлөгөө өгөх

Гепатитын В вирусийн халдвартай хүн бүрт архины хэрэглээг үнэлж, дунд ба өндөр хэрэглээтий бол зан үйлийг бууруулах арга хэмжээг эхлэх хэрэгтэй.

Архи, тамхи, мансууруулах сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ, эрсдэлийг эрт илрүүлэхэд ASSIST (Alcohol, Smoking, Substance Involvement Screening Test) сорилыг ашиглана. ASSIST нь сэтгэц нөлөөт зан үйлийг илрүүлэхэд чиглэсэн ДЭМБ-ын зөвлөмж бөгөөд эрүүл мэндийн анхан шатны байгууллагад түгээмэл хэрэглэдэг сорил юм.

ASSIST сорил нь дараах 3 хэсгээс бүрддэг.

- ASSIST эрт илрүүлгийн асуумж
- ASSIST сууриссан эрсдэлт зан үйлийг залруулах зөвлөмж
- Өөрөө өөрийгөө үнэлж, эрсдэлт зан үйлээс татгалзах, өөрийгөө өөрчлөх зөвлөмж

ASSIST зөвлөмж нь 5-10 минут орчим стандарт ярилцлага хийж, эрсдэлт оноог үнэлэн, тусlamж үзүүлэх түвшинг тодорхойлдог. Дараах 3 түвшний эрсдлийг илрүүлнэ. Үүнд:

- Бага эрсдэлтэй: тусlamж, зөвлөгөө шаардлагагүй
- Дунд эрсдэлтэй: энгийн тусlamж хэрэгтэй
- Өндөр эрсдэлтэй: зан үйлийг үнэлэх, эмчлэх мэргэжилтэн шаардлагатай.

B.3. Вирусийн эсрэг эмчилгээ

Гепатитын В ба D вирусийн халдвартай бүх өвчтөнд вирусийн эсрэг эмчилгээг зөвлөнө. Ээнэгшил алдагдсан циррозтой өвтөнүүдэд элэг шилжүүлэн суулгах боломжтой эсэхийг үнэлнэ.

Гепатитын D вирусийн архаг халдвартай өвчтөнд Пег-интерферон, Булевиртид эмчилгээг өвчтөний биеийн байдал, элэгний үйл ажиллагаа зэргийг харгалзан дан эсвэл хавсарсан эмчилгээ хийх эсэхийг шийднэ (Хүснэгт B.3, Хүснэгт B.4).

Гепатитын В ба D вирусийн халдвартай өвчтөнд гепатитын В вирусийн эсрэг нуклеоз(т)идын аналог эмийн эмчилгээг дараах нөхцөлд хийнэ.

- Циррозтой өвчтөнд HBV-DNA тооноос үл хамааран нуклеоз(т)идын аналог эмийн эмчилгээг хийнэ.
- Циррозгүй өвчтөнд HBV-DNA 2000 IU/mL-ээс их тодорхойлогдож байвал нуклеоз(т)идын аналог эмийн эмчилгээг хийнэ.

Хүснэгт B.3. Гепатитын D вирусийн архаг халдварын эмчилгээ

Үзүүлэлт	Пег-интерферон	Булевиртид
Эмчилгээний заалт	Гепатитын D вирусийн шалтгаант гепатит, ээнэгшилтэй цирроз	
Эмчилгээ үргэлжлэх хугацаа	48 долоо хоног	96 долоо хоногоос дээш
Хэлбэр	7 хоногт 1 удаа арьсан дор тарих	Өдөр бүр арьсан дор тарих
Хадгалалт	Хүйтэн хэлхээ	
Сул тал	Гаж нөлөө их	Өртөг өндөр, эмчилгээний хугацаа урт
Давуу тал	Эмчилгээний үргэлжлэх хугацаа бодино	Гаж нөлөө бага
Үр дүн	20–25%	Судлагдаж байна

Хүснэгт B.4. Гепатитын D вирусийн архаг халдварын эмчилгээний харьцуулалт

Удирдамж, эх сурвалж	Эмчилгээний сонголт	Эмчилгээ зогсоох заалт	Менежмент
AASLD 2018 (14)	Гепатитын D вирусийн идэвхжилтэй, АЛАТ ихэссэн өвчтөнд Пег-ИНФ 12 сар	HDV-RNA тодорхойлогдохгүй болох	Эмчилгээний дараа АЛАТ ихэсвэл HDV-RNA тодорхойлох мэргэшсэн төвд эмчилгээний хяналтыг хийх
APASL 2016 (15)	Пег-ИНФ 12–18 сар	HDV-RNA тодорхойлогдохгүй болох	Эмчилгээний дараа 6 сараас урт хугацаанд хянах
EASL 2023 (16)	ГДВ-ийн халдвартай элэгний эмгэг Пег-ИНФ >48 долоо хоног Булевиртид (үргэлжлэх хугацаа тодорхойгүй)	HDV-RNA тодорхойлогдохгүй болох	HDV-RNA удаан хугацааны туршид хянах
WHO 2018 (17)	Пег-ИНФ > 1жил	HDV-RNA тодорхойлогдохгүй болох	-

Гепатитын D вирусийн эмчилгээний үр дүнг дараах үзүүлэлтээр үнэлнэ.

- Вирусийн бүрэн хариу урвал: HDV-RNA тодорхойлогдохгүй болох
- Вирусийн бүрэн бус хариу урвал: HDV-RNA <2Log (>100 дахин буурах)
- Биохимийн хариу урвал: АЛАТ хэвийн болох
- Хавсарсан хариу урвал: HDV-RNA <2Log + АЛАТ хэвийн болох
- Серологийн хариу урвал: HBsAg арилах
- Гистологийн хариу урвал: гистологийн шинжилгээнд элэгний эсийн үрэвслийн зэрэг буурах

B.3.1. Пег-интерферон эмчилгээ

Пег-интерферон эмчилгээ нь вирусээр халдварлагдсан элэгний эсийн дархлааг идэвхжүүлснээр гепатитын В ба D вирусийн идэвхжилийг бууруулах нэлөөтэй (Зураг B.1).

Эмчилгээ эхлэх үндсэн шалгуур:

- Гепатитын D вирусийн шалтгаант (гепатитын D вирусийн ачаалалтай) элэгний үрэвсэл (АЛАТ-ын түвшин өндөр)
- Гепатитын D вирусийн шалтгаант (гепатитын D вирусийн ачаалалтай) даамжирсан фиброз (шууд ба шууд бус элэгний сорвижил тодорхойлох шинжилгээгээр)
- Гепатитын D вирусийн шалтгаант (гепатитын D вирусийн ачаалалтай) эзэнэгшилтэй циррозтой өвчтөн

Вирусийн үржлийг зогсоосноор элэгний үрэвсэл буурч, элэг сорвижихоос сэргийлэх боловч пег-интерферон эмчилгээний гаж нэлөө өндөр, үр дүн 20–25% байна.

Эмчилгээ эхлэх үндсэн шалгуур хангасан, эмчилгээг тасралтгүй 48 долоо хоног үргэлжлүүлэх боломжтой өвчтөнг лавлагагаа шатлалын эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтад эмчилгээг эхлүүлэх ба хяналтыг сар бүр хийнэ.

Гепатитын D вирусийн өвчтөнд HBV-DNA тодорхойлогдвол гепатитын В вирусийн эсрэг нуклеоз(т)идын аналог эмийн эмчилгээг пег-интерферон эмчилгээтэй

хавсруулан эхлэх ба пег-интерферон эмчилгээ зогсоосон ч нуклеоз(т)идын аналог эмийг үргэлжлүүлэн ууна.

Эмчилгээний өмнө qHBsAg түвшин бага (<1000 IU/mL) өвчтөнд пег-интерферон эмчилгээний явцад HBsAg арилах боломж өндөр байдаг.

Эмчилгээ эхлэхээс өмнө шинжилгээнд цагаан эс, ялтас эс буурсан өвчтөнд пег-интерферон эмчилгээний явцад цус төлжилт дарангуйлагдсантай холбоотой цусны цагаан эс, ялтас эс багасвал цагаан эс, ялтас эсийг өсгөх эмчилгээг хийх ба үр дүнгүй байх, шаардлагатай бол пег-интерферон эмчилгээг хугацаанаас өмнө зогсооно.

Пег-интерферон эмчилгээний туйлын эсрэг заалт:

- Ээнэгшилгүй цирроз
- Хорт хавдар
- Эрхтэн шилжүүлэн суулгасан
- Жирэмсэн
- Дархлааны шалтгаантай элэгний эмгэгүүд (K75 бүлгийн оноштой)
- Тромбоцитопени (<90000 эс/мл)
- Нейтропени (1500 эс/мл)
- Хашимото тиреойдит
- Зүрхний хүнд дутагдал
- Эмийн бодист харшилтай
- Сэтгэцийн эмгэг (F32 бүлгийн оноштой)
- Гемоглобинопати
- Ретинопати
- Бөөрний дутагдал

Эмчилгээ эхлэхийн өмнө дээрх эсрэг заалтыг заавал үгүйсгэх ба сэтгэл гутралын байдлыг Хамилтон (Хавсралт 1) эсвэл Бекийн (Хавсралт 2) асуумжаар дүгнэнэ.

Эмчилгээг хийх хугацаа: 48 долоо хоног (эмч тухайн өвчтөнд эмчилгээ сайн таарч байгаа байдал, HDV-RNA, qHBsAg зэргийн хөдлөл зүйд үндэслэн эмчилгээний хугацааг сонгож болно)

Хэрэглэх арга:

- Пег-интерферон альфа 2a 180 mcg, 7 хоногт 1 удаа арьсан дор тарих
- Пег-интерферон альфа 2b 0.5 эсвэл 1.0 mcg, 7 хоногт 1 удаа арьсан дор тарих

Пег-интерферон эмчилгээний үед илрэх гаж нөлөө:

- Томуу төст шинж
- Жин буурах
- Цус төлжилт дарангуйлагдах (улаан, цагаан, ялтас эс буурах)
- Ядрах,тамирдах
- Үс унах
- Хоолны дуршил буурах
- Нойргүйдэх
- Сэтгэл түгшил
- Сэтгэл гутрал зэрэг гаж нөлөө их гардаг тул эмчилгээг терөлжсөн мэргэжлийн эмч хянана.

Пег-интерферон эмчилгээний эхний 3 сард томуу төст хам шинж ажиглагддаг бол эмчилгээний 3 сараас хойш хоолны дуршил буурах, нойргүйдэх, жин буурах, сэтгэл түгшил илэрч эхэлнэ. Эмчилгээний туршид цусны эсүүд буурах шинж ажиглагддаг.

Эмчилгээний явцад тария хийсэн хэсэгт арьс загатнах, шалбараах, үрэвсэх шинж илэрч болох ба хэсэг газрын чийгшүүлэгч тосон түрхлэг, шаардлагатай бол

стеройдтой тосон түрхлэг хэрэглэж болно.

Халуун бууруулах, өвдөлт намдаах зорилгоор парацетамол, ибупрофен, хоолны шингэц сайжруулах прокинетик эмийг богино хугацаанд шинж тэмдэг багасгах зорилгоор хэрэглэнэ. Шаардлагатай үед сэтгэл гутралын эсрэг эмчилгээ хавсарна. Эмчилгээний явцад бамбайн дутагдал илэрвэл төрөлжсөн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авч шаардлагатай бол бамбайн гормон орлуулах эмчилгээг хавсарч хийнэ (Хүснэгт В.5).

Хүснэгт В.5. Пег-интерферон эмчилгээний гаж нөлөөний үед авах арга хэмжээ

Пег-интерферон эмчилгээ хийх үед цусны шинжилгээнд гарах өөрчлөлт	
Гемоглобин	
10–11 гр/дл	Пег-интерфероны тунг өөрчлөхгүй
8.5–10 гр/дл	Пег-интерферон альфа 2a тунг өөрчлөхгүй Пег-интерферон альфа 2b тунг 50% бууруулна
<8.5 гр/дл	Шинжилгээний үзүүлэлт хэвийн болтол эмчилгээг хийхгүй
Нейтрофилийн тоо	
<750	Пег-интерферон альфа 2a тунг 135mcg/долоо хоногт болгож бууруулна Пег-интерферон альфа 2b тунг 50%-р бууруулна
<500	Шинжилгээний үзүүлэлт хэвийн болтол хийхгүй. Циррозтой, ХДХВ/ДОХ халдвартай өвчтөнд бага тунгаар эмчилж хариу урвал илэрч байгаа бол гранулоцит идэвхжүүлэгч факторыг (G-CSF) 150-300 mcg-аар нейтрофилийн тоо >1500 болтол өдөр бүр арьсан дор тарина.
Ялтас эсийн тоо(эс/мл)	
<50000	Пег-интерферон альфа 2a тунг 90 mcg/долоо хоногт болгож бууруулна. Пег-интерферон альфа 2b эмчилгээг шинжилгээний үзүүлэлт хэвийн болтол хийхгүй.
<25000	Шинжилгээний үзүүлэлт хэвийн болтол эмчилгээг зогсоно.

Эмчилгээг үргэлжлүүлэх заалт:

Пег-интерферон 48 долоо хоногийн дараах эмчилгээний дүнд HDV-RNA >2 Log буурсан ч бүрэн арилаагүй, эмчилгээний хүнд зэргийн гаж нөлөө илрээгүй тохиолдолд пег-интерферон эмчилгээг 60–72 долоо хоног хүртэл сунгаж болно. Энэ хугацаанд эмчилгээний хяналтыг хэвээр үргэлжлүүлнэ.

Эмчилгээний үеийн хяналт:

- ЦЕШ, PT/INR, элэгний үйл ажиллагаа сар бүр (шаардлагатай үед 14 хоног тутам)
- HDV-RNA шинжилгээг эмчилгээний 12, 24 ба 48 дахь долоо хоногт, эмчилгээ зогсоосноос хойш 6 сарын дараа хянах
- HBV-DNA, qHBsAg эмчилгээний явц ба эмчилгээ дууссанаас хойш 6 сар тутамд хянах
- Хэвлийн хэт авиа, элэгний хавдрын маркер 3 сар тутам
- Сэтгэл гутралыг сар тутам Бекийн эсвэл Хамилтоны шалгуураар
- Биеийн жин 3 сар тутам

- Бөөрний үйл ажиллагаа, бамбайн гормоны түвшинг эмчилгээний явцад 3 сар тутам хянах
- Сэтгэл гутралыг илрүүлэх Хамилтоны шалгуур нь 17 асуумжтай ба хэвийн (0–5 оноо), хөнгөн (8–13 оноо), дунд (14–18 оноо), хүнд (19–22 оноо) ба маш хүнд (>23 оноо) зэргийн сэтгэл гутрал гэж үнэлнэ. Харин Бекийн асуумж нь 21 асуулттай ба хэвийн (0–10 оноо), сэтгэл санааны хямрал (11–16 оноо), хөнгөн (17–20 оноо), дунд (21–30 оноо), хүнд (31–40 оноо) ба маш хүнд (>40) зэргийн сэтгэл гутрал гэж үнэлнэ.

B.3.2. Булевиртид эмчилгээ

Булевиртид нь 47 амин хүчлээс тогтсон нийлэг липопептид бөгөөд элэгний эсэд HBsAg нэвтрэхэд холбогддог NCTR рецептор (Na^+ taurocholate cotransporting polypeptide / Натри $^+$ таурохолик котранспортер полипептид)-т нөлөөлснөөр гепатитын D вирус элэгний эсэд нэвтрэхийг хориглож, вирусийн үржилд дам нөлөө үзүүлдэг.

Булевиртид эмчилгээг лавлагаа шатлалын эмнэлгийн төрөлжсэн мэргэжлийн эмчийн хяналтад хийнэ.

Гепатитын D вирусийн халдвартай өвчтөнд HBV-DNA тодорхойлогдож байвал гепатитын B вирусийн эсрэг нуклеоз(т)идын аналог эмчилгээг булевиртид эмчилгээтэй хавсруулан хийх ба эмчилгээний дараа ч үргэлжлүүлэн ууна (Зураг B.1).

Эмчилгээг эхлэх үндсэн шалгуур:

- Гепатитын D вирусийн шалтгаант (гепатитын D вирусийн ачаалалтай) ээнэгшилтэй цирроз
- Гепатитын D вирусийн шалтгаант (гепатитын D вирусийн ачаалалтай) элэгний үрэвсэл

Вирусийн үржлийг зогсоосноор элэгний үрэвсэл буурч, элэг сорвижихоос сэргийлэх боловч эмчилгээ олон жилээр үргэлжлэх шаардлагатай.

Эмчилгээг хийх хугацаа: тодорхойгүй буюу 96 долоо хоногоос дээш

Хэрэглэх арга: Булевиртид 2 mg нунтгийг 1мл нэрмэл усаар шингэлж уусгаад хоногт 1 удаа арьсан дор тарих

Эмчилгээний эсрэг заалт:

- Энэгшил алдагдсан элэгний цирроз
- Жирэмсэн
- Хүүхэд (<18 нас)

Булевиртид эмчилгээний үеийн хяналт:

1. ЦЕШ, PT/INR, элэгний үйл ажиллагаа - сар бүр
2. HDV-RNA, HBV-DNA шинжилгээ: эмчилгээний явцад 3 сар тутамд, эмчилгээ дууссанаас хойш 6 сар тутамд хянах
3. Хэвлэлийн хэт авиа, элэгний хавдрын маркер 3 сар тутам
4. Ийлдсийн HBsAg түвшинг тоон үзүүлэлтээр тодорхойлох нь вирусийн эсрэг эмчилгээний үр дүнг хянах чухал шинжилгээ бөгөөд эмчилгээний явцад 6 сар тутамд хянах

B.3.3. Булевиртид ба пег-интерферон хавсарсан эмчилгээ

Булевиртид эмчилгээ эхэлсэн өвчтөнд эмчилгээний 12 дахь долоо хоногт HDV-RNA>2Log (>100 дахин) буураагүй үед пег-интерферон эмчилгээний эсрэг заалтгүй тохиолдолд хавсарсан эмчилгээ хийж болно (Зураг B.1).

Энэ эмчилгээний үед гепатитын B вирусийн эсрэг нуклеоз(т)-идын аналог эмчилгээг гепатитын D вирусийн эсрэг эмчилгээтэй хавсруулан хийх ба эмчилгээний дараа ч

үргэлжлүүлэн ууна.

Хэрэглэх арга: Пег-интерферон альфа 2a 180mcg-аар 7 хоногт 1 удаа, булевиртид 2 mg нунтгийг 1 мл нэрмэл уусмалаар шингэлж хоногт 1 удаа арьсан дор тарьж хэрэглэнэ. Эмчилгээний хяналт нь дан пег-интерферон эмчилгээтэй адил байна.



Тодорхой хугацаанд хэрэглэх
Халдвэр/өвчнийг эмчлэх

Удаан хугацааны эмчилгээ
Халдвэр/өвчнийг хянах

Зураг В.1. Гепатитын D вирусийн архаг халдварьн эмчилгээ

B.3.4 Эмчилгээ зогсоох заалт

Хүснэгт В.6. Гепатитын D вирусийн эмчилгээг зогсоох заалт

Эм бэлдмэл	Заалт
Пег-интерферон	<ul style="list-style-type: none">- Гемоглобин <8.5 гр/дл- Ялтас эсийн тоо <25000- Нейтрофилийн тоо <500- Эмчилгээний явцад циррозтой өвчтөнд элэгний ээнэгшил алдагдах (Child-pugh B, C)- Элэгний дутагдал- Хорт хавдар- Зүрхний шигдээс- Хүнд, маш хүнд зэргийн сэтгэл гутрал (Хамилтоны үнэлгээгээр > 19 оноо, Бэкийн асуумжаар >31 оноо)
Булевиртид	<ul style="list-style-type: none">- Эмчилгээг 96 долоо хоног ба түүнээс дээш үргэлжлүүлж, HDV-RNA тодорхойлогдохгүй болсноос хойш 6 сарын дараа- Элэгний ээнэгшил алдагдах
Эмчилгээг дахин эхлүүлэх заалт	<ul style="list-style-type: none">- Вирусийн үржил дахин сэдэрсэн (HDV-RNA, HBV-DNA дахин тодорхойлогдох)- АЛАТ ихсэх

B.3.5 Эмчилгээний хяналт

Вирусийн эсрэг эмчилгээний өмнө, явцад, дууссаны дараа өвчний даамжрал ба эмчилгээний үр дүнг хянана.

3.5.1 Эмчилгээний үеийн хяналт

Эмчилгээний гол үр дүн нь HDV-RNA тодорхойлогдохгүй болох, HBsAg арилж anti-HBs сероконверс үүсэх, эмчилгээний өмнө HBeAg эерэг байсан өвчтөнд HBeAg арилж, anti-HBe сероконверс (ийлдэс хөрвөх) үүснэ. Гэвч маш цөөн тохиолдолд дээрх үр дүнд хүрдэг тул нуклеоз(т)идын аналог эмийг удаан хугацаанд ууна (Хүснэгт В.7).3.5.2

Хүснэгт В.7. Вирусийн эсрэг эмчилгээний хяналт

	Пег-интерферон	Булевиртид	Булевиртид +Пег-интерферон
Сар бүр	<ul style="list-style-type: none"> - ЦЕШ - PT/INR - Элэгний үйл ажиллагаа - Сэтгэл гутралын хяналт 	<ul style="list-style-type: none"> - ЦЕШ - PT/INR - Элэгний үйл ажиллагаа 	<ul style="list-style-type: none"> - ЦЕШ - PT/INR - Элэгний үйл ажиллагаа - Сэтгэл гутралын хяналт
3 сар тутам	<ul style="list-style-type: none"> - Хэвлийн хэт авиа - Биеийн жин - AFP - HDV-RNA 	<ul style="list-style-type: none"> - Хэвлийн хэт авиа - Биеийн жин - AFP - HDV-RNA* 	<ul style="list-style-type: none"> - Хэвлийн хэт авиа - Биеийн жин - AFP - HDV-RNA
6 сар тутам	<ul style="list-style-type: none"> - HBV-DNA - qHBsAg - TSH 	<ul style="list-style-type: none"> - HBV-DNA - qHBsAg 	<ul style="list-style-type: none"> - HBV-DNA - qHBsAg - TSH

*HDV-RNA шинжилгээг эмчилгээний эхний жилд эмчилгээний 3, 6, 12 дахь сард цаашид 6 сар тутам давтамжтай

3.5.2 Пег-интерферон, Булевиртид эмчилгээ дууссаны дараах хяналт

- Дельта вирусийн эсрэг пег-интерферон, булевиртид эмчилгээ зогсоох үед эмчилгээний төгсгөл дэх ЦДШ, элэгний үйл ажиллагаа, qHBsAg, HBV-DNA, HDV-RNA шинжилгээ хийнэ. Энэ шинжилгээнд HDV-RNA ачаалалгүй үед эмчилгээний төгсгөлд эмчилгээ үр дүнтэй гэж үзнэ.
- Эмчилгээ зогсоосноос хойш 6 сарын дараа HDV-RNA, HBV-DNA шинжилгээгээр эмчилгээний үр дүнг үнэлэх ба цаашид жил бүр давтана.
- Эмчилгээ зогсоосноос хойш 6 сарын дараа дээрх шинжилгээг дахин давтаж HDV-RNA тодорхойлогдохгүй бол эмчилгээ үр дүнтэй гэж үзнэ. Вирус ачаалалгүй гарсан ч В вирусийн эсрэг нуклеоз(т)-ид аналог эмчилгээг үргэлжлүүлэн уух ба HBV-DNA тодорхойлогдохгүй үед эмчилгээний хяналтад qHBsAg үзнэ. Эмчилгээний төгсгөлд HDV-RNA тодорхойлогдсон үед эмчилгээ үр дүнгүй гэж үзнэ.
- Эмчилгээний төгсгөлд вирус ачаалалгүй байсан хүнд 6 сарын дараах шинжилгээнд HDV-RNA тодорхойлогдвол эмчилгээ үр дүнгүй гэж үзнэ. Хяналтын шинжилгээнд qHBsAg сөрөг болсон үед HBsAg арилсан гэж үзнэ.
- Эмчилгээний дараах хяналт нь элэгний циррозгүй өвчтөнд 6 сар тутам ЦДШ, элэгний үйл ажиллагаа, хэвлийн эхо, AFP (боломжтой бол PIVKA II) үзнэ. Жил бүр qHBsAg шинжилгээг давтана.
- Элэгний циррозтой өвчтөнд 3 сар тутам ЦДШ, элэгний үйл ажиллагаа, хэвлийн хэт авиа, AFP (боломжтой бол PIVKA II) үзнэ. Жил бүр qHBsAg шинжилгээг давтана.
- Гепатитын D вирусийн эсрэг эмчилгээ дууссан, эсвэл эмчилгээг зогсоосон үед гепатитын B вирусийн эсрэг нуклеоз(т)-идын аналог эмчилгээг заалтын дагуу ууна. Ялангуяа булевиртид эмчилгээ дууссан, эсвэл эмчилгээг зогсоосон үед гепатитын B вирусийн эсрэг нуклеоз(т)-идын аналог эмийг үргэлжлүүлэн ууна.
- Гепатитын D вирусийн эсрэг эмчилгээ дууссан, эсвэл эмчилгээг зогсоосны дараах эхний 1 жилд төрөлжсөн мэргэжлийн эмчийн тогтмол хяналтад байна. Эмчилгээ зогсоосны дараа зовуурь, шинж тэмдэг нэмэгдэх, шинээр шинж

тэмдэг илрэх, биеийн байдал дордох зэрэг өөрчлөлт гарвал товлолт хяналтын хугацаа үл хамааран хяналтын эмч яаралтай үзэж, шаардлагатай шинжилгээ, оношилгоонд хамруулна.

Г.1 ХҮН АМЫН ӨВӨРМӨЦ БҮЛЭГ

Г.1.1 Мансууруулах бодис судсаар тарьж хэрэглэгчид

Эдгээр хүмүүст вирусийн шалтгаант элэгний өвчин, халдвартын тархалт, нас барагт илүүтэй тохиолдох ба халдвартархад өндөр эрсдэлтэй бүлэгт тооцогддог. Сайн дурын ба товлолт шинжилгээгээр HBsAg, ХДХВ-ийн эсрэгбие илрүүлнэ.

Эмч, нийгмийн ажилтны багийн тусламжтайгаар эмчилгээний өмнөх зөвлөгөө өгч эрүүл мэндийн боловсрол олгоно. Тусламж үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр, тэгш хүртээмжтэй үзүүлнэ. Мансууруулах бодисын хор хөнөөлийг бууруулах, зүү тариур солилцох хөтөлбөр хэрэгжүүлнэ. Гепатитын В вирусийн вакцинжуулалтанд хамруулах, хавсарсан халдвартыг эмчлэх арга хэмжээг хамт хэрэгжүүлнэ

Г.1.2 ХДХВ/ДОХ хавсарсан халдвар

ХДХВ-ийн хавсарсан халдвартын үед элэгний эмгэг хурдан даамжрах, элэгний цирроз ба элэгний хорт хавдарт шилжих, элэгний эмгэгийн улмаас нас барах, ХДХВ-ийн халдвартгүй хүмүүстэй харьцуулахад эмчилгээнд тэсвэртэй болох зэргээр ГВВ/ГДВ-гепатитын вирусийн халдвартын эмнэлзүйд онцгой нөлөөтэй. Түүнчлэн ХДХВ/ДОХ ба ГВВ-ийн эсрэг эмэнд нэгэн зэрэг тэсвэртэй болох, эмийн шалтгаант элэгний гэмтэл, ретровирусийн эсрэг эмийн (РВЭ) хамааралт гепатитын дархлааны хувьсал, АЛАТ ихсэнэ. Хэрэв РВЭ эмчилгээ нь эдгээр халдварт зэрэг нөлөөлж чадахгүй бол фульминант гепатит үүсгэх зэрэг үр дагавартай.

РВЭ эмчилгээг эхлэх: ДЭМБ-ын 2013 оны удирдамжийн дагуу CD4 эсийн тоо 500 эс/мм³ хэмжээнээс буурвал HIV халдвартай хүмүүст эмчилгээг эхэлнэ, энэ нь халдвартай жирэмсэн, хөхүүл ээж, 5-аас бага насын хүүхдэд хамаатай юм. Элэгний эмгэг хүндэрсэн, давшигчийн явцтай, элэгний эмгэгийн улмаас нас барах өндөр эрсдэлтэй бол CD4 эсийн хэмжээг үл харгалзан РВЭ эмчилгээг эхэлнэ. Элэгний цирроз бүхий хүмүүст РВЭ эмчилгээ амьдрах хугацааг уртасгадаг тул тус эмчилгээг эхлүүлэх нь чухал юм. CD4 эсийн тоо 500 эс/мм³ хэмжээнээс их үед РВЭ эмчилгээний үр дүн тодорхой бус байна.

Бусад зөвлөмж: ХДХВ/ДОХ халдвартай хүмүүст АЛАТ ихсэх нь бусад хавсарсан халдвар, РВЭ ба сүрьеэгийн эмийн элгэнд үзүүлэх хоруу чанар, архины хэрэглээ, HBV арилах, дархлааны хувирал, эмэнд тэсвэржилт, эмчилгээ зогссони дараах өвчиний сэдрэл ба ГДВ, ГАВ, ГСВ, ГЕВ зэрэг вирусийн халдвар өндөр улс оронд вирусийн дахин халдвар авсантай холбоотой. Элэгний өвчиний хожуу үе шатанд этавиренз эмийн тун ихэсч, төв мэдрэлийн тогтолцооны хордлого үүсгэдэг бол типранавир ба невирапин эм элэгний хордлого үүсгэх аюултай тул эдгээр эмийг хэрэглэхээс аль болох зайлсхийх хэрэгтэй.

Хүснэгт Г.1. ГВВ, ГДВ ба ХДХВ/ДОХ хавсарсан халдвартай өсвөр насын хүүхэд ба насанд хүрэгчдэд РВЭ эмчилгээг эхлэх зөвлөмж

-
- ХДХВ/ДОХ өвчний хүнд ба хожуу шатанд (ДЭМБ-ын ангиллаар эмнэлзүйн 3 ба 4-р шат), CD4 эсийн тоо <500 эс/мм³-с буурсан үед РВЭ-эмчилгээг эхэлнэ
 - CD4 эсийн тоо <500 эс/мм³-с буурсан ХДХВ/ДОХ халдвартай хүмүүст ДЭМБ-ын ангилал үл хамаарч РВЭ эмчилгээг эхэлнэ

Дараах тохиолдолд ДЭМБ-ын ангилал ба CD4 эсийн тоог үл хамаарч эмчилгээг эхэлнэ:

- ХДХВ/ДОХ ба идэвхитэй сурьеэтэй
- ХДХВ/ДОХ ба элэгний хүнд хэлбэрийн эмгэг бүхий гепатитын В вирусийн халдвартай өвчтөн
- Хамтран амьдардаг хүмүүст ХДХВ/ДОХ сорил эргэлзээтэй, эсвэл халдвартай бол ХДХВ/ДОХ халдвар дамжихаас сэргийлж
- ХДХВ/ДОХ халдвартай жирэмсэн, хөхүүл эмэгтэйд
- ХДХВ/ДОХ халдвартай 5-аас бага насын бүх хүүхдэд ДЭМБ –ын ангилал ба CD4 эсийн тоог үл хамаарч РВЭ эмчилгээг эхэлнэ

Г.1.3 Хүүхдэд хийгдэх эмчилгээ

Хүүхдэд В вируст архаг гепатит ихэвчлэн шинж тэмдэггүй тохиолдох ба дархлаатэвчлийн шатандаа байх тул вирусийн эсрэг эмчилгээ хийх шаардлагагүй. Харин гепатитын В вирусийн халдварын үед пегинтерферон эмчилгээг заасан хугацаанд хийх нь хүүхэд, өвсөр насынханд үр дүнтэй байдгийг тогтоосон. Пег-интерфероныг нэг хүртэлх насын хүүхдэд хэрэглэхгүй. Тенофовир дезоксифумират, энтекавирийг 2-оос дээш насын хүүхдэд хэрэглэхийг зөвшөөрсөн. 2-оос бага насын хүүхдэд вирусийн эсрэг эмчилгээний асуудал судлагдаагүй байгаа. Гепатитын D вирусийн халдварын үед хүүхдэд пег-интерферон эмчилгээ хийх асуудал одоогоор тодорхойгүй байна. Булевиртид эмчилгээний үр дүн хүүхдэд судлагдаагүй байна.

Г.1.4 Элэгний бус холбогч эдийн тогтолцооны эмгэг

Гепатитын В вирусийн халдвартай өвчтөнд холбогч эдийг хамарсан элэгний бус шинж болох арьсны өөрчлөлт, полиартрит, зангилаат периартериит, гломерулонефрит илрэх ба вирусийн эсрэг эмчилгээ нуклеоз(т)ид аналог бэлдмэлд мэдрэг байдаг. Элэгний бус шинжийг вирусийн эсрэг эмзэр эмчилсэн судалгаа хангалтгүй байна. Пег-интерферон дархлааны шалтгаант элэгний бус шинж тэмдгийг дордуулах тул хэрэглэхгүй байхыг зөвлөдөг.

Г.1.5 Бөөр орлуулах эмчилгээ ба бөөр шилжүүлэн суулгасан өвчтөн

Бөөрний эмгэгийн төгсгөлийн шат, бөөр шилжүүлэн суулгасан өвчтөнүүдэд Гепатитын В, D вирусийн халдвар илрүүлэх шинжилгээ хийж, халдвартай бол дархлаажуулалт хийх шаардлагатай. Бөөрний дутагдалтай, бөөр шилжүүлэн суулгасан өвчтөнүүдэд вирусийн эсрэг эмийг хэрэглэхдээ (тенофовир, энтекавир, тенофовир альфенамид) тунг тохируулж, болгоомжтой хэрэглэнэ. Вирусийн эсрэг эмчилгээний явцад бөөрний үйл ажиллагааг хянаж байх ёстой бөгөөд эмчилгээний явцад бөөрний дутагдал гүнзгийрвэл эмчилгээг солих юмуу тунг дахин тохируулах хэрэгтэй. Шилжүүлэн суулгасан бөөр ховхрох эрсдэлтэй байдгаас интерферон эмчилгээг зөвлөдөггүй. Бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэж буй HBsAg-ээрэг өвчтөн бүр гепатитын В вирусийн халдвар дахин идэвхижихээс сэргийлж нуклеоз(т)ид аналог эмийг хэрэглэх шаардлагатай.

Г.1.6 Гепатитын С вирусийн хавсарсан халдвар

Гепатитын В, D вирусийн халдвартай хүмүүст гепатитын С вирусийн халдвар хавсрах нь элэгний өвчнийг даамжуулж, элэгний хорт хавдар үүсгэх, нас барах эрсдэлийг нэмэгдүүлдэг. гепатитын С вирусийн халдвар идэвхитэй үед HBV-DNA ихэвчлэн бага байх, эсвэл тодорхойлогдохгүй, ийм тохиолдолд анхдагч эмчилгээ

нь гепатитын С вирусийн халдвартыг эмчилнэ. гепатитын В ба С вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээ хийж, аль вирус идэвхитэй буйг тогтооно. ДЭМБ-аас гепатитын С вирусийн эсрэг уух эмийн эмчилгээг зөвлөж байна. Эмчилгээний үед, төгсгөлд гепатитын В вирусийн идэвхижил дахилтыг HBV-DNA шинжилгээгээр шалгаж байх ба хэрэв идэвхижвэл нуклеоз(т)ид аналог эмийн эмчилгээг эхэнэ.

Г.1.7 Сүрьеэгийн хавсарсан халдвар

Эдгээр халдвар нутагшмал гардаг улс оронд хавсарсан халдвар тохиолдох нь элбэг. Энэ үед оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээ нэмэх шаардлагатай. Мансууруулах тариа хэрэглэдэг, широнгийн хоригдол зэрэг хүмүүст гепатитын В ба С вирус ба сүрьеэгийн хавсарсан халдвар олон тохиолдоно. Гепатитын В вирусийн халдвартай өвчтөнд дөрвөн шинж тэмдгээр сүрьеэгийн халдварын эрт илрүүлгийг хийнэ. Хэрэв ханиалга, жин буурах, халуурах, шөнө хөлрөх зэрэг шинж тэмдэг илэрвэл идэвхитэй сүрьеэг илтгэх ба цаашид оношийг нотлох шинжилгээг төлөвлөх шаардлагатай. Гепатитын В ба С вирус, ХДХВ/ДОХ халдварын үед сүрьеэгийн эсрэг эм изонаизид, рифампицин, пиразинамид хэрэглэхэд эмийн шалтгаант элэгний гэмтэл үүсч, АЛАТ идэвхиждэг.

Г.1.8 Элэг шилжүүлэн суулгах эмчилгээ

Элэг шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх заалттай өвчтөнүүд хагалгааны өмнө элэг шилжүүлэн суулгах багийн гепатолог эмчийн хяналтанд нуклеоз(т)ид аналог эм ууна. Элэгний В вирусийн шалтгаант эмгэгүүд (элэгний цирроз, элэгний хавдар, элэгний дутагдал г.м)-ийн улмаас элэг шилжүүлэн суулгуулсан өвчтнүүдэд В вирусийн халдвар дахих эрсдлийг бууруулах зорилгоор В вирусийн эсрэг эмүүдийг элэг шилжүүлэн суулгасны дараах эмчилгээнд зайлшгүй зөвлөдөг. Уг эмчилгээг сонгоходоо элэг шилжүүлэн суулгахын өмнө HBV-DNA төвшин ямар байснаас дахин халдвар үүсэх, халдвар сэргэх эрсдэл бий эсэхийг дүгнэж болно. Тухайлбал мэс заслын өмнө HBV-DNA идэвхгүй буюу тоологдоогүй бол халдвар дахин идэвхжих эрдсэл бага байдаг. Нуклеоз(т)идын аналог эмүүдийг мэс заслын өмнө аль болох эрт амаар уулгах нь нь гепатитын В вирусийн халдвар дахин идэвхжихээс сэргийлдэг бөгөөд, мэс заслын дараа HBIG хэрэглэх шаардлагагүй. Харин гепатитын В,D вирусийн хавсарсан халдвартай, HBV-DNA идэвх бага үед мэс заслын дараа аль болох эрт HBIG болон нуклеоз(т)ид аналог эмийн хослолыг эхлүүлэх нь вирусийн халдвар дахин идэвхжихээс сэргийлж буй эмчилгээний алтан стандарт юм. HBIG хэрэглэх тун нь олон улсын томоохон төвүүдэд харилцан адилгүй байгаа бөгөөд дийлэнх төвүүд anhepatitic үед HBIG 10.000IU судсанд дуслаар, үргэлжлүүлээд өдөрт 600-1000IU булчин/судсанд 7 хоног, цаашид 7 хоногт нэг удаа 3 долоо хоног, сард нэг удаа 3-6 сар хэрэглэхийг зөвлөж байна.

Г.1.9 Элэгний ба бусад хорт хавдар

Гепатитын D вирусийн эсрэг эмчилгээ эхлэхийн өмнө элэгний хорт хавдрыг үгүйсгэх шаардлагатай. Элэгний хорт хавдрын улмаас төгс (Мэс засал, этанол тарих эмчилгээ, тулэх эмчилгээ, судас бөглөх) эмчилгээ хийгдсэн, хавдар дахилтгүй бол мөн бусад эрхтний хавдрын төгс эмчилгээ хийгдсэн тохиолдолд пег-интерферон, булевиртид эмчилгээг төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтад эхэлж болно. Эмчилгээний явцад элэгний хорт хавдрын дахилтыг AFP, хэвлийн хэт авиа, шаардлагатай бол хэвлийн тодосгогчтой компьютер хийлгэж хянана.

Г.1.10 Жирэмсэн эх

Гепатитын D вирусийн архаг халдвартай жирэмсэн эхэд вирусийн эсрэг эмчилгээг хийхгүй. Гепатитын В вирусийн халдвартай жирэмсэн эхэд “Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү, гепатитын В вирусийн халдвар дамжихыг таслан зогсоох” зааврыг мөрдөн, тусламж үйлчилгээ үзүүлнэ.

Г.1.11 Эрүүл мэндийн ажилтнууд

Гепатитын В вирусийн илрүүлэг шинжилгээнд хамруулж, HBsAg илрээгүй тохиолдолд ГВВ-ийн эсрэг вакцинд хамруулах нь гепатитын D вирусийн халдвараас сэргийлнэ. HBsAg илэрсэн үед эрүүл мэндийн ажилтнуудад зааврын дагуу тусlamж үйлчилгээ үзүүлнэ.

Д.1 Гепатитын D вирусийн халдвартай өвчтөний эмчилгээний асуудлыг шийдвэрлэх

Д.1.1. Эмч нарын баг

1. ХӨСҮТ-ийн дэргэд гепатитын D вирусийн эсрэг эмчилгээнд (пег-интерферон, булевиртид) хамруулах өвчтөн болон эмчилгээний горим сонгох, эмчилгээний үр дүнг хянах орон тооны бус эмч нарын баг ажиллана.

2. Эмч нарын баг нь ХӨСҮТ, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дотрын анагаах судлалын эмч, халдварт өвчин судлалын эмч нар, Эм судлалын мэргэжлийн салбар зөвлөл, АШУИС-ийн Хоол боловсруулах эрхтэн судлалын тэнхим, Монголын гастроэнтерологийн холбоо, Монголын элэгний эмч нарын нийгэмлэгийн төлөөллөөс бүрдсэн байна.

3. Эмч нарын баг нь гепатитын D вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдаж буй иргэдийн эмийн хүртээмж, хадгалалт, нөөц, зохистой хэрэглээ, гаж нөлөөний асуудлыг тогтмол хэлэлцэнэ.

4. Эмч нарын баг нь гепатитын D вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдаж буй иргэдийн лабораторийн шинжилгээний чанар, хүртээмж, тусlamж үйлчилгээнд тулгарч буй бусад асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлно.

5. Эмч нарын багийн бүрэлдэхүүнийг ХӨСҮТ-ийн захирал холбогдох журамд нийцүүлэн томилно.

6. Мэргэжлийн эмч нарын баг нь Гепатитын D вирусийн халдвартай өвчтөний эмчилгээний асуудлаар сард нэг удаа зөвлөгөөн хийнэ.

7. Зөвлөгөөний нийт гишүүдийн ирц 75 хувиас дээш тохиолдолд хүчинтэйд тооцно.

8. Зөвлөгөөний нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана.

9. Гепатитын D вирусийн халдвартай өвчтөний эмчилгээ, хавсарсан эмгэгтэй хүнд өвчтөний эмчилгээний хяналтад асуудал гарсан тохиолдолд эмч нарын багийн зөвлөгөөнд төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ хариуцсан дарга эсвэл дотрын тасгийн эрхлэгч нар цахим хэлбэрээр оролцож болно.

10. Эмч нарын багийн зөвлөгөөний шийдвэрийн маягтын загварыг ХӨСҮТ-ийн захирал батална.

11. Эмч нарын багийн зөвлөгөөний шийдвэрийн маягтыг үндэслэн эмч нар эмийн жор бичнэ.

Д.1.2 Гепатитын D вирусийн халдвартай өвчтөний эмчилгээний асуудлыг эмч нарын зөвлөгөөнөөр анх удаа оруулахад дараах материалыг бүрдүүлнэ.

1. Эмнэлзүйн зааврын дагуу пег-интерферон, булевиртид эмчилгээ хийлгэх заалт, шалгуурт тохирсон өвчтөн оршин суух тодорхой харьялалтай байна.

2. Дараах материалыг эх хувиар нь бүрдүүлсэн байна.

- 2.1. Гепатитын вирусийн архаг халдвартай болон үр дагаврын тохиолдлыг бүртгэх мэдээлэх маягтаар өвчтөнийг бүртгэсэн байх (эмчлэгч эмч)
- 2.2. Өвчний түүх, амбулаторийн картын хуулбар (эмчлэгч эмч)
- 2.3. Гепатитын D вирусийн халдвартай өвчтөний эмчилгээнд оруулахад өвчтөн болон гэр бүлийн гишүүн нь вирусийн эсрэг эмчилгээтэй танилцан, эмчилгээ хийлгэхийг зөвшөөрсөн таниулсан зөвшөөрлийн хуудас (Хавсралт 1)
- 2.4. Шинжилгээ (HBV-DNA, HDV-RNA сүүлийн 6 сарын хугацаанд, бусад шинжилгээ сүүлийн 14 хоногт хийгдсэн байна)
 - 1) Anti-HDV, HBsAg, эсвэл qHBsAg тодорхойлсон шинжилгээ
 - 2) HBV-DNA, HDV-RNA тодорхойлсон шинжилгээ
 - 3) Цусны дэлгэрэнгүй шинжилгээ, коагулограмм
 - 4) Биохимийн шинжилгээ
 - 5) Шээсний ерөнхий шинжилгээ
 - 6) Хэвлэлийн тодосогчтой КТ
 - 7) Элэгний фиброзын тодорхойлох шинжилгээ /Эластографи, APRI, Fib-4 аль нэг/
 - 8) AFP, боломжтой бол PIVKA-II
 - 9) Улаан хоолой, ходоодны дуран
 - 10) TSH, T4, T3
 - 11) Зүрхний цахилгаан бичлэг
 - 12) Бек эсвэл Хамилтоны сэтгэл гутралын сорил
 - 13) Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд жирэмснийг тодорхойлох сорил

Хавсралт 1

ГЕПАТИТЫН D ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ҮЕД ПЕГ-ИНТЕРФЕРОН ТАРИА ЭМЧИЛГЭЭ ХИЙХ ТАНИУЛСАН ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

Гепатитын D вирусийн халдвартын үед хийгдэх пег-интерферон эмчилгээний горим, хяналт, эмийн гаж нэлүүний талаарх мэдээллийг хүргэж байна. Монгол Улсад эмнэлгийн тусламж үйлчилгээнд мөрдөх гепатитын вирусийн халдвартын эмнэлзүйн зааврын дагуу пег-интерферон тариаг долоо хоногт нэг удаа арьсан дор тарих ба эмчилгээ 48 долоо хоног үргэлжилнэ. Пег-интерферон эмчилгээний үед гепатитын В вирусийн эмчилгээний зааврыг мөрдэж, вирусийн эсрэг нуклеоз(т)ид аналог эмийг (тенофовир, энтекавир г.м) хэрэглэнэ.

Эмчилгээний заалт	Гепатитын D вирусийн шалтгаант элэгний архаг үрэвсэл, ээнэгшилтэй үе шатанд буй элэгний циррозтой өвчтөнг эмчлэх
Эмчилгээг хийж болохгүй эсрэг заалт	<ul style="list-style-type: none">- Элэгний циррозын ээнэгшил алдагдсан үе шат- Хорт хавдар- Дархлааны шалтгаант элэгний ба бусад эмгэг /тиреоидит/- Эрхтэн шилжүүлэн суулгасан хүн- Тромбоцитопени (<90000 эс/мл), Нейтропени (1500 эс/мл), Гемоглобинопати- Эмийн харшилтай- Жирэмсэн ба хөхүүл эх- Бамбай булчирхайн эмгэг- Ретинопати- Бөөрний дутагдал
Эмчилгээний	48 долоо хоног (1 жил)

хугацаа	
Эмчилгээний үр дүн	Гепатитын D вирус идэвхигүй болох 20–25%
Эмчилгээний явцын хяналт	- Эхний 1 сард 7–14 хоног тутам /Үзлэг, ЦЕШ, элэгний биохими/ - 1 сар тутам /Үзлэг, ЦЕШ, элэгний биохими/ - 3 сар тутам / хэвлийн хэт авиа, HDV-RNA / - 6 сар тутам / HBV-DNA, qHBsAg, TSH/
Эмчилгээ дуусаад 1 жилийн хяналт	- 3 сар тутам / Үзлэг, ЦЕШ, элэгний биохими, хэвлийн хэт авиа / - 6 сар тутам / HDV-RNA, HBV-DNA, qHBsAg/
Эмчилгээний гаж нөлөө	Томуу төст шинж, жин буурах, цус төлжилт дарангуйлагдах (улаан, цагаан, ялтас эс цөөрөх), ядрах, үс унах, хоолны дуршил буурах, нойргүйдэх, сэтгэл түгших, гутрах зэрэг шинж илрөч болно. Эмийн гаж нөлөөг эрт оношилж, тохирсон арга хэмжээг авч, болзошгүй эрсдэл хүндрэлээс сэргийлнэ. Эмийн гаж нөлөө хүнд хэлбэрээр илэрвэл эмчилгээг зогсоно.
Эмчилгээний үр дүнг бууруулах хүчин зүйл	Эм тариаг буруу хадгалах, тарихгүй алгасах, эмчилгээг эрт зогсоох гэх мэт
Эмчилгээний үр дүнг сайжруулах хүчин зүйл	Хяналтын товлолт шинжилгээнд хамрагдах, эмийн гаж нөлөөг хянаж, тохирсон арга хэмжээг авах, эмчилгээг бүрэн хийж дуусгах гэх мэт
Орлуулах эмчилгээ	Булевиртид 2 mg өдөрт 1 удаа арьсан дор тарих, эмчилгээ 2–3 жил үргэлжилнэ
Эмийн сүл тал	- Эмийн гаж нөлөө - 7 хоног тутам тарьж хэрэглэнэ - Тариаг хүйтэн хэлхээний горимын дагуу хадгална
Эмийн давуу тал	- Эмчилгээ үргэлжлэх хугацаа тодорхой - Булевиртид эмчилгээтэй харьцуулахад үнэ өртөг бага

..... овогтой..... (Регистрийн дугаар.....) миний бие пег-интерферон эмчилгээний горим, хяналт, эмийн гаж нөлөөний талаарх мэдээлэл эмчээс бүрэн авсан. Иймээс Би эмчийн заавар зөвлөгөөг даган, хяналтын товлолт шинжилгээнд хамрагдаж, эмчилгээ хийлгэхийг зөвшөөрч байна.

Эмч, би үйлчлүүлэгчдээ дээр дурдсан мэдээллийг энгийн ойлгомжтой, дэлгэрэнгүй тайлбарлаж, асуултанд хариу өгсөн болно.

Үйлчлүүлэгчийн гарын үсэг
Хугацаа: Цаг :

Огноо: Он / Сар/ Өдөр

Үйлчлүүлэгчийн асран хамгаалагчийн нэр, гарын үсэг Огноо: Он / Сар/ Өдөр
Хугацаа: Цаг :

Эмнэлэг, Эмчийн нэр, гарын үсэг
Хугацаа: Цаг :

Огноо: Он / Сар/ Өдөр

Хавсралт 1. Сэтгэл гутралыг илрүүлэх Хамилтоны шалгуур

<p>1. Өнгөрсөн долоо хоногт танд сэтгэлээр унах, итгэл найдвараа алдах, өөртөө итгэлгүй болох, хэнд ч хэрэггүй болсон мэт санагдаж байсан уу? Хэрэв тийм бол хэдэн хоногт дээрх шинж илэрсэн бэ?</p>	<p>1. Үгүй 2. Ганц нэг илэрч байсан 3. Хааяа 4. Ихэвчлэн 5. Байнга илэрч байсан</p>
<p>2. Өнгөрсөн өдрүүдэд өөрийгөө ямар нэгэн зүйлд буруутгаж байсан уу?</p>	<p>1. Үгүй 2. Өөрийгөө буруушсан тохиолдол цөөн гарсан 3. Хааяа 4. Ихэвчлэн 5. Байнга илэрч байсан</p>
<p>3. Ингэж байснаас үхсэн нь дээр гэсэн бодол орж ирж байсан уу?</p>	<p>1. Үгүй 2. Тийм бодол төрж байсан 3. Үхлийн тухай боддог болсон 4. Амиа хорлох тухай бодол орж ирж байсан 5. Амиа хорлох оролдлого хийсэн</p>
<p>4. Өнгөрсөн 7 хоногт таны нойр хэр байсан бэ?</p>	<p>1. Нойр хэвийн байсан 2. Орондоо орсны дараа 30 минутаас илүү хугацаанд нойр хулжих тохиолдол нойр хулжиж байсан. 3. Ихэнхдээ нойр хулждаг</p>
<p>5. Өнгөрсөн долоо хоногт шөнө дунд сэргж, эргэж унтаж чадахгүй сэргэлзэх тохиолдол гарч байсан уу?</p>	<p>1. Үгүй 2. Шөнө нойр сэргэлзэх, амраагүй мэт сэтгэгдэл төрж байсан 3. Шөнө байнга сэргж, орноосоо босдог</p>
<p>6. Өнгөрсөн хоногуудад өглөө эрт сэргж байсан уу?</p>	<p>1. Нойрны хямрал гарч байгаагүй 2. Өглөө эрт сэргдэг, гэхдээ эргээд унтдаг 3. Өглөө эрт сэргээд, эргэж унтах гэхээр нойр хүрдэггүй тул босохоос өөр аргагүй болдог.</p>
<p>7. Өнгөрсөн өдрүүдэд таны ажил, өдөр тутмын амьдралд хандах хандлага өөрчлөгдсөн үү? Урьд нь дуртай хийдэг байсан зүйлээ хийхээс дургүй хүрэх үе гарч байсан уу?</p>	<p>1. Ямар нэг асуудал гардаггүй 2. Ямар нэгэн өөр зүйл хийнэ гэж бодоход өөрийн эрхгүй ядарч, сурьдах, идэвхгүй болж, хөдлөхөөс дургүй хүрдэг 3. Урьд нь сонирхдог байсан зүйлдээ сонирхолгүй болсон 4. Өөр зүйлд цаг зарцуулахаа болсон, идэвх буурсан 5. Энэ өвчний улмаас ажилаа ч хийхээ болжсон</p>
<p>8. Өнгөрсөн өдрүүдэд та уур, уцаартай байсан уу? Урьд нь тэгтлээ уцааарладаггүй байсан жижиг зүйлд уурлах тохиолдол гарч байсан уу?</p>	<p>1. Үгүй 2. Амархан уцаарах тохиолдол гарч байсан 3. Жижиг зүйлд байнга уцаарладаг 4. Өөрийгөө жижиг зүйлд уурлаад байгаагаа мэдээд санаа зовж байна. 5. Өөрийн эрхгүй уурлаж уцаарлах болсноо хүлээж зөвшөөрч байна</p>

<p>9. Өнгөрсөн долоо хоногт дараах шинжүүд илэрч байсан уу? (доогуур нь зурна уу)</p> <p>Дээрх шинжүүд хэр тогтолцсон бэ?</p>	<p>Хоол боловсруулах зам: ам хатах, гэдээс дүүрэх, хоолны шингэц буурах, гүйлгэх, шөрмөс татах, хэхрэх, баас хатах Зүрх судасны тогтолцоо: зүрх дэлсэх, толгой өвдөх Амьсгалын зам: санаа алдах, хөлрөх, амьсгал давчидах, ойр ойрхон шээх</p> <ol style="list-style-type: none"> 1. Ипрээгүй 2. Хөнгөн зэргээр 3. Дунд зэрэг 4. Хүнд хэлбэрээр 5. Хөдөлж чадахгүй болтол
<p>10. Таны хоолны дуршил хэр байна бэ?</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хэвийн 2. Хоолны дуршил буурсан 3. Хоолны дуршилгүй болсон, хоол идэх хэрэгтэй гэж бодоод л хоол иддэг
<p>11. Таны биеийн байдал хэр байна? Ямар нэг зовиур шаналгаа байна уу?</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хэвийн байсан 2. Гар хөл хүндэрч, толгой, нуруу, булчин өвдсөн 3. Илэрхий би супарч, ядрах байнга зовиурлах болсон
<p>12. Таны бэлгийн идэвх өөрчлөгдсөн үү?</p>	<ol style="list-style-type: none"> 1. Өөрчлөгдөөгүй 2. Бага зэрэг буурсан 3. Илэрхий супарсан
<p>13. Та өөрийн өвчний талаар санаа зовох тохиолдол гарч байсан уу?</p>	<ol style="list-style-type: none"> 1. Үгүй 2. Биеэ их чагнадаг болсон 3. Эрүүл мэндийн байдалдаа санаа зовдог 4. Байнга зовиурлаж, гомдоллодог болсон 5. Өөрийг эрүүл мэндийн талаар бодохгүй байхыг хичээдэг.
<p>14. Таны жин буурсан уу?</p>	<ol style="list-style-type: none"> 1. Үгүй 2. Энэ өвчинтөй холбоотой жин буурч байна 3. Илэрхий жин буурсан 4. Жингээ үзээгүй
<p>15. Ярилцлагын үед өгөх үнэлгээ</p>	<ol style="list-style-type: none"> 1. Ярианы хурд, сэтгэх хурд хэвийн 2. Яриа бага зэрэг удааширан 3. Яриа илэрхий удааширан 4. Ярилцлага хийхэд хүндрэлтэй 5. Ступор
<p>16. Ярилцлагын үед өгөх үнэлгээ</p>	<p>Сэтгэл түгшил</p> <ol style="list-style-type: none"> 1. Тайван 2. Биеэ барьсан 3. Гар хуруугаараа оролдох 4. Ярилцлагын үед босч явах 5. Хуруугаараа толгох, үсээ оролдох, хумсаа мэрэх, хөмхийгөө зуух

17. Ажиглалтын дүнд өгөх үнэлгээ	<p>Ойлголт</p> <ol style="list-style-type: none"> 1. Урьд нь сэтгэл гутралтай байснаа хүлээн зөвшөөрсөн ба одоо хэвийн байдалд орсондоо ойлгосон 2. Сэтгэл гутрал, стэгэл түгшилд хоол хүнс, амралтгүй ажилласан байдал, вирус зэрэг нелөөлсөн гэж үзэх 3. Өөрийгөө сэтгэл гутрал, сэтгэл түгшилд орж байсныг үгүйсгэх
----------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Нийт оноо: _____

1. Хавсралт 2. Сэтгэл гутралыг илрүүлэх Бекийн сорил

Энэ асуултад өнгөрсөн долоо хоногт таны сэтгэл санаа ямар байсныг бодож хариулахаа уу. Бүлэг бүрт буй 4 хариултын зөвхөн нэгийг сонгоорой.

Д/д	Хариулт	Оноо
1	Би уйтгарладаггүй	0
	Би заримдаа уйтгарладаг	1
	Би дандаа уйтгартай байдаг, тайвширч чаддаггүй	2
	Би маш их уйтгартай, аз жаргалгүй учир би үүнийг тэсвэрлэж чадахгүй байна	3
2	Би ирээдүйгээ өчүүхэн ч муугаар боддоггүй, итгэлтэй байдаг	0
	Би ирээдүйдээ сэтгэл зовнидог	1
	Би ирээдүйдээ урагшаа тэмүүлэх зүйл юу ч мэдэрдэггүй	2
	Би ирээдүйдээ итгэлгүй, юу ч дээрдэж чадахгүй гэж боддог	3
3	Би өөрийгөө бүтэлгүй хүн гэж боддоггүй	0
	Надад бусад хүмүүсээс илүү бүтэлгүй зүйл тохиолддог гэж боддог	1
	Би өөрийнхөө амьдралыг эргэж харахад бүтэлгүй зүйл маш их байсан	2
	Би өөрийгөө бүтэлгүй хүн гэж боддог	3
4	Би өөрийнхөө хийж буй зүйлд маш их сэтгэл хангалааун байдаг	0
	Би өөрийнхөө хийж буй зүйлд сэтгэл хангалааун байдаггүй	1
	Би юунаас ч жинхэнэ сэтгэл ханамжийг авч чаддаггүй	2
	Бүх юманд сэтгэл ханамжгүй, уйтгартай, залхмаар байна	3
5	Би өөрийгөө ямар нэгэн юманд өчүүхэн ч буруутай гэж боддоггүй	0
	Би өөрийгөө зарим нэгэн юманд буруутай гэж боддог	1
	Би өөрийгөө ихэнх юманд буруутай гэж боддог	2
	Би өөрийгөө бүх л юманд буруутай гэж боддог	3
6	Би өөрийгөө шийтгэгдэх ёстой гэж боддоггүй	0
	Би өөрийгөө шийтгэгдэх болох юм гэж боддог	1
	Би өөрийгөө шийтгэгдэнэ гэж боддог	2
	Би өөрийгөө шийтгэгдэх байгаа гэж боддог	3
7	Би өөртөө сэтгэл гонсгор байдаггүй	0
	Би өөртөө сэтгэл дундуур байдаг	1
	Би өөрийгөө жигшдэг	2
	Би өөрийгөө үзэн яддаг	3
8	Би өөрийгөө бусдаас мую хүн гэж боддоггүй	0
	Би өөрийнхөө сул тал, алдаандаа шүүмжлэлтэй ханддаг	1
	Би өөрийнхөө бүх алдааг буруушаадаг	2
	Мую юм тохиолдох болгонд өөрийгөө буруушаадаг	3
9	Би өөрийнхөө амийг хорлох тухай боддоггүй	0
	Би өөрийнхөө амийг хорлох тухай боддог ч, би үүнийг хийж чадахгүй	1
	Би амия хорломоор санагддаг	2
	Би боломж олдвол амия хорлоно	3
10	Би урьдынхаасаа илүү уйлаагүй	0
	Би урьдынхаасаа их уйлдаг болж байна	1
	Би сүүлийн үед байнга уйлдаг болоод байна	2
	Би уйлахыг хүсэж байсан ч уйлж чадахгүй байна	3
11	Би урьдынхаасаа илүү уурлаж бухимдахгүй байна	0
	Би урьдынхаасаа илүү уурлаж, бухимддаг болоод байна	1
	Уурлаж бухимдах юм гаралгүй байхад ч би уурлаж бухимдаад байна	2
	Би байнга уурлаж, бухимдаж байна	3
12	Бусад хүмүүсийг сонирхох сонирхол хэвээрээ байна	0
	Бусад хүмүүсийг сонирхох сонирхол бага зэрэг буурсан	1
	Бусад хүмүүсийг сонирхох сонирхол нилээд буурсан	2
	Бусад хүмүүсийг сонирхохоо бүр болисон	3

	Би урьдынх шигээ шийдвэр гаргаж чадаж байна	0
13	Би шийдвэр гаргахаас зайлсхийдэг болоод байна	1
	Урьдынх шигээ шийдвэр гаргахад маш хэцүү болоод байна	2
	Би шийдвэр гаргаж чадахгүй байна	3
	Би өөрийгөө урьдынхаасаа царай муутай болоод байна гэж боддоггүй	0
14	Би царай муутай, хөгшин харагдаж байна гэж санаа зовдог	1
	Миний гадаад төрх эргэшгүйгээр өөрчлөгджэх энэ нь муухай харагдуулдаг	2
	Би муухай харагдаж байна гэдэгтээ итгэлтэй байна	3
	Би урьдынх шигээ сайн ажиллаж чадаж байгаа	0
15	Ямар нэг юм хийж эхлэхэд илүү их чармайлт гаргах болсон	1
	Би ямар нэг юм хийхэд маш их хүч, чармайлт гаргах болсон	2
	Би ямар ч ажил хийж чадахаа болиод байна	3
	Би ердийнх шигээ сайн унтаж чадаж байна	0
16	Би ердийнх шигээ сайн унтаж чадахгүй байна	1
	Би ердийнхөөсөө 1-2 цагийн өмнө сэрээд, эргэн унтахад бэрхшээлтэй байна	2
	Би ердийнхөөсөө хэдэн цагийн өмнө сэрээд эргэн унтахгүй байна	3
	Би урьдынхаасаа илүү ядрахгүй байна	0
17	Би урьдынхаасаа илүү амархан ядардаг болоод байна	1
	Бараг юм хийхгүй байгаа мөртлөө ядардаг болоод байна	2
	Би маш их ядардаг болоод байна	3
	Миний хоолны дуршил сайн байгаа	0
18	Миний хоолны дуршил урьдынхаасаа буурч байна	1
	Миний хоолны дуршил маш муу байна	2
	Би хоол идэх ямар ч хүсэлгүй болсон	3
	Миний биеийн жин хэвийн байгаа	0
19	Би 2 кг-аас илүү турсан	1
	Би 5 кг-аас илүү турсан	2
	Би 7 кг-аас илүү турсан	3
	Би эрүүл мэнддээ санаа зовохгүй байгаа	0
20	Би эрүүл мэнддээ санаа зовж байна. /Надад хodoод гэдэсний зовиур, батга гарах, өтгөн хатах зэрэг асуудал байна/	1
	Би эрүүл мэнддээ маш их санаа зовж байгаа тул өөр юм бодоход хэцүү байна	2
	Би эрүүл мэнддээ маш их санаа зовж байгаа тул өөр юм бодож чадахгүй	3
	Миний бэлгийн дур өөрчлөгдсөн гэж бодохгүй байна	0
21	Миний бэлгийн дур хүсэл урьдахаасаа багассан	1
	Миний бэлгийн дур хүсэл маш бага болсон	2
	Миний бэлгийн дур хүсэл огт байхгүй болсон	3

Үнэлгээ	
1. 0-10 оноо	Сэтгэл гутрал үгүй
2. 11-17 оноо	Хөнгөн сэтгэл гутралтай
3. 18-23 оноо	Дунд зэргийн сэтгэл гутралтай
4. 24-дээш оноотой бол	Гүнзгий сэтгэл гутралтай
Амиа хорлох бодол, хандлага, оролдлого, үйлдэл, зан үйл цухалзсан, илэрсэн л бол нэн даруй бөгөөд заавал сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчилнэ.	

1. World Health Organization. Global Hepatitis Report 2017. Geneva: World Health Organization; April, 2017:1-83.
2. Hsu YC, Huang DQ, Nguyen MH. Global burden of hepatitis B virus: current status, missed opportunities and a call for action. *Nat Rev Gastroenterol Hepatol*. 2023; 20:524-537.
3. Hai-Yan Chen D-TS, Dong-Ze Ji, Pei-Chun Han, Wei-Ming Zhang, Jian-Feng Ma, Wen-Sen Chen, Hemant Goyal, Shiyang Pan, Hua-Guo Xu. Prevalence and burden of hepatitis D virus infection in the global population: a systematic review and meta-analysis. *Gut*. 2019; 68:512-521. doi: 510.1136/gutjnl-2018-316601.
4. Sharafi H, Rezaee-Zavareh MS, Miri SM, Alavian SM. Global Distribution of Hepatitis D Virus Genotypes: A Systematic Review. *Hepat Mon*. 2020; 20:e102268.
5. Rizzetto M. Hepatitis D Virus: Introduction and Epidemiology. *Cold Spring Harb Perspect Med*. 2015; 5.
6. Dambadarjaa D, Radnaa O, Khuyag S-O, Shagdarsuren O-E, Enkhbayar U, Mukhtar Y, Tsogzolbaatar E-O, Nyam G, Shaarii S, Singh P, Takahashi M, Namdag B, Okamoto H. Hepatitis B, C, and D Virus Infection among Population Aged 10–64 Years in Mongolia: Baseline Survey Data of a Nationwide Cancer Cohort Study. *Vaccines*. 2022; 10:1928.
7. Chen X, Oidovsambuu O, Liu P, et al. A novel quantitative microarray antibody capture assay identifies an extremely high hepatitis delta virus prevalence among hepatitis B virus-infected mongolians. *Hepatology*. 2017; 66:1739-1749.
8. Magvan B, Kloeble AA, Ptok J, Hoffmann D, Habermann D, Gantumur A, Paluschinski M, Enebish G, Balz V, Fischer JC, Chimed Dorj B, Walker A, Timm J. Sequence diversity of hepatitis D virus in Mongolia. *Front Med (Lausanne)*. 2023; 10:1108543.
9. Davaalkham D OT, Uehara R, Watanabe M, Oki I, Nymadawa P, Takahashi M, Okamoto H, Nakamura Y. Hepatitis delta virus infection in Mongolia: analyses of geographic distribution, risk factors, and disease severity. *Am J Trop Med Hyg*. 2006; 75:365-369.
10. Tsatsralt-Od B, Takahashi M, Nishizawa T, Inoue J, Ulaankhuu D, Okamoto H. High prevalence of hepatitis B, C and delta virus infections among blood donors in Mongolia. *Arch Virol*. 2005; 150:2513-2528.
11. Fattovich G, Giustina G, Christensen E, Pantalena M, Zagni I, Realdi G, Schalm SW. Influence of hepatitis delta virus infection on morbidity and mortality in compensated cirrhosis type B. The European Concerted Action on Viral Hepatitis (Eurohep). *Gut*. 2000; 46:420-426.
12. Romeo R, Del Ninno E, Rumi M, Russo A, Sangiovanni A, de Franchis R, Ronchi G, Colombo M. A 28-year study of the course of hepatitis Delta infection: a risk factor for cirrhosis and hepatocellular carcinoma. *Gastroenterology*. 2009; 136:1629-1638.
13. Buti M, Homs M, Rodriguez-Frias F, Funalleras G, Jardí R, Sauleda S, Tabernero D, Schaper M, Esteban R. Clinical outcome of acute and chronic hepatitis delta over time: a long-term follow-up study. *J Viral Hepat*. 2011; 18:434-442.

14. Su CW, Huang YH, Huo TI, Shih HH, Sheen IJ, Chen SW, Lee PC, Lee SD, Wu JC. Genotypes and viremia of hepatitis B and D viruses are associated with outcomes of chronic hepatitis D patients. *Gastroenterology*. 2006; 130:1625-1635.
15. Terrault NA, Lok ASF, McMahon BJ, Chang KM, Hwang JP, Jonas MM, Brown RSJ, Bzowej NH, Wong JB. Update on prevention, diagnosis, and treatment of chronic hepatitis B: AASLD 2018 hepatitis B guidance. *Hepatology*. 2018; 67:1560-1599.
16. Sarin SK, Kumar M, Lau GK, et al. Asian-Pacific clinical practice guidelines on the management of hepatitis B: a 2015 update. *Hepatol Int*. 2016; 10:1-98.
17. Brunetto MR, Ricco G, Negro F, Wedemeyer H, Yurdaydin C, Asselah T, Papatheodoridis G, Gheorghe L, Agarwal K, Farci P, Buti M. EASL Clinical Practice Guidelines on hepatitis delta virus. *Journal of Hepatology*. 2023; 79:433-460.
18. WHO. Guidelines for the prevention, care and treatment of persons with chronic hepatitis B infection. WHO, ed. 2016.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АЛАТ	Аланинаминотрансфераз
АСАТ	Аспартатаминотрансфераз
АФП	Альфа-фетопротейн
ГГПТ	Гаммаглутаминтранспептидаз
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ИНФ	Интерферон
КТ	Компьютертомографийн шинжилгээ
ПГУ	Полимеразын гинжин урвал
РВЭ	Ретровирусийн эсрэг
ФХЭБУ	Фермент холбоот эсрэг биесийн урвал
ХДХВ/ДОХ	Хүний Дархлал Хомсдлын Вирус/ Дархлалын Олдмол
Хомсдол	
ЦЕШ	Цусны ерөнхий шинжилгээ
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
APRI	AST-to-platelet ratio index
Anti HBc	ГВВ-ийн цөмийн эсрэгбие
Anti HBs	ГВВ-ийн гадаргуугийн эсрэгбие
Anti HBe	ГВВ-ийн e эсрэгбие
Anti HBc-IgM	ГВВ-ийн цөмийн эсрэгбие - иммуноглобулин M
Anti HDV	ГДВ-ийн эсрэгбие
Anti HDV-IgM	ГДВ-ийн эсрэгбие - иммуноглобулин M
FIB-4	Fibrosis-4 index forliver fibrosis
INR	International normalised ratio
IU/ml	International unit/milliliter олон улсын нэгж
HBsAg	ГВВ-ийн гадаргуугийн эсрэгтөрөгч
HBcAg	ГВВ-ийн цөмийн эсрэгтөрөгч
HBeAg	ГВВ-ийн e эсрэгтөрөгч
HBV-DNA	ГВВ-ийн дезоксирибонуклейн хүчил
HDV RNA	Гепатитын D вирусийн рибонуклейн хүчил

01
Эрүүл мэндийн сайдын 2024 оны
дугаар сарын 11-и өдрийн 11 дугаар
тушаалын наймдугаар хавсралт

**ГЕПАТИТЫН В, С, Д ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ИЛРҮҮЛЭГ,
ЛАБОРАТОРИЙН ОНОШИЛГОО ХИЙХ ЗААВАР**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Өөрх, сумын эрүүл мэндийн төв, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлгийн лабораториуд, төрөлжсөн мэргэжлийн төв, тусгай эмнэлэг, хувийн хэвшлийн лабораториудад хийгдэх гепатитын В, С, Д вирусийн халдвартын илрүүлэг шинжилгээ болон нэмэлт илрүүлэг шинжилгээ, вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээг чанарын өндөр түвшинд хийж, лабораторийн тусламж үйлчилгээг иргэдэд хүндрэл чирэгдэлгүй хүргэхэд энэхүү зааврыг ашиглана.

1.2. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан иргэд илрүүлэг шинжилгээ болон лабораторийн оношилгооны зохих хөнгөлөлтөнд хамрагдана.

1.3. Халдварт илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний хувийн мэдээллийг "Хувь хүний нууцын тухай" Монгол Улсын хуульд заасны дагуу нууцална.

1.4. Өөрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв (ЭМТ) нь олон улсын стандартын чанар, аюулгүй байдлыг хангасан, оношлуурын үнэлгээнд орсон хурдавчилсан оношлуур болон бусад шинжилгээнд шаардлагатай хэрэгслийг ашиглана.

**ХОЁР. ГЕПАТИТЫН В, С, Д ВИРУСИЙН ИЛРҮҮЛЭГ, АЧААЛАЛ ТОДОРХОЙЛОХ
ШИНЖИЛГЭЭНД СОРЬЦ АВАХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад хүндрэлтэй зах хязгаарт амьдарч буй иргэдийг эмнэлэгт олон дахин ирүүлэх чирэгдлийг багасгах, нэмэлт болон баталгаажуулах шинжилгээнд хадгалах сорьцын тогтвортой байдлыг хангах, эмнэлзүйн шийдвэрийг цаг тухайд нь шуурхай гаргахын тулд үйлчлүүлэгчийг анхны удаа ирэхэд нь тусламж үйлчилгээний цэг дээр шинжилгээнд сорьц авахтай зэрэгцэн шинжилгээний хариуг шинжилгээнд хамрагдаж буй хүн эсвэл асран хамгаалагч, эмчлэгч эмчид өгөх замаар тусламж үйлчилгээ үзүүлж болно.

- 2.1 Лабораторид суурилсан "рефлекс" шинжилгээ: Гепатитын В, С, Д вирусийн халдварт илрүүлэг шинжилгээнд анх удаа ирж байгаа үйлчлүүлэгчдээс шинжилгээнд сорьц авахдаа хураагуур судаснаас хоёр хуруу шилэнд цус авна.
- Эхний хуруу шилэн дэх цусанд гепатитын В, С вирусийн халдварт илрүүлэг шинжилгээг түргэвчилсэн аргаар болон ФХЭБҮ-ын аргаар хийнэ;
 - Илрүүлэг шинжилгээгээр гепатитын С вирусийн эсрэгбие илэрвэл тухайн сорьцод эсвэл давхар авсан 2 дахь сорьцод гепатитын С вирусийн ачаалал тодорхойлох (HCV-RNA) шинжилгээ хийнэ;
 - В вирусийн гадаргуугийн эсрэгтөрөгч (HBsAg) илэрвэл гепатитын D вирусийн илрүүлэг болон гепатитын B, D вирусийн ачаалал тодорхойлох (HBV-DNA, HDV-RNA) шинжилгээ 2 дахь сорьцод хийнэ.
 - Өвчтөн болон эмч рүү илгээх лабораторийн шинжилгээний хариунд гепатитын вирусийн халдвартын илрүүлэг болон вирусийн ачааллын шинжилгээний хариу багтсан байна.

2.2 Эмнэлэгт суурилсан “рефлекс” шинжилгээ гэдэг нь үйлчлүүлэгч анхны удаа эмнэлэгт ирэхэд, гепатитын вирусийн халдварт илрүүлэг шинжилгээг түргэвчилсэн аргаар хийж, шинжилгээний хариу зэрэг гарвал тухайн үед цус дахин авах шинжилгээний стратегийг хэлнэ.

- Түргэвчилсэн аргаар гепатитын С вирусийн халдварт илрүүлэг шинжилгээг хийж эсрэгбие илэрвэл HCV RNA тодорхойлох шинжилгээнд зориулан (15 минутын дараа) “рефлекс” буюу цусны дээж хоёр дахь удаа хураагуур судаснаас авна. HCV RNA тодорхойлох шинжилгээг тусламж үйлчилгээний цэг дээр өвчтний хажууд хийж болно, нэг бол хоёр дахь цусны дээжийг лабораторид илгээж болно.
- Түргэвчилсэн оношлуураар гепатит В вирусийн илрүүлэг шинжилгээ хийж гадаргуугийн эсрэгтерөгч (HBsAg) илэрвэл HBV-DNA ачаалал тодорхойлох шинжилгээнд зориулан (15 минутын дараа) “рефлекс” хоёр дахь цусны дээж авна. HBV-DNA тодорхойлох шинжилгээг тусламж үйлчилгээний цэг дээр өвчтний хажууд хийж болно, эсвэл хоёр дахь цусны дээжийг лабораторид илгээж болно.
- Түргэвчилсэн оношлуураар гепатит В вирусийн илрүүлэг шинжилгээ хийж гадаргуугийн эсрэгтерөгч (HBsAg) илэрвэл гепатитын D вирусийн илрүүлэг шинжилгээг ФХЭБҮ аргаар хийнэ, гепатитын D вирусийн эсрэгбие илэрвэл 2 дахь хуруу шилтэй сорьцыг D вирусийн ачаалал тодорхойлох (HDV-RNA) шинжилгээнд илгээнэ.

ГУРАВ. ГЕПАТИТЫН В, С, Д ВИРУСИЙН ИЛРҮҮЛЭГ, ИДЭВХЖИЛ ТОДОРХОЙЛОХ ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛГОРИТМ

3.1. Гепатитын С вирусийн илрүүлэг шинжилгээ: Анхдагч илрүүлэг шинжилгээ нь өрх, сумын Эрүүл мэндийн төвд түргэвчилсэн оношлуураар хийгдэнэ. Гепатитын С вирусийн илрүүлэг шинжилгээний дэслэлийг Зураг 1-д харуулав.

3.2. Гепатитын В вирусийн илрүүлэг шинжилгээ: Анхдагч илрүүлэг шинжилгээ нь өрх, сумын Эрүүл мэндийн төвд түргэвчилсэн оношлуураар HBsAg, anti-HBc, anti-HBs 3 үзүүлэлтээр хийгдэнэ. Гепатитын В ба D вирусийн халдвартын эрт илрүүлгийн дэслэлийг Зураг 2-д харуулав.

3.3. Гепатитын D вирусийн илрүүлэг шинжилгээ: Анхдагч илрүүлэг шинжилгээгээр гепатитын В вирусийн гадаргуугийн эсрэгтөрөгч (HBsAg) зерэг гарсан үйлчлүүлэгчийн 2 дахь сорьцод гепатитын D вирусийн эсрэгбие илрүүлэх шинжилгээг ФХЭБҮ-ийн аргаар аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хийнэ.

3.4. Гепатитын вирусийн халдвартын илрүүлгийн нэмэлт шинжилгээ: Түргэвчилсэн шинжилгээний хариу сул зэрэг, эргэлзээтэй гарвал Фермент холбоот эсрэг биеийн урвал (ФХЭБҮ) эсвэл хемолюминисцент иммуны (ХЛИА-CLIA) аргаар нэмэлт шинжилгээ хийнэ.

- Нэмэлт шинжилгээг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв хариуцан гүйцэтгэнэ.

- Сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс сорьц тээвэрлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв хариуцна.

3.5. Гепатитын В, С, D вирусийн ачаалал (HBV-DNA, HCV-RNA, HDV-RNA) тодорхойлох шинжилгээ: Гепатитын В, С, D вирусийн халдвартын илрүүлэг шинжилгээгээр зерэг гарсан (анти-HCV зерэг, HBsAg зерэг, anti-HDV зерэг) тохиолдолд вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээнд хамруулна.

HBV-DNA, HCV-RNA, HDV-RNA ачаалал тодорхойлох шинжилгээг бодит хугацааны полимеразын гинжин урвал (Бх-ПГУ)-ын аргаар тодорхойлно.

HBV-DNA, HCV-RNA, HDV-RNA ачаалал тодорхойлох шинжилгээг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн болон тусгай эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн лаборатори хариуцан гүйцэтгэнэ.

HBV-DNA, HCV-RNA ачаалал тодорхойлох шинжилгээг бодит хугацааны ПГУ-ын аргаар илрүүлэгийн доод хязгаар нь 20 IU/ml хүртэл хүчин чадалтай тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөц бүхий холбогдох бусад шалгуур үзүүлэлтийг хангасан, лабораторийн чанарын гадаад хяналт үнэлгээнд амжилттай хамрагдаж гэрчилгээ авсан лабораторит олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, эмнэл зүйн оношилгооны гэрчилгээтэй (IVD) оношлуур урвалж ашиглан, стандарт ажиллагааны зааврын дагуу хийнэ.


HDV-RNA ачаалал тодорхойлох шинжилгээг бодит хугацааны ПГУ аргаар зориулалтын лабораторийн байр, тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөц бүхий холбогдох бусад шалгуур үзүүлэлтийг хангасан, лабораторийн чанарын гадаад хяналт үнэлгээнд амжилттай хамрагдаж гэрчилгээ авсан лабораторит, эмнэл зүйн оношилгооны гэрчилгээтэй (IVD) оношлуур урвалж ашиглан, стандарт ажиллагааны зааврын дагуу хийнэ.

HDV-RNA ачаалал тодорхойлох бх-ПГУ шинжилгээний ДЭМБ-аас хүлээн зөвшөөрсөн, стандартчилсан арга одоогоор байхгүй, илрүүлэх доод хязгаарыг тодорхойлон тавих боломжгүй тул лабораториуд өөрийн тоног төхөөрөмжийг ашиглан, IVD, CE гэрчилгээтэй оношлуураар стандарт ажиллагааны зааврын дагуу шинжилгээг гүйцэтгэж чанарын баталгаажилтыг ханган, лаборатори хоорондын харьцуулалт хийх, лабораторийн олон улсын болон үндэсний хяналтын хөтөлбөрүүдэд тогтмол хамрагдаж байх шаардлагатай.

Вирусийн эсрэг эмчилгээний үр дүнгийн хяналтыг тухайн үйлчлүүлэгч нэг лабораторидоо, нэг шинжилгээний аргаар хянуулахыг ДЭМБ-аас зөвлөж байна. (ДЭМБ-ын Гепатит В ба С-ын шинжилгээний удирдамж, Хуудас 71 WHO, Guidelines on Hepatitis B and C, 2017Холбоос: <https://www.who.int/publications/i/item>).

Дараахь үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын баталсан холбогдох журам, зааврыг мөрдлөг болгоно.


1. Шинжилгээнд сорьц авах аргачлал, үйлчлүүлэгчид өгөх зөвлөгөө, өрх сум эрүүл мэндийн төвүүдэд хийгдэх үйл ажиллагаа, аймаг дүүрэг нэгдсэн эмнэлэгт хийгдэх үйл ажиллагаа, хурдавчилсан оношлуураар шинжилгээ хийх заавар болон үнэлэх аргачлал
2. Сорьцыг илгээх, тээвэрлэх
3. "Халдвартай материал оношилгооны сорьц, биобэлдмэл тээвэрлэх
4. "Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар
5. Бусад



Тайлбар:

- Венийн судаснаас ЕДТА К2, гален тусгаарлагчтай хуруу шилэнд цус авч, центрифугдэнэ.
Улмаар 2-8 хэмд 72 цагийн дотор сонгогдсон лабораториид хүргэн шинжилгэнэ.
- 2-8 хэмд 5 хоногоос удаан хугацаагаар хадгалагдсан сорьцыг ачаалал тодорхойлох шинжилгээнд хэрэглэж болохгүй.
- Тусламж үйлчилгээний цаг дээр GeneXpert анализатораар HCV-RNA ачаалал тодорхойлох шинжилгээг хийж болно.

Зураг 1. Гепатитын С вирусийн халдварын илрүүлэг шинжилгээний алгоритм



Зураг 2. Гепатит В ба D вирусийн халдвартын илрүүлэг шинжилгээний алгоритм

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Эрүүл мэндийн яам

А.Өнөржаргал, Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын дарга

А.Баярзаяа, Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын мэргэжилтэн

Ц.Сарантуяа, Дотрын анагаах судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн мэргэжилтэн

Ц.Билэгтсайхан, Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөлийн мэргэжилтэн

Ц.Сэлэнгэ,Халдварт өвчин, тархвар судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн

Зөвлөх

Д.Даваадорж, Монголын гастроэнтерологийн холбооны ерөнхийлөгч

О.Баатархүү, Академич, АШУУИС, Шинжлэх Ухааны Академи

Халдварт өвчин судлалын үндэсний төв

Ж.Байгалмаа, Ерөнхий захирал

Э.Одмаа, Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирал

Ж.Нямурэн, Халдварт өвчний тандалт судалгааны албаны дарга

Д.Бадрал, Вируст гепатитын тандалт судалгааны тасгийн эрхлэгч

Г.Сарангуга, Вируст гепатит энтеровирусийн лабораторийн эрхлэгч

Ч.Мөнхцэцэг, Вируст гепатитын тандалт судалгааны тасаг, тархвар судлаач эмч

Б.Батсүх, Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч

Б.Саруул, Амбулаторийн тасгийн эрхлэгч

Э.Нямбаяр, ХӨТСА-ны тархвар судлаач эмч

Хавдар судлалын үндэсний төв

Т.Ундармаа, Хавдрын бүртгэл тандалт эрт илрүүлгийн албаны дарга

Ч.Мөнхзаяа, Элэг шилжүүлэн суулгах албаны гепатолог эмч

АШУУИС, Анагаах ухааны сургууль, Монгол-Японы эмнэлэг

Ц.Бямбажав, Хоол боловсруулах эрхтэн судлалын тэнхимиийн эрхлэгч

Н.Бира, Хоол боловсруулах эрхтэн судлалын тэнхимиийн профессор

Г.Сарантуяа, Хоол боловсруулах эрхтэн судлалын тэнхимиийн багш

Л.Тулга, Анагаах ухааны хүрээлэнгийн захирал

Улсын нэгдүгээр төв эмнэлэг

О.Баярмаа, Эмчилгээ эрхэлсэн захирал, Гастроэнтерологийн төвийн дарга

Б.Болормаа, Гастроэнтерологийн төвийн хоол боловсруулах эрхтэн судлалын эмч

Г.Анар, Гастроэнтерологийн төвийн хосол боловсруулах эрхтэн судлалын эмч

Н.Одонтунгалааг, Гастроэнтерологийн төвийн хоол боловсруулах эрхтэн судлалын эмч

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Б.Хандмаа, ХБЭСС-ын тасгийн эрхлэгч

Интермед эмнэлэг

Б.Энхжаргал, Тасгийн эрхлэгч, хоол боловсруулах эрхтэн судлалын эмч

Д.Бадамсүрэн, Клиникийн эрхлэгч, хоол боловсруулах эрхтэн судлалын эмч

Төрийн болон төрийн бус байгууллага

Д.Наранжаргал, Монголын элэгний эмч нарын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, Элэгний төвийн захирал

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага,

П.Анузаяа, ДЭМБ-ын мэргэжилтэн

Б.Цолмон, ДЭМБ-ын мэргэжилтэн

ТӨГСӨВ